



ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ХӨГЖЛИЙН ТӨВ



# ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

# 2013

**Энэхүү эмхэтгэлийн талаархи саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.  
Эрүүл мэндийн хөгжлийн төв**

Шуудангийн хаяг: С.Зоригийн гудамж  
Улаанбаатар -210648  
Факс: 976-11-320633  
Утас: 70111485, 325540  
Э-шуудан: admin@chd.moh.mn  
www.chd.moh.mn

Эрхэлсэн: Ч. Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал  
Хянан тохинуулсан: Н.Нарангэрэл, ТССХ-ийн дарга

Эмхтгэсэн: С.Даваажаргал Мэргэжилтэн, ТССХ  
Х.Нарантуяа Мэргэжилтэн, ТССХ  
О.Энхцэцэг Мэргэжилтэн, ТССХ  
П.Энхээ Мэргэжилтэн, ТССХ

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Уранчимэг Оператор, ТССХ  
Д.Алтанцэцэг Оператор, ТССХ

Хэвлэлийн дизайнер: А.Өнөржаргал

**ГАРЧИГ**

<b>Өмнөх үг</b>	<b>5</b>
<b>Хүснэгтийн жагсаалт</b>	<b>6-7</b>
<b>Зургийн жагсаалт</b>	<b>8-9</b>
<b>Товчилсон үгийн жагсаалт</b>	<b>10</b>
<b>Ном зүй</b>	<b>11</b>
<b>Хураангуй</b>	<b>12</b>
<b>Бүлэг 1. Монгол Улсын хүн ам</b>	<b>13</b>
1.1. Хүн ам	14-15
1.2. Хүн ам зүйн үзүүлэлт	15-16
1.3. Хүн амын дундаж наслалт	16-18
<b>Бүлэг 2. Мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтууд</b>	<b>19-24</b>
<b>Бүлэг 3. Эх хүүхдийн эрүүл мэнд</b>	<b>25</b>
3.1. Эхийн эрүүл мэнд	26
3.2. Жирэмсний хяналт ба төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	26-28
3.3. Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	29-31
3.4. Төрсний дараах тусламж, үйлчилгээ	31-34
3.5. Эхийн эндэгдэл	34-36
3.6. Хүүхдийн эрүүл мэнд	36-39
3.7. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	39-41
3.8. Үр хөндөлт	41
3.9. Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ /ЖСАХ/	42
<b>Бүлэг 4. Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>	<b>43</b>
4.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ	44-46
4.2. Сумын эрүүл мэндийн төвийн болон сум, сум дундын эмнэлгийн тусламж, үйлчилгээ	46-48
4.3. Нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ	49-50
4.4. Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн тусламж үйлчилгээ	50-52
4.5. Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвийн тусламж, үйлчилгээ	52-53
4.6. Хувийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	54-55
4.7. Түргэн тусламжийн үйл ажиллагаа	56-58
<b>Бүлэг 5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц</b>	<b>59-62</b>

<b>Бүлэг 6. Халдварт өвчин</b>	<b>63</b>
6.1. Нийт халдварт өвчин	64
6.2. Гэдэсний халдварт өвчин	64-66
6.3. Амьсгалын замын халдварт өвчин	66-70
6.4. Бэлгийн замаар дамжих халдвар	70-71
6.5. Халдварт өвчний нас баралт	71
<b>Бүлэг 7. Халдварт бус өвчин</b>	<b>72</b>
7.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан	73-76
7.2. Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан	77-80
7.3. Мэс заслын үйл ажиллагаа	81-83
<b>Бүлэг 8. Хүн амын нас баралт</b>	<b>84-86</b>
8.1. Зүрх-судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт	86-87
8.2. Хорт хавдрын шалтгаант нас баралт	87-88
8.3. Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан	88-90
<b>Бүлэг 9. Монгол улсын эмийн бүртгэл</b>	<b>91-94</b>
<b>Бүлэг 10. Үндэсний хөтөлбөрүүд</b>	<b>95-102</b>
<b>Бүлэг 11. ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн мэдээний санд орох Монгол улсын үзүүлэлтүүд, 2013</b>	<b>103-106</b>
<b>Бүлэг 12. Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд, /хүснэгтээр/</b>	<b>107-154</b>

## ӨМНӨХ ҮГ

Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ, тайланд тулгуурлан эрүүл мэндийн үзүүлэлтийг өмнөх онуудтай зэрэгцүүлэн харуулсан жилийн эмхэтгэлийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тогтолцооны судалгаа, статистикийн хэлтэс жил бүр гаргадаг билээ. Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын нийтлэг стандарт, хэм хэмжээнд нийцүүлэх, эмхэтгэлийн үзүүлэлтийн хүрээг жил тутам өргөжүүлэх ажлыг хийж байна.

Статистикийн эмхэтгэлийг хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох зорилгоор зарим үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал, нэр томъёоны тайлбарыг тухайн бүлэг бүрийн өмнө оруулсан болно.

Энэ удаагийн эмхэтгэл нь ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн орнуудын эрүүл мэндийн мэдээллийн мэдээний санд нэмж оруулсан Монгол улсын үзүүлэлт, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн шинэчлэгдсэн үзүүлэлт орсон бөгөөд нийт 46 хүснэгт, 54 зураг, газарзүйн байршлын 35 дүрслэлээр баяжуулсан нь онцлог юм.

Монгол улсын хүн амын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдээс эхийн эндэгдлийн түвшин сүүлийн 10 жилийн хугацаанд тогтвортой буурч байгаа бөгөөд 2013 онд 42.6 болж хамгийн бага түвшинд хүрсэн.

Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 оноос хойшхи 20 жилийн хугацаанд эрчимтэй буурч, 2013 онд 1990 онтой харьцуулахад 1000 амьд төрөлтөд ноогдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4,8 дахин, нялхсын эндэгдэл 4,3 дахин багассан байна.

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2013 онд 69.11 болж өмнөх оныхоос 0.4-өөр нэмэгдэж эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.01, эрэгтэйчүүдийнх 65.42 боллоо.

Статистикийн сар, улирал, жилийн мэдээллийг манай вэб хуудас /[www.chd.moh.mn/](http://www.chd.moh.mn/)-д хандан хэрэглэгч Та шаардлагатай мэдээллээ авах боломжтой.

Эрүүл мэндийн үзүүлэлтийн жилийн эмхэтгэл, статистикийн үзүүлэлтийн тухай санал хүсэлтээ манай хаягаар ирүүлбэл бид хүлээн авч хамтран ажиллах болно.

ЗАХИРАЛ  Ч.БАТ-ЭРДЭНЭ

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1.2.1.** Хүн ам зүйн үзүүлэлтүүд, сонгосон онуудаар
- Хүснэгт 1.3.1.** Хүн амын дундаж наслалт, эхний 10 байранд байгаа орны жагсаалтаар
- Хүснэгт 1.3.2.** Хүн амын дундаж наслалт бүсээр, хүйсээр, 2013 он
- Хүснэгт 2.1.** Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар
- Хүснэгт 2.2.** Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар
- Хүснэгт 2.3.** Жирэмсэн эмэгтэйчүүд болон 15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ын тархалт, хувиар
- Хүснэгт 2.4.** Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын түвшин (100 000 хүн амд), сонгосон онуудаар
- Хүснэгт 3.3.1.** Мэс заслын аргаар төрүүлсэн хувь, бүсээр, 2013 он
- Хүснэгт 3.3.2.** Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2013 он
- Хүснэгт 3.3.3.** Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2013 он
- Хүснэгт 3.5.1.** Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, насны ангиллаар, 2013 он
- Хүснэгт 3.6.1.** Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2013 он
- Хүснэгт 3.6.2.** Нярай хүүхдийн өвчлөл, бодит тоогоо, 2013 он
- Хүснэгт 3.6.3.** 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, хувиар (хот, хөдөө), 2013 он
- Хүснэгт 3.6.4.** Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, насны бүлгээр, /10 000 хүн амд/, 2013 он
- Хүснэгт 3.7.1.** Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, нас, хүйсээр, 2013 он
- Хүснэгт 3.7.2.** Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, хувиар /хот, хөдөө/ 2013 он
- Хүснэгт 3.8.1.** Үр хөндөлт, байршлаар, 2013 он
- Хүснэгт 3.9.1.** ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо байршлаар, 2013 он
- Хүснэгт 4.1.** Эрүүл мэндийн байгууллагуудын тоо, 2013 он
- Хүснэгт 4.1.1.** Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2013 он
- Хүснэгт 4.2.1.** Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн их эмчийн хангамжийг стандартын доод хязгаартай харьцуулсан байдал, 2013 он
- Хүснэгт 4.2.2.** Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарын зарим үзүүлэлт, 2011 он, 2013 он
- Хүснэгт 4.3.1.** Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2011-2013 он

- Хүснэгт 4.4.1.** БОЭТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2011-2013 он
- Хүснэгт 4.4.2.** БОЭТ-ийн үйл ажиллагааны зарим үзүүлэлт, 2013 он
- Хүснэгт 4.4.3.** БОЭТ-ийн хүний нөөцийн зарим үзүүлэлт, 2013 он
- Хүснэгт 4.5.1.** Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарын зарим үзүүлэлт, 2011-2013 он
- Хүснэгт 4.5.2.** Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны зарим үр дүнгийн үзүүлэлт, 2013 он
- Хүснэгт 4.6.1.** Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2013 он
- Хүснэгт 4.6.2.** Хувийн ортой эмнэлгүүдийн хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, 2013 он
- Хүснэгт 4.7.1.** Түргэн тусламжийн дуудлага, 2013 он
- Хүснэгт 4.7.2.** Түргэн тусламжийн сүлжээний төвийн алсын дуудлага, 2013 он
- Хүснэгт 6.2.1.** Гэдэсний халдварт өвчин, бодит тоо, 10 000 хүн амд, 2012-2013 он
- Хүснэгт 6.2.2.** Вирүст хепатит, 10 000 хүн амд, улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудаар 2012-2013 он
- Хүснэгт 6.3.1.** Амьсгалын замын халдварт өвчин, бодит тоо, 10 000 хүн амд, 2012-2013 он
- Хүснэгт 6.3.2.** Сүрьеэ өвчин, 10 000 хүн амд /улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудаар, 2012-2013 он/
- Хүснэгт 6.4.1.** Бэлгийн замаар дамжих халдвар, бодит тоо, 10 000 хүн амд, 2012-2013 он
- Хүснэгт 7.1.1.** Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2013 он
- Хүснэгт 7.2.1.** Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2013 он
- Хүснэгт 7.2.2.** Хэвтэн эмчлүүлэгчдийн зонхилон тохиолдох өвчлөл, хувиар, 2003-2013 он
- Хүснэгт 7.2.3.** Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүний тоо, аймгаар, 2013 он
- Хүснэгт 7.3.1.** Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хийгдсэн мэс заслын тоо, 2013 он
- Хүснэгт 7.3.2.** Зонхилон хийгдсэн мэс засал, төрлөөр, 2013 он
- Хүснэгт 8.1.** Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 2013 он
- Хүснэгт 8.1.1.** Шалтгаанаар тооцсон зүрх-судасны тогтолцооны өвчний нас баралтын түвшин, 10 000 хүн амд, насны бүлгээр
- Хүснэгт 8.3.1.** Дэлхийн хүн амын нас баралтын 2030 оны төлөв байдал, Монгол улсын 2013 оны нас баралтын үзүүлэлтийн харьцуулалт

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1.1.1.** 2013 оны хот, хөдөөгийн хүн амын тоо, аймгаар
- Зураг 1.1.2.** 2013 оны дундаж хүн амын тоо, аймгаар
- Зураг 1.1.3.** Хүн амын тоо, жилийн өсөлтийн хувь, сонгосон онуудаар
- Зураг 1.2.1.** Төрөлтийн нийлбэр коэффициент, сүүлийн 5 жилээр
- Зураг 1.2.2.** Төрөлтийн нийлбэр коэффициент, аймгаар, 2013 он
- Зураг 1.3.1.** Нас,хүйсийн суварга, 2000, 2013
- Зураг 2.1.** ХДХВ-ийн халдварын тохиолдол, нас баралт, өссөн дүнгээр 1992-2013 оны байдлаар
- Зураг 3.1.1.** Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, 2003-2013 он
- Зураг 3.2.1.** Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь, аймгаар, 2013 он
- Зураг 3.2.2.** Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, 2013 он
- Зураг 3.3.1.** 1 000 хүн амд ногдох төрөлтийн түвшин, аймгаар 2013 он
- Зураг 3.3.2.** Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь, аймгаар 2013 он
- Зураг 3.3.3.** Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас ирж төрсөн эхчүүд, бодит тоо, 2013 он
- Зураг 3.4.1.** Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн тохиолдол эмнэлгийн байгууллагын төрлөөр, хувиар, 2013 он
- Зураг 3.4.2.** Жирэмсний хүндрэлд манас таталтын эзлэх хувь, аймгаар, 2013 он
- Зураг 3.4.3.** Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын эзлэх хувь, аймгаар, 2013 он
- Зураг 3.4.4.** Төрсний дараах хүндрэлд цус алдалтын эзлэх хувь, 2013 он
- Зураг 3.5.1.** Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, аймгаар, 2013 он
- Зураг 3.5.2.** Эхийн эндэгдэл бүсээр, 100 000 амьд төрөлтөд, 2013 он
- Зураг 3.6.1.** Амьгүй төрөлтийн түвшин 1 000 нийт төрөлтөд, аймгаар, 2013 он
- Зураг 3.6.2.** Нярай хүүхдийн өвчлөл, амьд төрсөн хүүхдэд эзлэх хувиар, аймгаар, 2013 он
- Зураг 4.1.1.** Өрхийн эрүүл мэндийн төвийн амбулаторийн үзлэгийн тоо, сүүлийн 3 жилээр
- Зураг 4.2.1.** Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ногдох эмчийн дундаж тоо, 2013 он
- Зураг 4.2.2.** Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2011-2013 он
- Зураг 4.3.1.** Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2013 он



- Зураг 4.5.1.** Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь, 2013 он
- Зураг 4.6.1.** Оргүй эмнэлгүүд, үйлчилгээний төрөл, хувиар, 2013 он
- Зураг 4.7.1.** Хүлээж авсан алсын дуудлага бодит тоогоор, 2009-2013 он
- Зураг 4.7.2.** Зонхилон тохиолдож буй дуудлага эзлэх хувиар, 2009-2013 он
- Зураг 4.7.3.** Алсын дуудлагаар үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ, 2008-2013 он
- Зураг 5.1.** Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын насны бүтэц, 2013 он
- Зураг 5.2.** 10 000 хүн амд ногдох их эмч, сувилагч, бүсээр, 2013 он
- Зураг 5.3.** Төрийн зардлаар төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний тоо, 2013 он
- Зураг 6.1.1.** 2013 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчний бүтэц
- Зураг 6.2.1.** Вирус хепатит, 10 000 хүн амд, 2003-2013 он
- Зураг 6.3.1.** Сүрьеэгийн өвчлөл, нас баралт, 2003-2013 он
- Зураг 6.3.2.** Сүрьеэгийн өвчний оношийн баталгаажилт хувиар, 2013
- Зураг 6.3.3.** Гахай хавдар өвчний хөдлөл зүй, 10 000 хүн амд, 1996-2013 он
- Зураг 6.3.4.** Гахай хавдар өвчин, улирлаар, 2013 он
- Зураг 6.4.1.** Бэлгийн замаар дамжих халдвар, бодит тоо, 10 000 хүн амд, 2011-2013 он
- Зураг 7.1.1.** Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд, 2003-2013 он
- Зураг 7.1.2.** Чихрийн шижин өвчин, хүйсээр, бүсээр, 10 000 хүн амд, 2013 он
- Зураг 7.1.3.** Цусны даралт ихдэх өвчин, хүйсээр, 10 000 хүн амд, 2013 он
- Зураг 7.3.1.** Мэс заслын тоо, аймгаар, 2013 он
- Зураг 7.3.2.** Цочмог мухар олгойн мэс засал, аймгаар, 2013 он.
- Зураг 7.3.3.** Цөсний замын мэс засал, аймгаар, 2013 он
- Зураг 8.1.** Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд, 2013 он
- Зураг 8.2.1.** Зонхилон тохиолдох хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойшхи амьдарсан хугацаа, хувиар, 2013 он
- Зураг 8.2.2.** Зонхилон тохиолдох хорт хавдрын өвчлөл, анх оношлогдсон I-IV үе шатандаа, 2013 он
- Зураг 8.3.1.** Осол гэмтлийн шалтгаант нас баралтын хэлбэр, хүйсээр, 10 000 хүн амд, 2013 он
- Зураг 8.3.2.** Осол гэмтлийн өвчлөл, нас баралт, 10 000 хүн амд, 2003-2013 он
- Зураг 9.1.** Бүртгэгдсэн эм, бодит тоогоор, 2013 он
- Зураг 9.2.** Бүртгэгдсэн эм, хувиар, 2013 он
- Зураг 9.3.** Бүртгэгдсэн эм, АТС кодоор, 2013 он
- Зураг 9.4.** Улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, улс орнуудаар, 2013 он

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

<b>АУДС</b>	Анагаах ухааны дээд сургууль
<b>АХБ</b>	Азийн хөгжлийн банк
<b>БОЭТ</b>	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
<b>ГССҮТ</b>	Гэмтэл согог судлалын үндэсний төв
<b>ДОХ/БЗДХ</b>	Дархлалын олдмол хомсдол/Бэлгийн замаар дамжих халдвар
<b>ДЭМБ</b>	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
<b>ЖСАХ</b>	Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл
<b>НБЕК</b>	Нас баралтын ерөнхий коэффициент
<b>НЭМГ</b>	Нийслэлийн эрүүл мэндийн газар
<b>ОХУ</b>	Оросын холбооны улс
<b>ӨОУА</b>	Өвчний олон улсын ангилал
<b>ТЕК</b>	Төрөлтийн ерөнхий коэффициент
<b>ТНК</b>	Төрөлтийн нийлбэр коэффициент
<b>УБ</b>	Улаанбаатар
<b>УГТЭ</b>	Улсын гуравдугаар төв эмнэлэг
<b>УНТЭ</b>	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
<b>УХТЭ</b>	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
<b>ХДХВ/ДОХ</b>	Хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол
<b>ХӨСҮТ</b>	Халдварт өвчин судлалын үндэсний төв
<b>ХСҮТ</b>	Хавдар судлалын үндэсний төв
<b>ЭБЭ</b>	Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд
<b>ЭМЯ</b>	Эрүүл мэндийн яам
<b>ЭМБ</b>	Эрүүл мэндийн байгууллага
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв
<b>ЭМШУИС</b>	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
<b>ЭХЭМҮТ</b>	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
<b>АТС</b>	Anatomical therapeutic classification /хүний анатомын бүтцэд суурилсан эмийн ангилал/
<b>DOTS</b>	Directly observed treatment short-course /шууд хяналттай богино хугацааны эмчилгээ/

## НОМ ЗҮЙ

1. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт тооцох аргачлал., Улаанбаатар., 2010.
2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага., Өвчний олон улсын ангилал I боть., 2008.
3. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага., Өвчний олон улсын ангилал II боть., 2008.
4. Монгол улсын үндэсний статистикийн хороо., Монгол улсын статистикийн эмхтгэл., Улаанбаатар., 2010.
5. Монгол улсын үндэсний статистикийн хороо., Монгол улсын статистикийн эмхтгэл., Улаанбаатар., 2011.
6. Монгол улсын үндэсний статистикийн хороо., Монгол улсын статистикийн эмхтгэл., Улаанбаатар., 2012.
7. Нэгдсэн үндэсний байгууллагын, Хүн амын сан, Монгол улсын их сургууль, Хүн амын сургалт судалгааны төв., Эрүүл мэнд, нөхөн үржихүйн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, түүнийг ашиглах гарын авлага, цуврал II., Улаанбаатар., 2013.
8. Халдварт өвчин судлалын үндэсний төв., Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2013 оны тайлан., Улаанбаатар., 2013.
9. Эрүүл мэндийн хөгжлийн төв., Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл I боть., Улаанбаатар., 2013.
10. Эрүүл мэндийн хөгжлийн төв., Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл II боть., Улаанбаатар., 2013.
11. Эрүүл мэндийн хөгжлийн төв., Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл III боть., Улаанбаатар., 2013.
12. Эрүүл мэндийн хөгжлийн төв., Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл IV боть., Улаанбаатар., 2013.
13. Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт., Улаанбаатар., 2009.
14. Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт., Улаанбаатар., 2010.
15. Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт., Улаанбаатар., 2011.
16. Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт., Улаанбаатар., 2012.

## ХУРААНГУЙ

2013 оны “Эрүүл мэндийн үзүүлэлт” нь нийт 12 бүлэг, 31 дэд бүлгээс бүрдэж байгаа ба эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг сүүлийн 10 жилийн байдлаар харьцуулан гаргасан. Монгол улсын хүн ам 2013 оны жилийн эцсийн байдлаар 2 сая 930.3 мянга болж, нийт хүн амын 68.1 хувь нь хот суурин газар, үлдсэн 31.9 хувь нь хөдөө амьдарч байна. Дундаж наслалт 2013 онд 69.11 болж, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.01, эрэгтэйчүүдийнх 65.42 байна.

2013 онд улсын хэмжээнд 79371 эх амаржсан нь 2012 онтой харьцуулахад төрөлт 4897 тохиолдлоор буюу 6.1 хувиар нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд 79780 хүүхэд амьд төрсөн ба 1815 нь хоёр ихэр, 40 нь гурван ихэр хүүхэд байна.

Хүн амын нас баралтын ерөнхий коэффициент 1990 онд 7.9 байсан бол бол 2013 онд уг үзүүлэлт 5.6 болж 1990 онтой харьцуулахад 2.3-аар буурсан байна.

Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд хүүхдийн эндэгдлийг бууруулах, эхийн эрүүл мэндийг сайжруулах, ХДХВ/ДОХ, сүрьеэ өвчинтэй тэмцэх гэсэн эрүүл мэндийн 3 зорилго дэвшүүлсэн байдаг.

Монгол Улсад 1 000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 87.5 байсан бол 2013 онд 18.0 болжээ.

Монгол Улсад эхийн эндэгдлийг бууруулах хоёр удаагийн стратегийг 2001-2010 онуудад хэрэгжүүлснээр 2001-2006 онд эхийн эндэгдэл эрчимтэй буурч 2013 оны байдлаар 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 42.6 байна.

2013 онд төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв-16, бүсийн оношилгоо эмчилгээний төв-5, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг -20, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв -8, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг-6, сум дундын эмнэлэг - 39, сум/тосгоны эрүүл мэндийн төв – 271/19, өрхийн эрүүл мэндийн төв - 228, амаржих газар-3, хилийн цэрэг, төмөр зам, хорихын нэгдсэн эмнэлэг зэрэг бусад эмнэлгүүд-31, хувийн ортой эмнэлэг-197, үүдэн эмнэлэг-822 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Эрүүл мэндийн салбарт 2013 онд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 45.0 мянган ажиллагчид ажиллаж байгаа ба 67.0 хувь нь эмнэлгийн мэргэжилтэн байна.

Үүнээс 10 000 хүн амд ногдох их эмч 30.7, сувилагч/эх баригч 37.8 ногдож байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нас баралтын 16192 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 731 тохиолдлоор буюу 4.3 хувиар буурсан байна. Нийт нас барсан хүний 60.1 хувь нь эрэгтэй, 39.9 хувь эмэгтэй байна. Нийт нас баралтын 3979 тохиолдол буюу 24.6 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 25.9 хувь нь хоног болоогүй нас баралт байна.

2013 онд улсын хэмжээнд 30 төрлийн халдварт өвчний 37320 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 5985 тохиолдлоор буурч өвчлөл 10 000 хүн амд 132.7 байна

10 000 хүн амд ногдох халдварт бус өвчлөл 7091.8 байгаа амьсгалын тогтолцооны өвчин (1339.42), хоол боловсруулах тогтолцооны өвчин (1056.79), шээс бэлгийн тогтолцооны өвчин (773.03), зүрх-судасны тогтолцооны өвчин (848.09), гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэг (578.42) өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд орж байна.

# БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

## ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлэгт Монгол Улсын хүн амын өсөлт, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, дундаж наслалт зэрэг хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн үзүүлэлтийг тусгав.

Мэдээллийн үндсэн эх үүсвэр нь Үндэсний статистикийн хорооны 10 жил тутамд явуулдаг хүн ам, орон сууцны тооллого, хүн амын ердийн болон шилжих хөдөлгөөний жил бүрийн мэдээ, тайлан болно.

**Монгол Улсын хүн амд** Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон гадаадад 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат хүн амыг хамруулна.

**Өрх** гэж нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг ойлгоно. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.

**Хотын хүн амд** Улаанбаатар хот, аймгийн төв, тосгонд оршин суугаа хүн амыг хамруулна.

**Хөдөөгийн хүн амд** сумын төв, хөдөө амьдарч байгаа хүн амыг хамруулна.

**Төрөлтийн хүйсийн харьцаа нь** төрсөн эрэгтэй хүүхдийн тоог төрсөн эмэгтэй хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа юм.

**Төрөлтийн ерөнхий коэффициент нь** 1000 хүнд ногдох тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд түүнийг тооцохдоо амьд төрсөн хүүхдийн тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, промилль-оор илэрхийлнэ.

**Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент нь** тухайн насны бүлгийн 1000 эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлэх бөгөөд тухайн насны бүлэг дэх эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, промилль-оор илэрхийлнэ.

**Төрөлтийн нийлбэр коэффициент нь** нэг эмэгтэйн нөхөн үржихүйн нас (15-49 нас)-ныхаа туршид төрүүлэх нийт хүүхдийн тоог илэрхийлэх бөгөөд насны бүлэг дэх төрөлтийн коэффициентүүдийн нийлбэрийг насны бүлгийн интервалын уртаар үржүүлж, 1000-д хувааж тодорхойлно.

**Нас баралтын ерөнхий коэффициент нь** 1000 хүнд ногдох тухайн жилд нас барсан хүний тоог илэрхийлэх бөгөөд тухайн жилд нас барсан хүний тоог хүн амын тухайн жилийн дундаж тоонд харьцуулж, промилль-оор илэрхийлнэ.

**Ердийн цэвэр өсөлтийг** төрөлт, нас баралтын абсолют зөрүүгээр тодорхойлно.

## БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

### 1.1. Хүн ам


Монгол улсын хүн ам 2013 оны жилийн эцсийн байдлаар 2 сая 930.3 мянга болж, өмнөх оныхоос 62.5 мянган хүн буюу 2.2 хувиар өссөн байна. Нийт хүн амын 68.1 хувь нь хот суурин газар, үлдсэн 31.9 хувь нь хөдөө амьдарч байна. Улаанбаатар хотод 1372.1 мянган хүн буюу нийт хүн амын 46.8 хувь нь оршин сууж байна.

Хүн амын 48.7 хувь нь эрэгтэйчүүд, 51.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 95 байна. Насны бүтцээр авч үзвэл 15 хүртэлх насны хүүхэд 27.4 хувийг, 15- 64 насны хүн ам 68.8 хувийг, 65-аас дээш насны хүн ам 3.8 хувийг тус тус эзэлж байна.


2013 оны байдлаар 794.1 мянган өрх, түүний 64.4 хувь нь хотод, 35.6 хувь нь хөдөөд амьдарч байна. Улаанбаатар хотод 333.4 мянган өрх, хангайн бүсэд 162.3, төвийн бүсэд 140.2, баруун бүсэд 97.8, зүүн бүсэд 60.4 мянган өрх байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 3.7 хүн ногдож байна.

Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 68.1 хувь нь буюу 1 сая 995.7 нь хот, тосгонд амьдарч байгаагийн дотор Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Дорноговь аймгийн хүн амын талаас илүү хувь нь хот тосгонд амьдарч байна.


**Зураг 1.1.1. 2013 оны хот, хөдөөгийн хүн амын тоо, аймгаар**



**Зураг 1.1.2. 2013 оны дундаж хүн амын тоо, аймгаар**



### Зураг 1.1.3. Хүн амын тоо, жилийн өсөлтийн хувь, сонгосон онуудаар



Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлтийн хувь нэмэгдэж 2011 онд 1.74 байсан бол 2013 онд 2.2 болж 0.26 пунктээр нэмэгдсэн байна.

### 1.2 Хүн ам зүйн үзүүлэлтүүд

Өнгөрсөн 10 жилд нийтдээ 615.9 мянган хүүхэд төрсний дотор 2007-2009 онуудад төрөлт өмнөх жилүүдийнхээс тогтвортой нэмэгдэж хүн амын өсөлтөд эерэгээр нөлөөлсөн байна.

Түүнчлэн 1990 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 35.3 байсан бол 2005 онд 17.8 болж 2 дахин буурч хамгийн бага түвшинд хүрсэн бөгөөд 2006 оноос тогтвортой нэмэгдэн 2013 онд 27.5 болсон нь өмнөх оныхоос 1.2 пунктээр өслөө.

Төрсөн хүүхдийн тоо 2013 онд 79.8 мянгад хүрч өмнөх оныхоос 8.0 хувиар өсчээ. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд 106 хөвгүүн ногдож байна.


#### Хүснэгт 1.2.1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
<b>Нийт хүн (мян)</b>	<b>2149.2</b>	<b>2407.5</b>	<b>2562.3</b>	<b>2594.8</b>	<b>2626.6</b>	<b>2683.5</b>	<b>2735.5</b>	<b>2780.7</b>	<b>2811.6</b>	<b>2867.7</b>	<b>2930.3</b>
Хотын хүн ам (хувиар)	54.6	57.2	60.2	60.9	61.0	61.4	62.6	63.3	67.1	67.2	68.1
Хөдөөгийн хүн ам (хувиар)	45.4	42.8	39.8	39.1	39.8	38.6	37.4	36.7	32.9	32.8	31.9
<b>Насны бүлгээр (хувиар)</b>											
0-15	41.5	33.7	32.6	28.6	28.9	28.1	27.6	27.3	27.2	27.6	27.4
15-64	54.4	62.8	63.9	67.3	67.3	67.8	68.4	68.8	68.8	68.4	68.8
65 аас дээш	4.1	3.5	3.5	4.1	4.1	4.1	4.0	3.9	4.0	4.0	3.8
<b>Хүн ам зүйн коэффициентууд</b>											
ТЕК	35.3	21.5	17.8	18.4	21.7	23.7	25.3	23.8	25.3	26.3	27.5
НБЕК	7.9	5.9	6.1	6.1	6.2	5.7	5.7	6.3	6.2	5.9	5.6
Цэвэр өсөлт	2.7	1.5	1.17	1.23	1.55	1.8	1.9	1.7	1.9	2.0	2.2
ТНК	4.3	2.2	1.9	1.9	2.3	2.6	2.8	2.4	2.6	2.7	3.0




Хүн амын нас баралтын ерөнхий коэффициент 1990 онд 7.9 байсан бол 2013 онд уг үзүүлэлт 5.6 болж 1990 онтой харьцуулахад 2.3-аар буурсан үзүүлэлттэй байна.

**Зураг 1.2.1. Төрөлтийн нийлбэр коэффициент, сүүлийн 5 жилээр**



Төрөлтийн нийлбэр коэффициент 1990 онд 4.3 байсан бол 2000-2003 онд 2 дахин буурч, 2010 онд 2.4, 2013 онд 3.0 болон нэмэгдсэн байна. Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент нь 2013 оны байдлаар 25-29 насны 1000 эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхэд 167.3 байгаа нь хамгийн өндөр байна.

**Зураг 1.2.2. Төрөлтийн нийлбэр коэффициент, аймгаар, 2013 он**



### 1.3 Хүн амын дундаж наслалт

Хүн амын дундаж наслалт 2013 онд 69.11 болж өмнөх оныхоос 0.4-өөр нэмэгдсэн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.01, эрэгтэйчүүдийнх 65.42 боллоо. Дундаж наслалтын хувьд хүйсийн ялгаа аль ч улс оронд байдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 4 насаар илүү амьдардаг байна. Манай улсын хувьд эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс 9.6 жилээр илүү байна.

2013 оны байдлаар дэлхийн улс орнуудын хүн амын дундаж наслалтаас харахад Монака улс 89.63 жил байгаа хамгийн өндөр буюу Чад улс 49.07 жил байгаа хамгийн бага дундаж наслалттай байна. Монгол улс 157-рт бичигдсэн байна.



**Хүснэгт 1.3.1. Хүн амын дундаж наслалт, эхний 10 байранд байгаа орны жагсаалтаар**

Жагсаалт	Улс/хот	Дундаж наслалт	Мэдээлэл тавигдсан хугацаа
1	Монако/Monaco	89.63	2013 он
2	Макао/Macau	84.46	2013 он
3	Япон/Japan	84.19	2013 он
4	Сингапур/Singapore	84.07	2013 он
5	Сан-Марино/San-Marino	83.12	2013 он
6	Андора/Andorra	82.58	2013 он
7	Guernsey	82.32	2013 он
8	Switzerland	82.28	2013 он
9	Хонгконг/Hongkong	82.20	2013 он
10	Австрали/Australia	81.98	2013 он

<http://www.infoplease.com/world/statistics/life-expectancy-country.html>


2013 оны байдлаар дундаж наслалт аймаг, бүсүүдээр ялгаатай байгаа ба Хангайн бүсийн хүн амын дундаж наслалт хамгийн бага буюу 69.0, Төвийн бүсийн хүн амын дундаж наслалт хамгийн өндөр буюу 70.9 байна. Аймгуудаар харуулбал Хөвсгөл /65.25/, Увс /67.72/, Дорнод /67.84/, Дархан-Уул /67.94/, Говь-Алтай /68.27/, Баянхонгор /68.32/, Завхан /68.62/, Өвөрхангай /68.75/ зэрэг аймгууд дундаж наслалтаараа улсын дундаж үзүүлэлтээс доогуур байна.

**Хүснэгт 1.3.2. Хүн амын дундаж наслалт бүсээр, хүйсээр, 2013 он**

Аймаг, хот	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Баруун бүс</b>			
Баян-Өлгий	72.16	68.89	74.50
Говь-Алтай	68.27	63.47	71.70
Завхан	68.62	66.23	71.20
Увс	67.72	62.93	71.58
Ховд	71.12	67.72	74.90
<b>Хангайн бүс</b>			
Архангай	69.95	67.48	71.45
Баянхонгор	68.32	64.99	70.05
Булган	71.70	67.14	74.69
Өвөрхангай	68.75	66.18	71.53
Хөвсгөл	65.25	62.25	69.92
Орхон	70.25	69.27	79.53
<b>Төвийн бүс</b>			
Говьсүмбэр	72.26	70.85	74.75
Дархан-Уул	67.94	63.69	72.61
Дорноговь	69.59	64.99	74.69
Дундговь	72.61	69.58	77.20
Өмнөговь	70.85	67.11	74.09
Сэлэнгэ	71.27	67.06	76.43
Төв	71.46	69.23	74.34
<b>Зүүн бүс</b>			
Дорнод	67.84	63.94	72.12
Сүхбаатар	71.19	66.35	75.05
Хэнтий	70.35	67.68	73.79
<b>Улаанбаатар</b>			
Улаанбаатар	70.65	65.51	74.02

2000 болон 2013 оны хүн амын нас, хүйсийн суваргыг абсолют тоогоор дүрслэн харуулж байна. Дээрх хүн амын нас, хүйсийн суваргыг харахад 2000 онд харьцангуй пирамид хэлбэртэй байхад 2013 оны суварга нь дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь идэр насны хүн амын хувь нэмэгдэж байгааг харуулж байна.

**Зураг 1.3.1. Нас хүйсийн суварга, /2000, 2013/**



Суваргаас харахад 2013 онд 0-4 насны хүн амын тоо хамгийн өндөр, 20-29 насны хүн ам харьцангуй их байгаа нь хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж хүн ам зүйн цонхны үе үргэлжлэхийг харуулж байна.

## БҮЛЭГ 2. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗОРИЛТУУД

### ТОДОРХОЙЛОЛТ

МХЗ-ууд нь Монгол Улсын бодлогын түвшинд тусгалаа олсон. Монгол Улсын Их Хурал (УИХ)-аас МХЗ-уудыг хөгжлийн харьцуулах үзүүлэлт болгон 2005 онд баталсан бөгөөд МХЗ-д суурилсан 2008-2021 оны Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ)-ын суурь болгон ашигласан. “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” есдүгээр зорилгыг шинээр нэмж тодорхойлсон цөөн орны нэг нь Монгол Улс бөгөөд ардчилсан засаглал, хүний эрхэд онцгой анхаарал хандуулснаар бусад МХЗ-уудыг хангахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх юм.

Монгол Улсад 1 000 амьд төрөлтөд ногдох **тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл** 1990 онд 87.5 байсан бол 2013 онд 18.0 болжээ. Монгол Улс 2013 оны байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 4 дахин бууруулах зорилгыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

**Эхийн эндэгдлийн түвшин** 1996 онд 100 000 амьд төрөлтөд 176.0 байсан бол 2007 онд 89.6 болж буурсан байна. 1997-2000 онд эхийн эндэгдлийн түвшин тогтвортой буурахгүй нэлээд хэлбэлзэлтэй байсан бол 2001-2006 онд эрчимтэй буурч, 2007-2010 онд хэлбэлзэлтэй байсан хэдий ч ерөнхийдөө буурах хандлагатай байжээ. Монгол Улсад эхийн эндэгдлийн түвшин 1990-ээд онд нэлээд өндөр байсан бөгөөд эхийн эндэгдлийг бууруулах хоёр удаагийн стратегийг 2001-2010 онуудад хэрэгжүүлснээр 2001-2006 онд эхийн эндэгдэл эрчимтэй буурсан.

Монгол Улсын Засгийн газраас Эхийн эндэгдлийг бууруулах стратегийн хамрах хүрээг өргөжүүлж, “Эх, хүүхдийн эрүүл мэндийн стратеги (2011-2015)”-ийг батлан, хэрэгжүүлж байна. Уг стратеги нь эхийн эндэгдлийг бууруулах зорилтод 2015 он гэхэд хүрэх үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэж байна.

Монгол Улс **ХДХВ-ийн тархалт** багатай орон юм. 2013 оны эцсийн байдлаар Монгол Улсад ХДХВ-ийн халдвар насанд хүрэгчдийн дунд 0.1 хувиас бага тархсан бөгөөд ХДХВ-ийн халдвартай 150 хүн байна. Гэвч ХДХВ-ийн халдвартай тохиолдлын тоо, ялангуяа эрсдэлтэй бүлэг болох ЭБЭ-ийн дунд өссөөр байна.

**Сүрьеэгийн тархалт** 1996 онд 100 000 хүн амд 146, 2013 онд 142 байгаа нь сүрьеэгийн тархалт буурахгүй байгааг илэрхийлж байна.

## БҮЛЭГ 2. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗОРИЛТУУД

Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд хүүхдийн эндэгдлийг бууруулах, эхийн эрүүл мэндийг сайжруулах, ХДХВ/ДОХ, сүрьеэ өвчинтэй тэмцэх гэсэн эрүүл мэндийн 3 зорилго, дэвшүүлсэн байдаг.

### Зорилго 4. Хүүхдийн эндэгдлийг бууруулах

Дэвшүүлсэн зорилт	Шалгуур үзүүлэлт
<b>Зорилт 9.</b> Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах	4.1 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин / 1000 амьд төрөлт тутамд / 4.2 Нялхсын эндэгдлийн түвшин / 1000 амьд төрөлт тутамд / 4.3 Улаан бурхны эсрэг вакцинжуулалтад хамрагдсан хүүхдийн хувь

### Зорилго 5. Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах

Дэвшүүлсэн зорилт	Шалгуур үзүүлэлт
<b>Зорилт 10.</b> Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах.	5.1 Эхийн эндэгдлийн түвшин /100.000 амьд төрөлт тутамд / 5.2 Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь

**Зорилго 6.** Бэлгийн замын халдварт өвчин, хүний дархлал хомсдлын вирус, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах

Дэвшүүлсэн зорилт	Шалгуур үзүүлэлт
<b>Зорилт 11.</b> 2015 он гэхэд Хүний дархлал хомсдолын вирус / ХДХВ /, Дархлалын олдмол хомсдол /ДОХ /өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх.	6.1 Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундахь ХДХВ-ын халдварын тархалт / хувь /
	6.2 15-24 насны залуучуудын дундахь ХДХВ –ын халдварын тархалт / хувь /
<b>Зорилт 12.</b> 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах	6.3 Сүрьеэ өвчний тархалт /100.000 хүн тутамд/
	6.4 Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /100.000 хүн тутамд/
	6.5 Сүрьеэгээс шалтгаасан нас баралт /100.000 хүн тутамд/
	6.6 Оношлогоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж, эмчилсэн тохиолдлын хувь

## Зорилт 9.Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах

Монгол Улсын засгийн газраас нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулахад онцгой анхаарч 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулахаар зорилт дэвшүүлсэн.

1990 онд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 87.5, нялхсын эндэгдлийн түвшин 63.4 байсан бол 2007 онд энэ үзүүлэлт 22.1 болон 17.8 болж 2015 онд хүрэхээр тавьсан зорилтоо хангасан тул 2008 онд Засгийн Газраас хүрсэн амжилтаа бататгахын тулд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 21.0, нялхсын эндэгдлийг 15.0-д хүргэх шинэ зорилтуудыг дэвшүүлсэн юм.

### Хүснэгт 2.1. Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2015
<b>Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/</b>											
<b>Хүйс</b>											
Эрэгтэй	-	-	22.1	19.2	22.4	22.6	21.3	17.5	17.1	16.0	
Эмэгтэй	-	-	17.3	16.4	16.6	17.6	17.3	15.1	13.4	13.1	
<b>Улсын дундаж</b>	<b>63.4</b>	<b>31.2</b>	<b>19.8</b>	<b>17.8</b>	<b>19.6</b>	<b>20.2</b>	<b>19.4</b>	<b>16.3</b>	<b>15.3</b>	<b>14.6</b>	<b>22.0a/15.0b</b>
УБ хот	70.3	32.8	19.0	14.7	17.5	18.0	16.1	13.3	13.1	13.6	-
<b>Аймгийн дундаж</b>	<b>62.5</b>	<b>30.8</b>	<b>20.3</b>	<b>20.3</b>	<b>21.2</b>	<b>21.9</b>	<b>22.1</b>	<b>19.2</b>	<b>17.5</b>	<b>15.7</b>	-
<b>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/</b>											
<b>Хүйс</b>											
Эрэгтэй	-	-	26.8	23.3	26.4	25.9	26.4	21.9	20.8	22.6	
Эмэгтэй	-	-	21.1	20.8	20.2	21.2	22.7	18.0	16.5	16.9	
<b>Улсын дундаж</b>	<b>87.5</b>	<b>42.4</b>	<b>24.0</b>	<b>22.1</b>	<b>23.4</b>	<b>23.6</b>	<b>24.6</b>	<b>20.0</b>	<b>18.7</b>	<b>18.0</b>	<b>29.2a/21.0b</b>
УБ хот	99.9	42.4	21.8	18.8	20.8	21.0	20.6	16.2	16.0	16.3	-
<b>Аймгийн дундаж</b>	<b>94.4</b>	<b>42.5</b>	<b>25.6</b>	<b>24.6</b>	<b>25.3</b>	<b>25.7</b>	<b>28.0</b>	<b>23.5</b>	<b>21.3</b>	<b>19.7</b>	-

**Эх үүсвэр:** а. УИХ-ын тогтоол #15 Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2005  
б. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

2013 оны байдлаар нялхсын эндэгдлийн 1166 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 14.6 болсон байна. Энэ нь 2000 онтой харьцуулахад 2.1 дахин, 2008 онтой харьцуулахад 1.3 дахин буурсан байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1438 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 18.0 байгаа нь 2000 онтой харьцуулахад 2.4 дахин буурсан байна.

Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 оноос хойшхи 20 жилийн хугацаанд эрчимтэй буурч байгаагийн илрэл нь 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2013 онд 1990 оны түвшинтэй харьцуулахад 4.8 дахин ба нялхсын эндэгдэл 4.3 дахин тус тус буурснаас харагдаж байна.

## Зорилт 10. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд дөрөв дахин бууруулах

Монгол улс эхийн эндэгдлийн түвшингээр бүсийн болон өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад дунд зэргийн оронд багтдаг билээ. Эхийн эндэгдлийг тогтвортой бууруулах талаар засгийн газраас ихээхэн анхаардаг төдийгүй энэ талаар хэрэгжүүлдэг хөтөлбөр, төсөл, тушаал журмууд амжилттай хэрэгжсээр байна. Манай улс эхийн эндэгдлийн түвшинг 1996 оны үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглаж, 2015 он гэхэд эхийн эндэгдлийг  $\frac{3}{4}$ -аар бууруулах буюу 100 000 амьд төрөлтөд 50 болгох зорилтыг дэвшүүлсэн. 2012 онд “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний дөрөв дэх хөтөлбөр батлагдлаа.

### Хүснэгт 2.2. Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар

Үзүүлэлт	1996	2000	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2015
Улсын дундаж	176.0	158.5	69.7	89.6	49.0	81.4	45.5	48.2	50.8	42.6	50.0 <sup>a</sup>
УБ хот	97.7	171.1	71.8	73.7	55.2	78.9	46.2	44.2	43.0	52.3	-
Аймгийн дундаж	200.7	153.4	68.2	102.0	44.3	83.5	44.9	51.8	58.6	32.8	-

Эх үүсвэр: а.УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

Сүүлийн 10 жилийн хугацаанд эхийн эндэгдлийн түвшин 2010 онд 100 000 амьд төрөлтөд 45.5 хүрсэн бөгөөд 2013 онд 42.6 болж хамгийн бага түвшинд хүрсэн байна.

## Зорилт 11. 2015 он гэхэд ХДХВ/ДОХ өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх

Монгол улсын нийт хүн амын дунд Хүний дархлал хомсдолын вирусийн халдварын тархалтын түвшин 0.1 хувиас бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд 5.0 хувиас бага байгаа нь нийт хүн амын дунд бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд төвлөрсөн тархалттай орны тоонд орж байна. 1992 онд Монгол улсад ХДХВ/ДОХ-ын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2013 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 150 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 23 тохиолдол нь 2013 онд шинээр бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 150 тохиолдлын 19 нь нас барсан байна. Нийт тохиолдлын 121 нь (80.7%) эрэгтэйчүүд, 28 нь (18.7%) эмэгтэйчүүд, хүйс тодорхойгүй 1 байна.


Бүртгэгдсэн тохиолдлуудад ХДХВ-ийн халдвар зонхилон бэлгийн замаар дамжсан байна. Цус цусан бүтээгдэхүүн, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тохиолдол, мөн эхээс хүүхдэд халдвар дамжсан тохиолдол бүртгэгдээгүй байна. Нийт 150 тохиолдлын 86.0% Улаанбаатар хотоос оношлогдсон бол, 13.3% хөдөө орон нутгаас, 0.7% тодорхойгүй байна.

### Хүснэгт 2.3. Жирэмсэн эмэгтэйчүүд болон 15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ын тархалт, хувиар

Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2015
Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах ХДХВ-ын халдварын тархалт	-	-	0.004	0.001	0.0	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1 <sup>a</sup>
15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ын халдварын тархалт	-	-		0.007	0.0005	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1

Эх үүсвэр: а.УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

### Зураг 2.1. ХДХВ-ийн халдварын тохиолдол, нас баралт, өссөн дүнгээр (1992-2013 оны байдлаар)



Эх үүсвэр: ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ тандалтын алба

2013 онд бүртгэгдсэн ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 19 буюу (82.6 хувь) эрэгтэйчүүд, 4 нь (17.4 хувь) эмэгтэйчүүд байна.

Насны бүлгээр авч үзвэл: 20-24 насанд 1 тохиолдол, 25-39 насны өсвөр, идэр насны залуучууд 18 тохиолдол, 40-өөс дээш насанд 4 тохиолдол бүртгэгдсэн байна. 43.4 хувь буюу 10 тохиолдол нь гэр бүлгүй хүмүүсийн дунд бүртгэгдсэн байна.

2013 онд шинээр нийт 23 тохиолдол бүртгэгдсэнээс 4 нь (17.4%) идэвхтэй тандалтаар, 9 нь (39.1%) эрүүл мэндийн байгууллагаас, 10 нь (43.4%) урьдчилан сэргийлэх болон сайн дураараа үйлчлүүлэгчдийн дунд илэрсэн байна.

## Зорилт 12. 2015 онд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах

Дэлхийн бусад улс орнуудын адил Монгол улс 1996 оноос шууд хяналттай богино хугацааны эмчилгээний стратеги (ДОТС)-ийг нэвтрүүлснээр сүрьеэгийн шинээр илэрсэн тохиолдол 1996 оноос хойш тасралтгүй нэмэгдэж 2007 оноос буурах хандлага ажиглагдаж байгаа хэдий ч 2015 онд дэвшүүлсэн зорилтыг хангахад хангалтгүй байгаа юм. 2015 он гэхэд 100 000 хүн амд ногдох сүрьеэгийн тархалтыг 82, өвчлөлийг 100, нас баралтыг 2.0 хүртэл бууруулах, ДОТС-ийн хүрээнд эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувийг 100-д хүргэх зорилтууд дэвшүүлсэн.

100 000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшин 1996 онд 146.0 байсан бол 2006 онд 186 болж 1.3 дахин нэмэгдсэн байна. Харин 2007 оноос эхлэн өвчлөл буурч 100 000 хүн амд ногдох түвшин 168 байсан бол 2011 онд 143 болж бууран 2013 оны байдлаар 142 болсон байна.

2013 онд сүрьеэгийн нас баралтын түвшин 100 000 хүн амд 2.0 байгаа нь 1996 оны түвшинтэй харьцуулахад 2.5 дахин буурч 2015 оны зорилтын түвшинд хүрсэн байна.

### Хүснэгт 2.4. Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын түвшин (100 000 хүн амд), сонгосон онуудаар

Үзүүлэлт	1996	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2015
<b>Сүрьеэгийн өвчлөлийн түвшин*</b>										
Улсын дундаж	146	186	168	160	157	154	143	139	142	100.0a
УБ хот	189	248	217	205	199	189	174	170	179	-
Аймгийн дундаж	122	149	145	140	131	136	126	119	110	-
<b>Сүрьеэгийн нас баралтын түвшин*</b>										
Улсын дундаж	4.9	2.9	2.5	2.7	2.8	3.3	2.2	2.1	2.0	2.0a
УБ хот	4.1	3.3	2.3	3.2	2.7	4.4	2.4	2.2	2.4	-
Аймгийн дундаж	2.4	2.5	2.6	2.4	2.9	2.5	1.9	2.0	1.7	-
<b>ДОТС-ын хүрээнд эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь*</b>										
Улсын дундаж	100/66.2	100/82.1	100/83.8	100/85.0	100/82.4	100/84.5	100/83.0	100/82.7	100/80.1	100.0a
УБ хот	100/62.7	100/78.0	100/84.2	100/86.4	100/80.7	100/81.7	100/79.8	100/78.0	100/76.0	-
Аймгийн дундаж	100/68.5	100/87.1	100/88.0	100/87.2	100/87.8	100/87.5	100/87.3	100/89.2	100/84.7	-

Эх үүсвэр: а.УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

2013 оны байдлаар сүрьеэгийн шинэ тохиолдол 4 111, уушгины түрхэц эерэг шинэ сүрьеэ 1 622 бүртгэгдсэн байгаа нь урд оны мөн үетэй харьцуулахад сүрьеэгийн шинэ тохиолдол 167 тохиолдлоор буюу 4.1 хувиар нэмэгдэж, уушгины түрхэц эерэг шинэ сүрьеэ 94 тохиолдлоор буюу 5.7 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн сүрьеэгийн шинэ тохиолдлын 57.3 хувийг уушгины сүрьеэ, 42.7 хувийг уушгины бус эрхтний сүрьеэ эзлэж байна.

Хүүхдийн сүрьеэгийн 402 тохиолдол бүртгэгдсэн нь сүрьеэгийн нийт шинэ тохиолдлын дотор 9.7%-ийг эзэлж урьд оны мөн үетэй харьцуулахад 12.6 хувиар нэмэгдсэн байна.

Шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлыг насаар нь авч үзвэл 16-44 насныхан 68.7 хувийг эзлэж байгаа нь залуу хөдөлмөрийн насны хүмүүс илүүтэй өвчилж байна. Хүйсний хувьд эрэгтэйчүүд 55.4 хувь, эмэгтэйчүүд 44.6 хувийг тус тус эзлэж байна.

2013 оны байдлаар оношийн баталгаажилт 71.5 хувь, эдгэрэлтийн түвшин 80.1 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад оношийн баталгаажилт 4 хувиар, эдгэрэлтийн түвшин 2.6 хувиар тус тус буурсан байна.

\*2010 онд хүн амын тооллоготой холбоотойгоор урд онуудын дундаж хүн амын тоо засварлагдсан болно.



## БҮЛЭГ 3. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

### ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлэгт жирэмсэн, төрөхийн өмнөх, төрөх, төрсний дараах үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, эхийн эндэгдэл, хүүхдийн эрүүл мэнд, нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийн шалтгаан, үр хөндөлт, жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ, эх хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг бүс нутгаар харьцуулан тусгалаа.

Үндэсний хэмжээнд эх, хүүхдийн эндэгдэл буурч байгаа хэдий ч зарим бүс нутаг, аймгуудад эх, хүүхдийн эндэгдлийн түвшин өндөр байгаа. Үүнд алслагдсан байдал; тусламж, үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдал; шилжилт хөдөлгөөнтэй холбоотой ядуу, эмзэг бүлгийн эмэгтэйчүүд, хүүхдүүд эмнэлгийн тусламжийг хожимдож авах нь нөлөөлж байна.

**Амьд төрөлт:** Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойшхи хугацаанд 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нэг нь илэрч байвал амьд төрөлтөд тооцно.

**Амьгүй ураг (амьгүй төрөлт)** Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойшхи хугацаанд 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нэг нь илрэхгүй байвал амьгүй төрөлтөд тооцно. Уг үзүүлэлт нь жирэмсэн болон төрөх үед үзүүлж буй тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх, нялхсын эндэгдлийн мэдээний чанарыг шалгаж, үнэлгээ өгөхөд хэрэглэдэг үзүүлэлт юм.

**Перинаталь эндэгдэл:** Жирэмсний бүтэн 22 долоо хоногоос эхэлж төрсний дараах бүтэн 7 хоног дуусах хүртэлх хугацааг перинаталь үе гэх ба энэ үед ургийн жин 500 грамм байна. Перинаталь эндэгдлийн түвшин нь жирэмсэн, төрөх үеийн болон төрсний дараах үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг харуулдаг үзүүлэлт юм. Мөн эхийн эрүүл мэнд, хоол тэжээлийн байдал болон эхийн амьдарч буй нөхцөлийг илэрхийлдэг.

**Эхийн эндэгдэл:** Жирэмсний хугацаанд буюу төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар нас барахыг эхийн эндэгдэлд хамруулна. Харин золгүй тохиолдлын шалтгаантай нас баралтыг эхийн эндэгдэлд тооцохгүй.


**Нялхсын эндэгдэл:** Тайлангийн жилд эндсэн нэг хүртэлх насны хүүхдийн тоог 1 000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт юм. Уг үзүүлэлтийг байршил, хүйсээр тооцон гаргасан ба нялхсын эндэгдлийн олон жилийн хандлагыг тодорхойлох, эх хүүхдэд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх, өндөр эрсдэлтэй газар зүйн бүс нутаг, хүн амын бүлгийг тогтооход хэрэглэдэг.

## БҮЛЭГ 3. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

### 3.1. Эхийн эрүүл мэнд

Монгол Улсын Засгийн Газраас хүн амын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогыг тодорхойлсон бөгөөд 2012 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн Засгийн газрын 61 дүгээр тогтоолоор “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” Үндэсний дөрөв дэх хөтөлбөрийг баталлаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2012-2016 онуудад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих замаар монгол хүний хөгжлийг хангах таатай орчныг бүрдүүлэх юм.

Зураг 3.1.1. Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, 2003-2013 он



100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл өмнөх 10 жилтэй харьцуулахад 2013 онд 42.6 болж хамгийн бага түвшинд хүрсэн байна.


### 3.2. Жирэмсний хяналт ба төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ

2013 оны байдлаар улсын хэмжээнд 84399 жирэмсэн эмэгтэйчүүд шинээр хяналтад хамрагдсан бөгөөд 87.8 хувь нь жирэмсний эрт үедээ буюу эхний 3 сартайдаа, 11.4 хувь нь 4-6 сартайдаа, 0.8 хувь нь хожуу буюу 7 ба түүнээс дээш сартайдаа хяналтад хамрагджээ.

Жирэмсний эрт үеийн хяналтыг хот, хөдөөгөөр авч үзвэл хотод жирэмсэн эмэгтэйчүүдийн 86.4 хувь нь, хөдөө орон нутагт 89.1 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтад хамрагдсан ба өмнөх онтой харьцуулахад хотод 0.2 хувиар, хөдөө орон нутагт 0.4 хувиар өссөн байна.

Шинээр хяналтад орсон нийт жирэмсэн эхчүүдийн 4.8 хувь нь цус багадалттай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2.3 хувиар буурсан байна. Баян-Өлгий /20.4/, Дорнод /14.9/, Дархан-Уул /13.3/, Орхон /8.8/ аймгуудад улсын дунджаас 1.5-4.2 дахин өндөр, Төв /2.6/, Говьсүмбэр /2.2/, Хэнтий /2.1/, Дундговь /0.9/ байгаа нь улсын дунджаас 1.8-5.3 дахин бага байна.

### Зураг 3.2.1. Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь, аймгаар, 2013 он



Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд 95.7 хувь хамрагдсанаас 2.0 хувьд нь тэмбүү өвчин илэрсэн ба энэ үзүүлэлт Улаанбаатар /2.3/, Сэлэнгэ /2.4/, Дорнод /2.5/, Сүхбаатар /2.6/, Хөвсгөл /2.8/, Орхон /2.9/ хувь байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 0.3-0.9 хувиар өндөр байна.

Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 88.8 хувь нь хамрагдсан нь өмнөх оноос 1.2 пунктаар буурсан байна. Шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 0.7 хувьд нь заг хүйтэн өвчин илэрчээ. Баян-Өлгий /1.5/, Баянхонгор /2.2/, Сэлэнгэ /2.8/, Сүхбаатар /3.6/, Говь-Алтай /3.8/, Дорнод /5.7/ хувийг тус тус эзэлж байгаа нь улсын дунджаас 0.8-5.0 хувиар өндөр байна.

Трихомониаз илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 89.7 хувь нь хамрагдсанаас 1.8 хувьд нь эерэг үзүүлэлттэй байна. Булган /2.0/, Орхон /2.3/, Сэлэнгэ /2.6/, Хэнтий /2.9/, Архангай /3.2/, Дорноговь /4.5/, Сүхбаатар /5.2/, Баянхонгор /6.9/, Дорнод /8.4/ хувийг тус тус эзэлж байгаа нь улсын дүнгээс 0.2-6.6 хувиар өндөр үзүүлэлттэй байна.


Хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 75.6 хувь нь рентген шинжилгээнд хамрагдаж идэвхтэй сүрьеэгийн 260 тохиолдол буюу 0.4 хувьд эерэг гарсан байна.

2013 онд улсын хэмжээнд 341 эхчүүдийн амрах байр ажиллаж байгаагаас 264 нь сумын эрүүл мэндийн төвд, сум дундын эмнэлэгт 37, аймгийн нэгдсэн эмнэлэгт 19, тосгоны

эрүүл мэндийн төвд 9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт 5, БОЭТ-д 5, Улаанбаатар хотын эмнэлэгт 2 тус тус ажилласан байна.

Эхчүүдийн амрах байрны 32.0 хувь нь зориулалтын байранд байгаа ба 67.7 хувь нь эмнэлэг дотор байрлаж нийт 78 051 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.1 байна. Энэ онд шинээр эхчүүдийн амрах байр 3 баригдаж, 38 байранд засвар үйлчилгээ, 50 байранд тохижилт хийгдсэн байна. Эхчүүдийн амрах байранд амарвал зохих эхчүүдийн 74.1 хувь нь амрах байраар үйлчлүүлсэн байна.

**Зураг 3.2.2. Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, 2013 он**




2013 онд нийт төрсөн эхчүүдийн 91.8 хувь нь жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа үзүүлж хяналтад хамрагдсан байна.

### 3.3. Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ

2013 онд улсын хэмжээнд 79 371 эх амаржсан нь өмнөх онтой харьцуулахад 4 897 төрөлтөөр буюу 6.1 хувиар нэмэгдсэн байна. 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин Төв /14.4/, Сэлэнгэ /18.7/, Булган /18.8/, Сүхбаатар /23.1/, Увс /27.0/ аймгуудад буурч, харин Улаанбаатар /29.9/, Ховд /30.2/, Баян-Өлгий /30.2/, Орхон /31.2/, Говьсүмбэр /32.9/ зэрэг аймгууд улсын дунджаас 2.7-5.4 промилль-оор өндөр байна.


Зураг 3.3.1. 1 000 хүн амд ногдох төрөлтийн түвшин, аймгаар, 2013 он



Төрөлтийн тусгай коэффициентийг тооцоход 2013 онд нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутмын 95 нь хүүхэд төрүүлсэн байна. Нийт төрөлтийн 45.9 хувь нь Улаанбаатар хотод, 29.5 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 12.3 хувь нь Бүсийн оношлогоо эмчилгээний төвд, 7.8 хувь нь сум, сум дунд, тосгон, ортой их эмчийн салбарт, 2.2 хувь нь хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт, 2.0 хувь нь хувийн эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвд 0.3 хувь нь гэртээ төрсөн байна.

Төрсөн эхчүүдээс анхны төрөлт 36.9 хувь, 1 жилийн зайтай төрсөн эх 6.5 хувь, 2 жилийн зайтай төрсөн эх 14.7 хувь, 3 ба түүнээс дээш жилийн зайтай төрсөн эх 41.9 хувь байна. Нийт төрөлтийн 3.6 хувийг их эмч, 91.3 хувийн эх барих эмэгтэйчүүдийн эмч, 4.3 хувийг эх баригч бага эмч удирдан явуулсан байна. Нийт төрөлтөд 35-аас дээш насны төрөлт 13.4 хувь, 20 хүртэлх насны төрөлт 5.5 хувийг эзэлж байна.

Зураг 3.3.2. Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь, аймгаар, 2013 он



ДЭМБ-ын зөвлөснөөр нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрүүлж болно гэж үздэг. Манай улсын хувьд 2013 оны улсын дүн харьцангуй өндөр буюу 23.7 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна. Мэс заслын аргаар төрсөн эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 2093 тохиолдлоор буюу 11.1 хувиар өссөн байна. Мэс заслын аргаар төрлөгийг шийдсэн хувь баруун бүсэд аймгийн дунджаас 3.3, хангайн бүсэд 0.2 пунктээр бага, харин төвийн болон зүүн бүсэд 2.2-2.9 пунктээр их байна.


### Хүснэгт 3.3.1 Мэс заслын аргаар төрүүлсэн хувь, бүсээр, 2013 он

	Төрсөн эх	Мэс заслын аргаар төрсөн эхийн тоо	Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь
Баруун бүс	10018	1501	15.0
Төвийн бүс	10248	2098	20.5
Хангайн бүс	14399	2601	18.1
Зүүн бүс	4800	1019	21.2
<b>Аймгийн дүн</b>	<b>39465</b>	<b>7219</b>	<b>18.3</b>
Улаанбаатар	39906	11592	29.0
<b>Улсын дүн</b>	<b>79371</b>	<b>18811</b>	<b>23.7</b>

Гэрийн төрөлтийн нийт 287 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 55 тохиолдлоор буюу 19.1 хувиар нэмэгдсэн байна. Гэрийн төрөлтийн 61.6 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн ба өмнөх оноос 3.9 пунктээр буурсан байна.

Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хөдөө орон нутгаас 5 842 эх ирж амаржсан нь өмнөх оноос 736 төрөлтөөр нэмэгдсэн ба Улаанбаатар хотод бүртгэгдсэн төрөлтийн 14.6 хувийг эзэлж байна.

### Зураг 3.3.3. Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас ирж төрсөн эхчүүд, бодит тоо, 2013 он



**Хүснэгт 3.3.2 Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2013 он**

Аймаг, хот	Нийт төрөлт	Үүнээс гэртээ	БОЭТ	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт	Сум ЭМТ, сум дундын эмнэлэгт	Тосгоны эрүүл мэндийн төв	Их эмчийн ортой салбар	УБ хотын амаржих газар болон ЭХЭМҮТ-д	Хувийн эмнэлэгт	ХӨСҮТ
Архангай	2101	2	0	1509	0	589	0	1	0	0	0
Баян-Өлгий	2783	5	0	2125	0	653	0	0	0	0	0
Баянхонгор	2308	9	0	1936	0	356	7	0	0	0	0
Булган	1023	6	0	764	0	232	21	0	0	0	0
Говь-Алтай	1376	5	0	1195	0	171	1	4	0	0	0
Говьсүмбэр	478	1	0	477	0	0	0	0	0	0	0
Дархан-Уул	2680	9	0	2618	0	53	0	0	0	0	0
Дорноговь	1502	5	0	1226	234	37	0	0	0	0	0
Дорнод	1972	7	1881	0	0	84	0	0	0	0	0
Дундговь	890	3	0	715	0	172	0	0	0	0	0
Завхан	1501	1	0	901	374	225	0	0	0	0	0
Орхон	2891	7	2878	0	0	6	0	0	0	0	0
Өвөрхангай	2779	6	1882	0	287	566	0	2	0	36	0
Өмнөговь	1536	6	1280	0	0	250	0	0	0	0	0
Сүхбаатар	1217	4	0	1119	0	94	0	0	0	0	0
Сэлэнгэ	1924	4	0	1018	662	203	37	0	0	0	0
Төв	1238	2	0	873	0	363	0	0	0	0	0
Увс	1994	17	0	1482	0	495	0	0	0	0	0
Ховд	2364	2	1843	0	211	308	0	0	0	0	0
Хөвсгөл	3297	2	0	2386	0	909	0	0	0	0	0
Хэнтий	1611	7	0	1237	170	195	1	1	0	0	0
<b>Аймгийн дүн</b>	<b>39465</b>	<b>110</b>	<b>9764</b>	<b>21581</b>	<b>1938</b>	<b>5961</b>	<b>67</b>	<b>8</b>	<b>0</b>	<b>36</b>	<b>0</b>
Улаанбаатар	39906	177	0	1786	0	0	3	0	36359	1568	13
<b>Улсын дүн</b>	<b>79371</b>	<b>287</b>	<b>9764</b>	<b>23367</b>	<b>1938</b>	<b>5961</b>	<b>70</b>	<b>8</b>	<b>36359</b>	<b>1604</b>	<b>13</b>

**Хүснэгт 3.3.3. Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2013 он**

Насны бүлэг	Тухайн насны эмэгтэйчүүдийн тоо	Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоо	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент
15-19	124782	4380	35.1
20-24	143337	24983	174.2
25-29	144435	24166	167.3
30-34	124350	15523	124.8
35-39	114948	8758	76.1
40-44	102032	1901	18.6
45-49	92061	57	0.6

Төрөлтийн нийлбэр коэффициент 3.0 байгаа ба 20-24 насны 1000 эмэгтэй тутмын 174 нь, 25-29 насны 1 000 эмэгтэй тутмын 167 нь хүүхэд төрүүлж байгаа нь насны бүлэг дотроо өндөр үзүүлэлттэй байна.

**3.4. Төрсний дараах тусламж, үйлчилгээ**

2013 оны байдлаар төрсөн эхчүүдийн 83.4 хувь нь төрсний дараа 42 хоногтойдоо идэвхтэй хяналтад хамрагдсан ба өмнөх онтой харьцуулахад 6 пунктээр буурсан байна. Энэ үзүүлэлт төрсний дараах хүндрэл болон эхийн эндэгдэл буурахад чухал ач холбогдолтой билээ.

Нийт төрсөн эхчүүдийн 13.7 хувь нь жирэмсэн байх үедээ ямар нэгэн хавсарсан өвчнөөр өвдсөн ба өмнөх онтой харьцуулахад 8 пунктээр буурсан байна.



Өвчлөлийг шалтнаанаар харуулахад:


- Шээс бэлгийн тогтолцооны өвчин, 39.6 хувь
- Зүрх-судасны тогтолцооны өвчин, 16.8 хувь
- Хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин, 12.8 хувь
- Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин, 8.0 хувь
- Бусад 22.8 хувийг тус тус эзэлж байна.

Мөн 2013 оны байдлаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн 61131 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 766.2 ногдож байна.

**Нийт тохиолдлоос:**

- Жирэмсэн үеийн хүндрэл, 35.6 хувь
- Төрөх үеийн хүндрэл, 50.6 хувь
- Төрсний дараах үеийн хүндрэл, 3.4 хувь
- Жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл, 10.4 хувийг тус тус эзэлж байна.

**Зураг 3.4.1. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн тохиолдол эмнэлгийн байгууллагын төрлөөр, хувиар, 2013 он**




2013 онд төрөлхийн тэмбүүгийн нийт 26 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 14, Дорнод аймагт 4, Орхон, Өвөрхангай аймгуудад тус бүр 3, Баян-Өлгий, Хэнтий аймгуудад тус бүр 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах БЗДХ болон төрөлх тэмбүүгийн тохиолдол нэмэгдэж байгаа нь тэмбүү өвчнийг эрт оношлох, эмчлэх журмын дагуу тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах хэрэгтэйг харуулж байна.




**Зураг 3.4.2. Жирэмсний хүндрэлд манас таталтын эзлэх хувь, аймгаар, 2013 он**



Жирэмсний хүндрэлд манас таталтын эзлэх хувь Дундговь /100/, Архангай /96.9/, Төв /94.9/, Баян-Өлгий /80.4/ байгаа нь улсын дунджаас 1.8-2.2 дахин өндөр, Баянхонгор /10.5/, Өмнөговь /27.4/ аймгуудад 1.6-4.3 дахин бага байна.


Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс манас таталтын урьтал 44.6 хувь, манас таталт 0.2 хувь, төрөх үеийн хүндрэлээс төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулралт 41.8 хувь, төрсний дараах үеийн цус алдалт 81.3 хувьтай тэргүүлж байна.

**Зураг 3.4.3. Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын эзлэх хувь, аймгаар, 2013 он**



Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын хувь Говьсүмбэр /69.8/, Говь-Алтай /67.9/, Ховд /67.0/, Дархан-Уул /66.2/, Архангай /66.0/ байгаа нь улсын дунджаас 1.5-1.6 дахин өндөр байна.

**Зураг 3.4.4. Төрсний дараах хүндрэлд цус алдалтын эзлэх хувь, аймгаар, 2013 он**




**3.5. Эхийн эндэгдэл**

Мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтод эхийн эндэгдлийг 2015 онд 1990 оны түвшингээс 75 хувиар бууруулахаар заасан. Ази-Номхон далайн баруун эргийн бүсийн орнуудад жилд дунджаар 40-50 сая жирэмслэлт бүртгэгдэж, жирэмслэлт, төрөх, төрсний дараах үедээ 30 500-50 000 эх эндэж, 300 000 нярай амьдралын эхний 0-6 хоногтоо эндэж байна. Манай улсад эхийн эндэгдэл 1990 оны түвшингээс бараг 4.7 дахин буурч, эхийн эндэгдэл өндөр орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд хүрээд байна.

2013 оны байдлаар эхийн эндэгдлийн 34 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 42.6 байна. 2012 оноос эхийн эндэгдэл 4 тохиолдлоор буюу 10.5 хувиар 100 000 амьд төрөлт тутамд 8.2 эндэгдлээр буурсан байна. Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий зэрэг аймгуудад эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. Эхийн эндэгдлийн 73.5 хувь нь эмнэлэгт, 26.5 хувь нь гэртээ эндсэн байна.

**Зураг 3.5.1. Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, аймгаар, 2013 он**



Эндсэн эхчүүдийг боловсролоор нь авч үзвэл: 3 хувь нь боловсролгүй, 5.9 хувь нь бага, 64.7 хувь нь дунд, 5.9 хувь нь мэргэжлийн болон техникийн, 20.5 хувь нь дээд боловсролтой байжээ. Түүнчлэн 26.4 хувь нь ажил эрхэлдэг, 14.7 хувь нь малчин, 11.7 хувь нь оюутан, 47.2 хувь нь ажил эрхэлдэггүй байсан байна.

Эхийн эндэгдлийг эмнэлгийн төрлөөр нь авч үзвэл 38.2 хувь нь төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд, 20.5 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 17.6 хувь нь Улаанбаатар хотын амаржих газруудад, 11.7 хувь нь сум, сум дундын эмнэлэгт, 5.8 хувь нь Бүсийн оношлогоо, эмчилгээний төвд, 6.2 хувь нь Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төвд эндсэн байна.


Эндсэн эхчүүдийн 29.4 хувь нь жирэмсэн үеийн хүндрэл, 5.8 хувь нь төрөх үеийн хүндрэл, 29.4 хувь нь төрсний дараах хүндрэл, 35.2 хувь нь жирэмсэн болон төрөхөөс бусад өвчний улмаас эндсэн байна. Энэ үзүүлэлтээс харахад өмнөх оны мөн үеэс төрөх үеийн хүндрэл 0.6, төрсний дараах хүндрэл 5.7 хувиар өсч, жирэмсэн үеийн хүндрэл 2.2, жирэмсэн болон төрөхөөс бусад өвчний хүндрэл 4.3 хувиар тус тус буурсан байна.

### Хүснэгт 3.5.1. Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, насны ангиллаар, 2013 он

Насны бүлэг	Эндсэн эхийн тоо	Эзлэх хувь	Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоо	Тухайн насны бүлгийн 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин
15-19	1	2.9	4380	22.8
20-24	8	23.5	24983	32.0
25-29	9	26.4	24166	37.2
30-34	6	17.6	15523	38.6
35-39	7	20.5	8758	79.9
40-44	3	9.1	1901	157.8

Эхийн эндэгдлийн түвшин 35-39 насанд 79.9, 40-44 насанд 157.8 байгаа нь улсын дунджаас 37.3-115.2 промилль-оор өндөр байна.

**Зураг 3.5.2. Эхийн эндэгдэл бүсээр, 100 000 амьд төрөлтөд, 2013 он**



Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд бүс нутгаар авч үзвэл Улаанбаатар хот болон баруун бүсэд улсын дунджаас 9.7-27.2 промиль-оор их, харин төвийн болон хангайн бүсэд улсын дунджаас 13.5-22.2 промиль-оор буурсан, зүүн бүсэд эхийн эндэгдэл бүртгэгдээгүй байна.

2013 онд баруун бүсэд эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд 69.8 болж өмнөх оны түвшнээс 5.3 промиль-оор, Улаанбаатар хотод эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд 52.3 болж, өмнөх оны түвшнээс 9.3 промиль-оор тус тус нэмэгдсэн байна.

### 3.6. Хүүхдийн эрүүл мэнд

Шинээр төрсөн хүүхдийг нярай үед нь буюу төрсний дараах нэг сар хүртэлх хугацаанд нь хамрагдвал зохих эрүүл мэнд нийгмийн үйлчилгээнд хамруулснаар амьдрах боломжийг нэмэгдүүлж, хэвийн өсөлт хөгжилтэй, эрүүл саруул өсөх үндэс болдог.


2013 оны байдлаар төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 93.3 байна. Энэ үзүүлэлт Архангай, Өвөрхангай, Сүхбаатар аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 6.8-3.5 хувиар доогуур үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 3.6.1 Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2013 он**

Бүсээр	Төрсөн хүүхэд			Хүйсийн харьцаа /100-д/	Нийт төрөлтөд	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бага жинтэй хүүхдийн эзлэх хувь	Амьгүй төрөлтийн түвшин /1000 төрөлтөд /
Баруун бүс	10032	5195	4837	107.4	4.3	8.5
Төвийн бүс	10294	5387	4907	109.8	3.4	6.8
Хангайн бүс	14444	7343	7101	103.4	4.0	4.9
Зүүн бүс	4823	2458	2365	103.9	2.9	4.3
<b>Аймгийн дүн</b>	<b>39593</b>	<b>20383</b>	<b>19210</b>	<b>106.1</b>	<b>3.9</b>	<b>6.9</b>
Улаанбаатар	40187	20683	19504	106.0	4.7	6.5
<b>Улсын дүн</b>	<b>79780</b>	<b>41066</b>	<b>38714</b>	<b>106.1</b>	<b>4.2</b>	<b>6.7</b>

Улсын хэмжээнд 79780 хүүхэд амьд төрсөн нь өмнөх онтой харьцуулахад 5002 хүүхдээр буюу 6.2 хувиар нэмэгдсэн байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 4.2 хувь нь 2500 граммаас доош жинтэй төржээ. Амьд төрсөн хүүхдийн 1815 нь хоёр ихэр, 40 нь гурван ихэр хүүхэд байна. Амьгүй төрөлтийн 539 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 32 тохиолдлоор буюу 5.9 хувиар нэмэгдсэн.


**Зураг 3.6.1. Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд), аймгаар, 2013 он**



Амьгүй төрөлтийн түвшин Баян-Өлгий аймагт 17.8 байгаа нь улсын дунджаас 11.1 промилль-оор өндөр байна. Зүүн болон төвийн бүсэд амьгүй төрөлтийн түвшин улс, аймгийн дунджаас доогуур үзүүлэлтэй байна. Хангайн бүсээс Баянхонгор /8.1/, Орхон /7.8/ байгаа нь улс, аймгийн дунджаас 1.1-1.4 промилль-оор өндөр байна. Амьгүй төрөлтөд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь 51.7 байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 106.0 байна.

2013 онд нэг хүртэлх насны хүүхдийн идэвхитэй хяналтын хувь 99.6, тав хүртэлх насны хүүхдийн идэвхитэй хяналтын хувь 96.1 байна. Нярай хүүхдийн өвчлөлийн 11 688 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь амьд төрсөн хүүхдийн 14.6 хувийг эзэлж байна.

**Зураг 3.6.2. Нярай хүүхдийн өвчлөл, амьд төрсөн хүүхдэд эзлэх хувиар, аймгаар, 2013 он**



**Хүснэгт 3.6.2. Нярай хүүхдийн өвчлөл, бодит тоогоор, 2013 он**




	Нярай хүүхдийн өвчлөл бүгд	Перинаталь үед үүссэн зарим эмгэг	Халдварт ба шимэгчит өвчин		Амьсгалын тогтолцооны өвчин		Хоол шингээх эрхтний эмгэг		Төрөлхийн гажиг, гаж хөгжил	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант эмгэг	Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан	Бусад өвчин
			Бүгд	Үүнээс: Төрөлхийн тэмбүү	Бүгд	Үүнээс: Уушгины хатгаа	Бүгд	Үүнээс: Халдварт бус суулгалт өвчин				
Аймгийн дүн	4808	3834	12	12	340	115	58	46	215	7	1	335
Улаанбаатар	6880	6333	12	12	80	33	28	6	380	5	0	25
<b>Улсын дүн</b>	<b>11688</b>	<b>10167</b>	<b>24</b>	<b>24</b>	<b>420</b>	<b>148</b>	<b>86</b>	<b>52</b>	<b>595</b>	<b>12</b>	<b>1</b>	<b>360</b>

Перинаталь үед үүссэн зарим эмгэг дотор ургийн бүтэлт 17.9 хувь, нярайн шарлалт 20.8 хувийг эзэлж байна.

Нэг хүртэлх насны хүүхдэд бүртгэгдсэн төрөлхийн гажгийн 865 тохиолдлоос хоол боловсруулах тогтолцооны төрөлхийн гажиг 30.6 хувь, зүрхний төрөлхийн гажиг 25 хувь, түнхний төрөлхийн гажиг 16.6 хувийг эзэлж тэргүүлэх шалтгаан болж байна.

**Хүснэгт 3.6.3 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, хувиар (хот, хөдөө), 2013 он**




	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	64.5	65.2	58.7	65.5
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	10.2	12.7	7.9	13.1
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	6.1	3.2	3.3	1.7
Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан	3.1	1.1	10.9	3.3
Халдварт ба шимэгчит зарим өвчин	1.3	0.4	3.6	1.9
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	5.4	3.7	11.5	5.3
Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	1.7	5.1	1.4	4.1

	Тэргүүлэх шалтгаан
	Хоёрдугаар шалтгаан
	Гуравдугаар шалтгаан

Тав хүртэлх насны хүүхдийн өвчлөлөөс хот, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчин зонхилох шалтгаан болж байна. Амьсгалын тогтолцооны өвчлөлөөс уушгины хатгалгаа 24.3 хувь, томуу, томуу төст өвчлөл 18.1 хувь, цочмог амьсгуурстас 13.7 хувийг тус тус эзэлж байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн 62.3 хувийг халдварт бус суулгалт өвчин эзэлж байна.

### Хүснэгт 3.6.4. Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, насны бүлгээр, 10 000-д, 2013 он

	1-4 нас	5-9 нас	10-14 нас	15-19 нас
Амьсгалын тогтолцооны өвчин	4825.7	1360.5	989.7	653.7
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	815.9	754.6	665.3	690.0
Халдварт ба шимэгчт зарим өвчин	214.5	186.3	126.4	154.6
Гэмтэл хордлого, гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	553.9	365.5	467.6	533.7
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	103.2	118.0	193.2	447.5
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	655.3	371.6	382.8	499.6

	Тэргүүлэх шалтгаан
	Хоёрдугаар шалтгаан
	Гуравдугаар шалтгаан

Өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны болон гэмтэл хордлого, гадны шалтгаант бусад тодорхой эмгэг, арьс арьсан доорх эслэгийн өвчлөл, шээс бэлгийн тогтолцооны өвчлөлүүд тэргүүлэх 5 шалтгаан болж байна.

Жилээс жилд гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг өсвөр үеийнхний дунд нэмэгдэж, 2013 онд 10-14 болон 15-19 насны хүүхдийн осол гэмтлийн өвчлөл өмнөх оноос тухайн насны 10 000 хүүхэд тутамд 66.9-84.6 өвчлөлөөр тус тус нэмэгдсэн байна.

Тухайн насны 10 000 хүүхдэд ногдох 1-4 насны хүүхдийн өвчлөлд халдварт бус суулгалт 417.3, шүдний цооролт 146.9, шүд ба дайврын эмгэг 113.5 байгаа нь тэргүүлэх шалтгаан болж байна. Харин 5-9 насны хүүхдийн өвчлөлд тухайн насны 10 000 хүүхдэд шүдний цооролт өвчин 229.6, шүд ба дайврын эмгэгийн өвчин 297.3 байгаа нь тэргүүлэх шалтгаан болж байна.

### 3.7. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Мянганы хөгжлийн зорилтод 1 000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг 2015 он гэхэд 15.0, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 21.0 болгохоор дэвшүүлсэн. 2013 оны байдлаар улсын хэмжээнд нялхсын эндэгдэл 1 166 тохиолдол бүртгэгдэж, 1 000 амьд төрөлтөд 14.6 ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 000 амьд төрөлтөд 0.7 промил-оор буурсан байна.

Нялхсын эндэгдлийн 66.1 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 9.7 байна. Нярайн эндэгдлийн нийт 771 тохиолдол бүртгэгдсэний 614 буюу 79.6 хувь нь нярайн эрт үед /амьдралын эхний 0-6 хоногт/, 157 буюу 20.4 хувь нь нярайн хожуу үед /амьдралын эхний 7-28 хоногт/ эндсэн байна. Нялхсын эндэгдлийн 56.4 хувь нь эрэгтэй, 43.6 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Нялхсын эндэгдлийн түвшин Говь-Алтай /25.2/, Хөвсгөл /23.1/, Архангай /18.4/, Баянхонгор /18.1/, Хэнтий /18.0/, Завхан /17.9/, Булган /17.6/, Увс /17.0/, Сүхбаатар /15.5/ аймгуудад улс, аймгийн дундаж үзүүлэлтээс 0.9-10.6 промил-оор өндөр байна.



Харин тав хүртэлх насандаа 1438 хүүхэд эндсэн бөгөөд амьд төрсөн 1000 хүүхэд ногдох түвшин 18.0 байна. Өнгөрсөн онтой харьцуулахад бодит тоогоор 42 тохиолдлоор нэмэгдсэн боловч амьд төрсөн 1000 хүүхэдэд 0.7 промилль-оор буурсан үзүүлэлттэй байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 55.8 хувь эрэгтэй, 44.2 хувь нь эмэгтэй хүүхэд байна. 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Говь-Алтай /30.3/, Хөвсгөл /28.8/, Баян-Өлгий /23.9/, Хэнтий /23.5/, Архангай /22.7/, Дорноговь /21.9/, Завхан /21.2/, Сүхбаатар /21.2/, Баянхонгор /20.7/, Булган /20.5/, Увс /20.0/ аймгуудад улс, аймгийн дундаж үзүүлэлтээс 2.0-12.3 промилль-оор өндөр байна.

Нялхсын эндэгдлийн шалтгаанд перинаталь үед үүссэн зарим эмгэг 52.6 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 15.7 хувь, төрөлхийн гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг 15.1 хувь байгаа нь эхний тэргүүлэх шалтгаан болж байна. Нялхсын эндэгдлийн шалтгааныг өмнөх онтой харьцуулахад перинаталь үеийн эмгэгийн улмаас эндсэн эндэгдэл 2.2 пунктээр, амьсгалын тогтолцооны өвчин 2.1 пунктээр буурч, төрөлхийн гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг 2.9 пунктээр нэмэгдсэн байна.

**Зураг 3.7.1. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл нас, хүйсээр, 2013 он**

	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Нярайн эрт үеийн эндэгдэл	345	269	614
Нярайн хожуу үеийн эндэгдэл	92	65	157
Нялхсын эндэгдэл	658	508	1166
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	803	635	1438
Амьд төрсөн хүүхдийн тоо	41066	38714	79780

Нялхсын эндэгдэлд хот болон хөдөөд адил перинаталь үед үүссэн эндэгдэл тэргүүлэх шалтгаан болж байна.

**Хүснэгт 3.7.2. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, хувиар, (хот, хөдөө), 2013 он**

	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	10.1	20.6	10.5	20.2
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	3.3	2.3	3.2	2.7
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	58.2	48.2	48.4	38.3
Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг	17.8	12.7	16.3	11.3
Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан	5.1	8.4	13.2	15.6

Тэргүүлэх шалтгаан  
 Хоёрдугаар шалтгаан  
 Гуравдугаар шалтгаан



Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 93.1 хувь нь өвчнөөр, 6.9 хувь нь гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад эмгэгийн улмаас эндсэн бөгөөд 83.4 хувь нь эмнэлэгт, 14.6 хувь нь гэртээ, 2 хувь нь бусад газар эндсэн байна.

### 3.8. Үр хөндөлт

2013 оны байдлаар үр хөндөлтийн 15 628 тохиолдол бүртгэгдэж, 1 000 амьд төрөлтөд 195.0, нөхөн үржихүйн насны 1 000 эмэгтэйд 18.4 үр хөндөлт ногдож байна. Үр хөндөлт өмнөх оноос 2 845 тохиолдлоор буюу 18.2 хувиар, 1000 амьд төрөлтөд 51.3 промилль-оор буурсан байна. 1 000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлт Өмнөговь /216.3/, Дорноговь /235.9/, Өвөрхангай /320.5/, Орхон /513.5/ зэрэг аймгууд болон Улаанбаатар хотод /258.4/ байгаа нь улсын дунджаас 20.5-317.7 промилль-оор өндөр байна. Мөн хувийн эмнэлгээр хийгдсэн үр хөндөлт өмнөх оноос 5 488 тохиолдлоор буюу 2.6 дахин буурсан байна. Хожуу үеийн үр хөндөлтийн түвшин 1 000 амьд төрөлтөд 6.1 промилль байгаа нь өмнөх оноос 0.7 пунктээр буурсан байна.

Үр хөндөлт хийлгэсэн эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд: 20-иос доош насны 6.1 хувь, 20-34 насны 69.3 хувь, 35-49 насны эмэгтэйчүүд 24.6 хувийг тус тус эзэлж байна. 20-иос доош насны үр хөндөлтийн түвшинг өмнөх онтой харьцуулахад 0.8 пунктээр буурсан байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 9.1 хувь нь төрөөгүй ба анхны удаа үр хөндүүлсэн нь өмнөх оноос 1 758 тохиолдлоор буюу 11.2 хувиар буурсан байна.

Үр хөндөлтийн хүндрэл 115 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 2.9 дахин буурсан ба хүндрэлийн 46.0 хувийг умайн агшилт суларч цус алдсан, 38.2 хувийг умайн дайврын үрэвсэл, 15.8 хувийг бусад хүндрэл эзэлж байна.

#### Хүснэгт 3.8.1. Үр хөндөлт, байршлаар, 2013 он

№	Эрүүл мэндийн байгууллага	Бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	Нийт үр хөндөлтөд эзлэх хувь
1	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	3127	20.0
2	Амаржих газрууд	4766	30.5
3	Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв	116	0.7
4	Хувийн эмнэлэг	3335	21.3
5	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	2308	14.8
6	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1840	11.8
7	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	56	0.4
8	Сум дундын эмнэлэг	22	0.1
9	Тосгоны эрүүл мэндийн төв	0	0.0
10	Сумын эрүүл мэндийн төв	30	0.2
11	Бусад эмнэлэг	28	0.2
	<b>Бүгд</b>	<b>15628</b>	<b>100.0</b>

### 3.9. Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ /ЖСАХ/

Нөхөн үржихүйн 15-49 насны 1 000 эмэгтэй тутмын 552 нь жирэмслэлтээс сэргийлэх ямар нэг арга хэрэглэдэг байна.

Жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээг төрлөөр нь авч үзэхэд бэлгэвч 32.4, ерөндөг 25.5, бэлдмэл /эм/ 24.4, тариа 11.4, бусад 4.6, умайн үр дамжуулах суваг боох /стерилизаци/ 1.4, суулгац /норплант/ 0.3 хувийг тус тус эзэлж байна.

2010 оны “Хүүхэд хөгжил 2010” судалгаагаар 15-49 насны гэрлэсэн болон хамтран амьдрагчтай эмэгтэйчүүд бараг бүгд ЖСАХ-ийн талаар мэддэг боловч дөнгөж талаас илүү хувь нь (55 хувь) жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэгсэл хэрэглэдэг нь нотлогдсон байна. ЖСАХ хэрэглэж байсан эмэгтэйчүүдийн 13.2 хувь хэрэглэхээ болж 5.6 хувь нь жирэмсэлсэн байна.

#### 3.9.1. ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо байршлаар, 2013 он

№	Байршил	ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо	Эзлэх хувь
1	Улаанбаатар хот	211 309	45.3
2	Аймгийн төв	113 276	24.3
3	Сумын төв	65 505	16.4
4	Баг	65 502	14.0
	<b>Бүгд</b>	<b>466 550</b>	<b>100.0</b>

## БҮЛЭГ 4. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

### ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү бүлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээний албан ёсны статистик мэдээллийг Эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц үйл ажиллагааны стандарттай харьцуулсан бөгөөд манай улс нь эмнэлгийн тусламж үйлчилгээний 3 шатлалт тогтолцоотой бөгөөд эмнэлгийн тусламж үйлчилгээнд баримтлах зарчим нь үйлчилгээг хүн бүрт жигд, хүртээмжтэй чанартай үзүүлэх явдал юм.

Монгол улсын хүн амд Өрхийн эрүүл мэндийн төв, Сум, тосгоны эрүүл мэндийн төв, Сум дундын эмнэлэг, Клиник, Амаржих газар, Нийгмийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Сувилал, Түргэн тусламжийн төв, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

Тухайн бүлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг илтгэх үзүүлэлтүүд, нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, эхийн эндэгдэл, амбулаторийн тусламж үйлчилгээний үзүүлэлтүүд, хүний нөөцийн үзүүлэлтүүдийг шатлал бүрээр харуулсан болно.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний ашиглалтын нэг гол үзүүлэлт нь эмнэлгийн **хэвтүүлэн эмчлэх тусламж** үйлчилгээ юм.

2013 оны байдлаар улсын хэмжээнд 737 477 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлж, 5 648 506 ор хоног ашигласан байна. Орны эргэлт жилээс жилд нэмэгдэж байгаа ба дундаж ор хоног буурахад гол нөлөө үзүүлдэг. Уг үзүүлэлтийг эмнэлгийн нөөцийн болон тусламж үйлчилгээ, ашиглалтын бусад үзүүлэлттэй хослуулан эмнэлгийн орны ашиглалтад үнэлгээ өгөх, эмнэлгийн орны хэрэгцээг тогтоох, эмнэлгийн орны тоог төлөвлөхөд ашигладаг.

**Дундаж ор хоног** нь тайлангийн жилд 1 өвчтөнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн дундаж хоногийн тоог хэлдэг ба 2013 онд 7.7 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 0.9-р буурсан үзүүлэлттэй байна. Дундаж ор хоногийг нийт хэвтэн эмчлүүлэгсдээр бус өвчний ангилал, эмнэлгийн тасаг, нэгж тус бүрээр тооцож гаргах нь илүү ач холбогдолтой байдаг. Уг үзүүлэлтийг эмнэлгийн нөөцийн болон тусламж үйлчилгээ, ашиглалтын үзүүлэлттэй хослуулан эмнэлгийн орны ашиглалтад үнэлгээ өгөх, эмнэлгийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, эмнэлгийн үйл ажиллагааны зардлын үр ашгийг тооцоход ихэвчлэн ашиглана.

Мөн эмнэлгийн орны ашиглалтад үнэлгээ өгөх, эмнэлгийн орны хэрэгцээг тогтоох, эмнэлгийн орны тоог төлөвлөхөд ашигладаг гол үзүүлэлт нь **орны фонд ашиглалт** байдаг ба энэ нь тайлангийн жилд эмнэлгийн 1 орыг ашигласан дундаж хоногийн тоог хэлдэг. 2013 онд орны фонд ашиглалтын хувь 86.2 байна.

Европын улс оронд орны фонд ашиглалтыг 85%-аас дээш гарсан тохиолдолд тусламж үйлчилгээний чанарт сөрөг нөлөөтэй гэж үздэг байна. Мөн орны фонд ашиглалтыг 85 хувиас доош байвал фонд ашиглалт хангалтгүй, шаардлаггүй орны тоог цөөрүүлэх үндэслэл болно гэж үздэг байна.

## БҮЛЭГ 4. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ.

2013 оны байдлаар төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв-16, бүсийн оношлогоо эмчилгээний төв - 5, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг -20, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв-8, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг-6, сум дундын эмнэлэг-39, сум/тосгоны эрүүл мэндийн төв-271/19, өрхийн эрүүл мэндийн төв - 228, амаржих газар-3, хилийн цэрэг, төмөр зам, хорихын нэгдсэн эмнэлэг зэрэг бусад эмнэлгүүд-31, хувийн ортой эмнэлэг-197, үүдэн эмнэлэг-822 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

### Хүснэгт 4.1. Эрүүл мэндийн байгууллагуудын тоо, 2013 он

Эрүүл мэндийн байгууллагууд	Тоо
Өрхийн эрүүл мэндийн төв	228
Сум/ тосгоны эрүүл мэндийн төв	271/19
Сум дундын эмнэлэг	39
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	8
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	6
Аймгийн нэгдсэн эмнэлэг	20
Бүсийн оношлогоо эмчилгээний төв	5
Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд	16
Амаржих газрууд	3
Бусад эмнэлгүүд /Хилийн цэрэг, төмөр зам, хорихын эмнэлгүүд/	31
Ортой хувийн эмнэлэг	197
Үүдэн хувийн эмнэлэг	822
Аршаан сувилал, сувилал	71
Эм ханган нийлүүлэх байгууллага	128
Эмийн үйлдвэр	42
Хувийн эмийн сан	789
Бусад	57
<b>Бүгд</b>	<b>2752</b>

#### 4.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ

Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.

АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-2”-ийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвүүдийг Улаанбаатар хот болон бүх аймгийн төвүүдэд үе шаттайгаар байгуулж, 2002 он гэхэд өрхийн эмнэлгийн тогтолцоонд шилжсэн билээ.

2013 оны байдлаар 228 өрхийн эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотын 1 сая 267.0 мянган хүн амд 136 өрхийн эрүүл мэндийн төв, 21 аймгийн төвийн 576.7 мянган хүн амд 92 өрхийн эрүүл мэндийн төв эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

### Хүснэгт 4.1.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2013 он

Үзүүлэлт	Өрхийн эрүүл мэндийн төв		Нийт дүн
	УБ хот	Аймаг	
Эмнэлгийн тоо	136	92	228
Их эмчийн тоо	555	320	875
Сувилагчийн тоо	527	285	812
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	3834822	2035472	5870294
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	42.2	36.1	40.1
Нэг иргэний жилд үзүүлсэн удаа	3.0	3.0	3.0
Нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо	6909.6	6360.9	6708.9
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	86.4	87.1	86.7


228 өрхийн эрүүл мэндийн төвд их эмч-875, сувилагч-812 болон нийт 2 501 эмч, эмнэлгийн ажиллагчид хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартад 1 800-2 000 хүн тутамд 1 их эмч ажиллана гэж заасан хэдий ч 2013 оны байдлаар улсын хэмжээнд 1 өрхийн эмчид 2 107 хүн ногдож байна. Архангай, Баянхонгор, Булган, Дорнод, Дундговь, Увс, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотод нэг их эмчид ногдох хүний тоо стандартад заасан хэмжээнээс өндөр байна.

2013 онд өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд жилд дунджаар 5.8 сая үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 3.0 удаа өрхийн эрүүл мэндийн төвд хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна. Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь 40.1 байгаа ба УБ хотын өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 42.2 хувь, харин аймгийн өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 36.1 хувь байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь өмнөх оноос 4.8 хувиар буурсан байна.

“Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-д гэрийн идэвхтэй эргэлтийн хувь 30 хувиас доошгүй байна гэж заасан хэдий ч 2013 оны байдлаар өмнөх оны түвшинд буюу 26.7 хувь байна.

2013 оны байдлаар 1 хүртэлх насны хүүхдийн хяналтын хувь 99.6 хувь, 1-5 насны хүүхдийн хяналтын хувь 96.1 хувь, ахмад настны хяналтын хувь 83.7 байна.

### Зураг 4.1.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн амбулаторийн үзлэгийн тоо, сүүлийн 3 жилээр



Улаанбаатар хотын өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 2005 онд 3.0 сая үзлэг хийгдэж байсан бол 2007 онд 3.9 сая, 2010 онд 4.2 сая, 2013 онд 3.8 сая үзлэг хийгдсэн байна. Жилд нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо Улаанбаатар хотод 6909.6 байгаа нь аймгийн түвшинд ажиллаж байгаа өрхийн нэг эмчид ногдох үзлэгээс 548 үзлэгээр их байна.

### 4.2. Сумын эрүүл мэндийн төвийн болон сум дундын эмнэлгийн тусламж, үйлчилгээ

Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийнхээ хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлэх бөгөөд сумын эрүүл мэндийн төв нь тухайн сумын хүн амын тоо, байршлаас хамааран багийн эмчийн салбартай байж болно.

Сум дундын эмнэлэг нь хүн амын суурьшил, нягтралаас хамааран харьяаллын болон зэргэлдээ сумын хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

2013 онд батлагдсан “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт”-аар сумын эрүүл мэндийн төвүүд нь аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймгийн төв хүртэлх зорчих хугацаанаас хамааран 3 зэрэглэлд ангилсан байна.


Нэгдүгээр зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км-ийн дотор үйлчлэх хүрээний хүн ам 3000 хүртэл, хоёрдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50-99 км-ийн дотор болон 1-2 цаг хүртэлх хугацаанд зорчих, гуравдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 100 км-ээс алслагдсан сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэг хамаарна гэж заасан.

Гэвч сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км-ээс дотогш боловч үйлчлэх хүрээний хүн амын тоо 3000-аас дээш, хүн амын 70-аас дээш хувь нь сумын төвөөс алслагдсан бол хоёрдугаар зэрэглэлд, 100 км-ээс дотогш боловч хүн амын тоо 8000-аас дээш бол гуравдугаар зэрэглэлд хамааруулна.

**Хүснэгт 4.2.1 Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн их эмчийн хангамжийг стандартын доод хязгаартай харьцуулсан байдал, 2013 он**

Зэрэглэл	Эмнэлгийн тоо	Эмчийн тоо (дундаж)	Стандартын түвшинд		Стандартаас доогуур	
			тоо	Хувь	Тоо	Хувь
I зэрэглэл	17	2.8	15	88.2	2	11.8
II зэрэглэл	79	1.9	52	65.8	27	34.2
III зэрэглэл	175	2.8	133	76.0	42	24.0
Сум дундын эмнэлэг	39	5.7	5	12.8	34	87.2

**Зураг 4.2.1 Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ногдох эмчийн дундаж тоо, 2013 он**




**Хүснэгт 4.2.2 Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарын зарим үзүүлэлт, 2011, 2013 он**

Үзүүлэлт	2011 он			2013 он		
	Сумын эрүүл мэндийн төв	Сум дундын эмнэлэг	Нийт дүн	Сумын эрүүл мэндийн төв	Сум дундын эмнэлэг	Нийт дүн
Эмнэлгийн орны тоо	2 928	675	3 603	2 971	661	3 632
Их эмчийн тоо	576	171	747	611	208	819
Сувилагчийн тоо	1 341	243	1 584	1 383	256	16.39
Дундаж ор хоног	8.0	7.8	7.9	7.3	7.0	7.3
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	109 720	22 905	132 625	101 010	21 816	122 826
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	2 009 293	427 516	2 436 809	1 910 213	438 021	2 348 234
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	39.5	37.5	39.2	37.8	38.7	37.6
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	89.5	92.6	90.0	90.5	90.9	90.5
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөд)	58	145.3	76.4	64.6	75.5	67.0
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	36.2	28.3	34.5	35.3	27.9	33.7

2013 оны байдлаар эмнэлгийн нийт орны 18.2 хувь нь сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт ногдож байгаа бөгөөд 2011 онтой харьцуулбал 29 ороор буюу 0.7 хувиар нэмэгдсэн байна.

Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт жилд 122.8 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн байна. 2013 онд хэвтэн эмчлүүлэгчдийн тоог 2011 онтой харьцуулахад сум дундын эмнэлэгт 4.9 хувиар буурч, сумын эмнэлэгт 8.7 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг 4.2.2. Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2011-2013 он**



Дундаж ор хоног 2011 онд 7.9 хоног байсан бол 2013 онд 7.3 болж буурсан байна. Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт нэг иргэний үзүүлсэн дундаж тоо 2011 онд 2.5 байсан бол 2013 онд 2.3 болж буурсан байна. 2013 онд сумын болон сум дундын эмнэлгийн түвшинд жирэмсний эрт үеийн хяналт 90.5 болж 2011 оноос 0.5 хувиар нэмэгдсэн байна.

2013 онд нийт эндсэн эхийн 11.8 хувь (4 тохиолдол) нь сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт эндсэн байна. 2011 онтой харьцуулахад 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин сум дундын эмнэлгийн түвшинд 69.8-оор буурч, сумын эрүүл мэндийн төвийн түвшинд 6.6-оор нэмэгдсэн байна.

2013 онд 1000 амьд төрсөн хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийн түвшин сумын эрүүл мэндийн түвшинд 35.3, сум дундын эмнэлгийн түвшинд 27.9 байна. Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлгийн нялхасын эндэгдлийн түвшин 2011 оноос 0.8-оор буурсан байна.



### 4.3 Нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ

Нэгдсэн эмнэлэг нь хүн амд 7-оос доошгүй чиглэл/ дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, ерөнхий мэс засал, шүд, мэдрэл, халдварт/-ээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх бөгөөд хүн амын байршил, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг үндэслэн салбар амбулаторитой байж болно гэж эрүүл мэндийн тухай МУ-ын хуулинд заажээ.


Нийгмийн эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулдаг.

2013 оны байдлаар 16 аймгийн нэгдсэн эмнэлэгт 959 их эмч, 1608 сувилагч, 2168 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 4692 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд 796 их эмч, 852 сувилагч, 1136 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 2892 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн нийт орны 16.3 хувь нь ногдож байгаа бөгөөд 2013 онд аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн орны тоо 3249 буюу 2011 онтой харьцуулахад 36 ороор нэмэгдсэн байна.

Дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд нийт орны 9.4 нь хувь ногдож байгаа бөгөөд дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2011 онд 76.7 мянга байсан бол 2013 онд 86.4 мянга болж, 9.6 мянган хүнээр нэмэгдсэн байна.

**Зураг 4.3.1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2013 он**



### Хүснэгт 4.3.1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2011-2013 он

Үзүүлэлт	2011 он		2012 он		2013 он		Сүүлийн 3 жилийн дундаж	
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг
Эмнэлгийн орны тоо	3 213	1 808	3 070	1 808	3 249	1 868	3 177	1 828
Их эмчийн тоо	903	711	904	785	959	796	922	764
Сувилагчийн тоо	1 515	766	1 524	822	1 608	852	1 549	813
Дундаж ор хоног	7.8	7.5	7.7	7.5	7.4	7.3	7.6	7.4
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	127 414	76 783	125 369	84 892	126 902	86 401	126 562	82 692
Хоног болоогүй нас баралтын хувь	34.1	29.6	31.5	31.4	32.3	30.3	32.6	30.4
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	1 616 455	2 033 432	1 425 793	2 168 522	1 497 908	2 367 979	1 513 385	2 189 978
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	41.8	45.3	37.6	45.0	35.1	43.7	38.2	44.7
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөнд)	49.7	-	49.8	-	32.2	-	44.5	-
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	15.1	-	12.0	-	11.8	-	12.9	-
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	16.5	-	13.7	-	11.6	-	13.9	-

Аймгийн нэгдсэн эмнэлгийн дундаж ор хоног 2011 онд 7.8 байсан бол 2013 онд 7.4 болж, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн дундаж ор хоног 2011 онд 7.5 байсан бол 2013 онд 7.3 болж тус тус буурсан байна.

2013 онд эмнэлгийн хоног болоогүй нас баралтын эзлэх хувь аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 2011 оноос 1.8 хувиар буурч, дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 0.7 хувиар нэмэгдсэн байна.

Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 2011 онд аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 1.6 сая, дүүргийн эмнэлгийн түвшинд 2.0 сая байсан бол аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 1.4 болж буурсан ба дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 2.3 сая болж нэмэгдсэн байна. Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 2011 оноос 6.6 хувиар, дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 1.6 хувиар буурсан байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн нялхсын эндэгдлийн түвшин сүүлийн 3 жилд тогтвортой буурсан бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж 12.8 байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 2013 онд 32.2 байгаа нь 2011 онтой харьцуулахад 17.5-оор буурсан байна.

Сүүлийн 3 жилд дунджаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 13.8 хувийг хөдөөнөөс буюу сум, сум дундын эмнэлгээс илгээсэн өвчтнүүд эзэлж байна. 2013 онд хөдөөнөөс аймгийн нэгдсэн эмнэлэгт ирж хэвтэн эмчлүүлэгчид өмнөх 2011 онтой харьцуулахад 4.9 хувиар буурсан байна.

#### 4.4 Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээ

Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь бүс нутгийн хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагад мэргэжлийн аргачилсан зөвлөгөө

өгөх, сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага юм. 2013 оны байдлаар улсын хэмжээнд Орхон, Дорнод, Өвөрхангай, Ховд, Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлгүүд БОЭТ-ийн статусаар үйл ажиллагаа явуулж байгаа ба 412 их эмч, 665 сувилагч, 896 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 1855 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

#### Хүснэгт 4.4.1. БОЭТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2011-2013 он

Үзүүлэлт	Онууд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2011	2012	2013	
Эмнэлгийн орны тоо	1145	1290	1285	1240.0
Дундаж ор хоног	7.5	7.7	7.6	7.6
Хоног болоогүй нас баралтын хувь	26.8	29.6	27.9	28.1
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	43 163	49 417	51 107	47 896
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	458 211	555 650	571 396	528 419
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөнд)	63.7	33.2	20.3	37.4
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	15.9	14.9	10.2	13.8
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	27.6	26.3	27.5	27.1

2013 онд БОЭТ-д 51.1 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн бөгөөд, жилд дунджаар 14054 хүн сумын болон сум дундын эмнэлэг, бүсийн аймгуудаас ирж хэвтэн эмчлүүлж байгаа нь нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 27.5 хувьтай тэнцэж байна.

БОЭТ-ийн дундаж ор хоног 2011 онд 7.5 байсан бол 2013 7.6 болж нэмэгдсэн байна. Түүнчлэн эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь 2011 онд 26.8 байсан бол 2013 онд 27.9 хувь болж нэмэгдсэн байна.

Сүүлийн 3 жилд улсын хэмжээнд нялхсын эндэгдэл тогтвортой бага түвшинд байгаа хандлагын дагуу БОЭТ-ийн 1 000 амьд төрсөн хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2011 -2013 онд 1 000 амьд төрөлтөд 13.8 байгаа нь аймгийн дунджаас доогуур байна. 2013 онд Өвөрхангай, Ховд аймгийн БОЭТ-д тус бүр 1 эх эндсэн байна.

#### Хүснэгт 4.4.2. БОЭТ-ийн үйл ажиллагааны зарим үзүүлэлт, 2013 он

Аймаг БОЭТ	Хэвтэн эмчлүүлэгчид	Ор хоног	Дундаж ор хоног	Хоног болоогүй нас баралт	Амбулаторийн үзлэг	Бүртгэгдсэн халдварт бус өвчлөл	Эхийн эндэгдэл /100000 амьд төрөлтөд/	Нялхсын эндэгдэл /1000 амьд төрсөн хүүхдэд/	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрсөн хүүхдэд/
Дорнод	11 478.5	92 896	8.1	32.7	107 332	17 435	0.0	12.1	17.4
Орхон	13 649.5	104 089	7.6	21.2	147 672	5 311	0.0	9.6	9.6
Өвөрхангай	8 140	60 067	7.4	31.9	88 330	32 940	35.9	10.6	11.6
Өмнөговь	6 192.5	40 018	6.5	62.5	100 819	17 932	0.0	11.6	12.4
Ховд	11 647	91 560	7.9	24.0	127 243	14 165	42.2	14.0	15.1
<b>Дүн</b>	<b>51 107.5</b>	<b>388 630</b>	<b>7.6</b>	<b>27.9</b>	<b>571 396</b>	<b>87 783</b>	<b>20.3</b>	<b>10.2</b>	<b>12.9</b>

**Хүснэгт 4.4.3. БОЭТ-ийн хүний нөөцийн зарим үзүүлэлт, 2013 он**

№	Аймаг БОЭТ	Нийт ажиллагсад	Үүнээс			Орны тоо
			Тусгай мэргэжлийн мэргэжилтэн	Их эмч	Сувилагч	
1	Дорнод	502	222	101	163	322
2	Орхон	475	244	109	193	364
3	Өвөрхангай	314	160	79	109	216
4	Өмнөговь	205	93	56	64	125
5	Ховд	373	181	83	134	258
<b>Дүн</b>		<b>1869</b>	<b>900</b>	<b>428</b>	<b>663</b>	<b>1285</b>

**4.5 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн тусламж, үйлчилгээ**

Төв эмнэлэг нь улсын хэмжээнд төрөлжсөн мэргэжлээр эмнэлгийн тусламж үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг лавлагаа мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна. Тусгай мэргэжлийн төв нь улсын хэмжээнд тухайн мэргэжлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, лавлагаа, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэн эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж байна.

2013 оны байдлаар 16 Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдэд 1383 их эмч, 2071 сувилагч, 2494 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 6391 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

Нийт эмнэлгийн орны 21.0 хувь нь, мөн хэвтэн эмчлүүлэгчдийн 19.8 хувь нь УБ хотын төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд ногдож байна.


Дундаж ор хоног 2011 онд 8.2 байсан бол 2013 онд 7.4 болж буурсан байна. Түүнчлэн эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь 2011 онд 21.2 байсан бол 2013 онд 24.5 хувь болж нэмэгдсэн бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж 22.7 хувь байна.

**Хүснэгт 4.5.1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарын зарим үзүүлэлт, 2011-2013 он**

Үзүүлэлт	Онууд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2011	2012	2013	
Эмнэлгийн орны тоо	3 995	4 085	4 187	4 089.0
Их эмчийн тоо	1 280	1 327	1 383	1 330.0
Сувилагчийн тоо	1 937	1 988	2 071	1 998.7
Дундаж ор хоног	9.9	9.2	9.5	9.5
Хоног болоогүй нас баралтын хувь	21.2	22.3	24.5	22.7
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	137 929	141 381	146 375	141 895.0
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	1 200 639	1 237 295	1 385 032	1 274 322.0
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн тоо / хөдөөнөөс/	34 741	32 007	39 380	35 376.0

Сүүлийн 3 жилд дунджаар Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 141 мянган хүн хэвтэн эмчлүүлж байгаагийн 24.9 хувийг хөдөөнөөс ирж хэвтэн эмчлүүлэгчид эзэлж байна. 2011 онтой харьцуулбал 2013 онд нийт хэвтэн эмчлүүлэгчид 2.8 хувиар нэмэгдэж, хөдөөнөөс ирж хэвтэн эмчлүүлэгч 0.3 хувиар буурсан байна.

**Зураг 4.5.1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь, 2013 он**



**Хүснэгт 4.5.2. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны зарим үр дүнгийн үзүүлэлт, 2013 он**

Эмнэлгүүдийн нэр	Амбулаторийн үзлэгийн тоо	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид	Дундаж ор хоног	Хоног болоогүй нас баралт
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	207 512	21 147	7.8	26.3
Улсын хоёрдугаар төв эмнэлэг	89 633	7 561	8.8	8.3
Улсын гуравдугаар төв эмнэлэг	152 203	17 064	8.4	19.6
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	167 598	36 892	6.3	26.8
Хавдар судлалын үндэсний төв	90 964	8 575	8.4	4.2
Халдварт өвчин судлалын үндэсний төв	111 514	9 571	14.3	9.2
Гэмтэл согог судлалын үндэсний төв	107 537	13 038	11.9	24.2
Арьсны өвчин судлалын үндэсний төв	82 710	5 803	10.0	0
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	56 386	5 750	29.3	14.3
Хүүхдийн төв сувилал	0	302	21.4	0
Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн корпорац	24 442	4 015	9.1	0
Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн	16 675	0	0	0
Геронтологийн үндэсний төв	13 064	0	0	0

## 4.6 Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээ


2013 оны байдлаар 197 ортой, 822 үүдэн хувийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хувийн эмнэлгүүдэд 1965 их эмч, 1891 эмнэлгийн тусгай дунд мэргэжилтэн, үүнээс 1326 сувилагч, нийт 5835 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

### Хүснэгт 4.6.1 Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2013 он

	2000	2005	2009	2010	2011	2012	2013
Ортой эмнэлгийн тоо	466	160	160	166	171	179	197
Үүдэн эмнэлгийн тоо		523	922	947	1013	851	822
Эмнэлгийн орны тоо	964	1 982	2 422	2 527	3 069	3 606	3 829
Нийт оронд эзлэх хувь	5.4	10.8	13.6	14.2	16.2	18.4	19.3
Эмчийн тоо	736	1 145	1 396	1 549	1 677	1 904	1 965
Сувилагч	296	682	858	1 007	1 135	1 275	1 326
Амбулаторийн үзлэгийн тоо	-	1 016 705	1 304 897	1 036 934	1 986 901	1 320 932	1 756 769
Эмнэлэгт хэвтсэн хүний тоо	23 592	63 267	75 003	86 117	97 821	111 338	121 452
Дундаж ор хоног	11.3	9	8.1	7.9	8.2	7.7	7.4

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийг орны тоо 2005 онд 1982 байсан бол 2013 онд 3 829 болж нэмэгдсэн бөгөөд нийт эмнэлгийн орны 19.3 хувийг эзэлж байна. 2005 оноос хувийн хэвшлийн эмнэлгүүдийг ялангуяа ортой эмнэлгийг шинээр байгуулахыг хязгаарлах, харин үйл ажиллагааны чиглэл нь улсын эмнэлгийн үзүүлж байгаа зарим эмнэлгийн тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн эмнэлгүүдээр гүйцэтгүүлэх, үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх, төрөлжүүлэх бодлогыг хэрэгжүүлж ирсэн билээ.

### Зураг 4.6.1. Оргүй эмнэлгүүд, үйлчилгээний төрөл, хувиар, 2013 он



Хувийн хэвшлийн эмнэлгүүдээр 2005 онд 1 016 705 хүн амбулаториор үйлчлүүлж, 63 267 хүн хэвтэн эмчлүүлж байсан бол 2013 онд амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо 1 756 769, хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 121 452 болж нэмэгдсэн байна.

2013 оны байдлаар хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн 47.5 хувь нь дотор, 10.1 хувь нь мэдрэл, 10.4 хувь нь уламжлалт, 7.2 хувь нь эмэгтэйчүүд, 5.1 хувь нь мэс засал, 4.7 хувь нь хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

#### Хүснэгт 4.6.2. Хувийн ортой эмнэлгүүдийн хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, 2013 он

Үзүүлэлт	Эмнэлгийн тоо		Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
5-8 ортой	14	7.1	6 102	5.0
10-12 ортой	65	33.0	35 446	29.2
15 ортой	46	23.4	27 625	22.7
20-25 ортой	38	19.3	20 520	16.9
30 ортой	14	7.1	11 659	9.6
40-50 ортой	11	5.6	7 650	6.3
50 ба түүнээс дээш ортой	9	4.6	12 450	10.3
<b>Нийт дүн</b>	<b>197</b>	<b>100</b>	<b>121 452</b>	<b>100</b>

#### 4.7. Түргэн тусламжийн үйл ажиллагаа

Түргэн тусламжийн үйлчилгээг үр дүнтэй бүтэц, зохион байгуулалтад оруулах, менежментийг сайжруулах, техник, багаж, тоног төхөрөөмжийг шинэчлэх, боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх замаар олон улсын жишигт ойртсон нэгдсэн тогтолцоо бий болгох шаардлагын үүднээс “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ хөтөлбөр”-ийг 2010 оны 12 сарын 8-ны өдрийн Засгийн газрын 318 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. 2013 онд улсын хэмжээнд 730.0 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч гүйцэтгэснээс 10.6 хувийг алсын дуудлага эзэлж байна.

##### Хүснэгт 4.7.1. Түргэн тусламжийн дуудлага, 2013 он

№	Аймгууд	Бүгд	Үүнээс алсын дуудлага	
			Бодит тоо	Эзлэх хувь
1	Архангай	20 906	4 748	22.7
2	Баян-Өлгий	21 590	6 654	30.8
3	Баянхонгор	15 968	3 085	19.3
4	Булган	14 142	3 309	23.4
5	Говь-Алтай	18 148	2 832	15.6
6	Говьсүмбэр	6 322	466	7.4
7	Дархан-Уул	24 151	755	3.1
8	Дорноговь	20 173	2 938	14.6
9	Дорнод	16 032	2 355	14.7
10	Дундговь	14 105	3 387	24.0
11	Завхан	20 663	3 054	14.8
12	Орхон	18 103	354	2.0
13	Өвөрхангай	21 016	6 560	31.2
14	Өмнөговь	12 409	2 390	19.3
15	Сүхбаатар	18 111	4 312	23.8
16	Сэлэнгэ	30 770	4 351	14.1
17	Төв	17 917	4 494	25.1
18	Увс	17 436	4 224	24.2
19	Ховд	16 924	3 536	20.9
20	Хөвсгөл	27 198	5 005	18.4
21	Хэнтий	21 481	4 470	20.8
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>393 565</b>	<b>73 279</b>	<b>18.6</b>
23	Улаанбаатар	336 452	4 175	1.2
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>730 017</b>	<b>77 454</b>	<b>10.6</b>

##### Түргэн тусламжийн үндэсний сүлжээний төвийн алсын дуудлагын үйл ажиллагаа


2013 онд 21 аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүргээс нийт 250 дуудлагыг хүлээн авч зохих журмын дагуу тусламж үйлчилгээ үзүүлсэн. Нийт дуудлагын 157 буюу 62.8%-д төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нар орон нутагт очиж тусламж үйлчилгээ үзүүлж 88 буюу 35.2 %-д утсаар зөвлөгөө өгүүлж, 5 буюу 2 % нь дуудлага гарахаас өмнө өвчтөн нас барсан байна.




## Хүснэгт 4.7.2 Түргэн тусламжийн сүлжээний төвийн алсын дуудлага, 2013 он

№	Аймаг, дүүргийн нэр	Хүлээн авсан дуудлага		Орон нутагт очиж тусламж үйлчилгээ үзүүлэхэд ашигласан тээврийн хэрэгсэл		Утсаар зөвлөгөө өгсөн	Дуудлага очихоос өмнө нас барсан
		тоо	хувь	машин	онгоц		
1	Архангай	15	6.0	10	0	5	0
2	Баян-Өлгий	19	7.6	0	12	5	2
3	Баянхонгор	8	3.2	6	0	2	0
4	Булган	17	6.8	13	0	2	2
5	Говь-Алтай	2	0.8	1	0	1	0
6	Говьсүмбэр	2	0.8	1	0	1	0
7	Дархан-Уул	18	7.2	10	0	8	0
8	Дорноговь	5	2.0	5	0	0	0
9	Дорнод	7	2.8	1	5	1	0
10	Дундговь	7	2.8	2	0	5	0
11	Завхан	6	2.4	1	1	3	1
12	Орхон	8	3.2	5	0	3	0
13	Өвөрхангай	26	10.4	14	0	12	0
14	Өмнөговь	4	1.6	2	1	1	0
15	Сүхбаатар	9	3.6	6	0	3	0
16	Сэлэнгэ	15	6.0	11	0	4	0
17	Төв	20	8.0	10	0	10	0
18	Увс	10	4.0	0	9	1	0
19	Ховд	7	2.8	0	4	3	0
20	Хөвсгөл	8	3.2	5	1	2	0
21	Хэнтий	19	7.6	15	0	4	0
22	Багануур дүүрэг	12	4.8	2	0	10	0
23	Баганхангай дүүрэг	1	0.4	1	0	0	0
24	Сэлэнгэ Зүүн хараа	5	2.0	3	0	2	0
<b>Дүн</b>		<b>250</b>	<b>100.0</b>	<b>124</b>	<b>33</b>	<b>88</b>	<b>5</b>

Зураг 4.7.1. Хүлээж авсан алсын дуудлага бодит тоогоор, 2009-2013 он




**Зураг 4.7.2. Зонхилон тохиолдож буй дуудлага эзлэх хувиар, 2009-2013 он**



Хөдөө орон нутгаас хүлээн авсан дуудлагын дотор осол гэмтлийн дуудлага тэргүүлэх шалтгаан болж байна.

**Зураг 4.7.3. Алсын дуудлагаар үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ, 2008-2013 он**



Нарийн мэргэжлийн эмч нар орон нутагт очиж үзүүлсэн тусламж үйлчилгээний нийт дуудлаганд эзлэх хувь 2013 онд 62.8 хувь болж өмнөх онтой харьцуулахад 4.6 пунктээр буурсан байна.

## БҮЛЭГ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ

### ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү бүлэгт эрүүл мэндийн салбарын ажиллагчид, нас хүйсээр, эрүүл мэндийн байгууллагуудын шатлал бүрт ажиллаж буй эмч, сувилагч, мэргэжилтнүүдийн хангамжийн талаархи статистик мэдээллийг оруулав.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун эргийн бүсээс гишүүн орнуудын эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бүсийн стратеги боловсруулсан. Уг стратегийг хэрэгжүүлэх зорилгоор манай улс “Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн баримт бичиг”-ийг 2008 онд гаргасан ба 2012 онд шинэчлэн баталсан байна.

Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээгээр эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын талаарх мэдээллийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлал, байгууллагын төрөл, мэргэжлээр гаргахын зэрэгцээ эмнэлгийн мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөний мэдээг нэгтгэн гаргаж байна.

Мөн 10 000 хүн амд ногдох, их эмч, сувилагч, ажиллагчдын тоог аймаг тус бүрээр тооцон гаргасан ба манай улсын хувьд 10 000 хүн амд ногдох их эмчийн тоо 30.7 байгаа нь дэлхийн бусад орнуудын дундажтай харьцуулахад өндөр байгаа хэдий ч хөдөө орон нутагт эмч эмнэлгийн мэргэжилтэн дутагдалтай байгаа нь статистик мэдээнээс харагдаж байна.

**10 000 хүн амд ногдох эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоо** нь эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоог 10 000 хүн амд харьцуулсан үзүүлэлт ба салбарын хүний нөөцийн хангамж хүртээмжийг үнэлэх, Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг төлөвлөх, хэрэгцээг тооцох, эрүүл мэндийн салбарын хүний нөццийн хүртээмжийг бүс нутгаар харьцуулахад хэрэглэдэг.

**Нэг их эмчид ногдох хүн амын тоог** мэргэжил тус бүрээр тооцон гаргаж болох ба нийт их эмчийн тоог жилийн дундаж хүн амын тоонд харьцуулж гаргадаг. Мөн 10 000 хүн амд ногдох сувилагчийн тоог тооцон гаргаж сувилагчийн хангамж хүртээмжийг үнэлэх, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг төлөвлөх, хэрэгцээг тооцох, сувилагчийн хүртээмжийг бүс нутгаар харьцуулахад ашигладаг.

## БҮЛЭГ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ

Эрүүл мэндийн салбарт 2013 онд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 45.0 мянган ажиллагчид ажилласан нь өмнөх онтой харьцуулахад 3.2 хувиар өссөн байна. Нийт ажиллагчдын 24.4 хувь нь анхдагч шатлалын, 18.2 хувь нь хоёрдогч шатлалын, 18.3 хувь нь гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад, 12.9 хувь нь хувийн эрүүл мэндийн байгууллагуудад, 26.2 хувь нь амаржих газар болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Нийт ажиллагчдаас 8 911 нь их эмч, 1 596 нь эм зүйч, 17 402 нь эмнэлгийн тусгай мэргэжилтэн (үүнээс 10 150 нь сувилагч), 12 505 нь эмнэлгийн бус бусад ажилтан байна. Чих хамар хоолой, шүд, дүрс оношлогоо, бөөрний эмчийн тоо өмнөх оныхоос буурч, бусад мэргэжлийн эмч нарын тоо өссөн байна.

Нэг их эмчид ногдох хүний тоо 2013 онд 325.3 байгаа нь өмнөх оныхоос 5 хүнээр, нэг сувилагчид ногдох хүний тоо 285.6 болж, өмнөх оныхоос 0.8 хүнээр тус тус буурсан байна. Хангайн бүсэд дунджаар нэг их эмчид ногдох хүний тоо хамгийн өндөр буюу 490.8, төвийн бүсэд хамгийн бага буюу дунджаар 416 байна. Энэ үзүүлэлт Баян-Өлгий аймагт 614, Хөвсгөл аймаг 579, Сэлэнгэ аймагт 568, Архангай аймагт 565, Булган аймагт 540.0, Баянхонгор аймагт 535.2. байгаа нь хамгийн их байгаа бөгөөд Говьсүмбэр аймагт хамгийн бага буюу 259.9 байна.


Тусламж үйлчилгээ үзүүлж буй ажиллагчдын 19.8 хувийг эмч, 22.5 хувийг сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжлийн мэргэжилтэн 38.6 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 80.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Нийт их эмч/сувилагчийн 19.5/25.4 хувь нь анхдагч шатлалд, 21.1/25.9 хувь нь хоёрдогч шатлалд, 20.3/26.9 хувь нь гуравдагч шатлалд ажиллаж байна.

Монгол улсад 2013 оны байдлаар 10000 хүн амд ногдох их эмч 30.7, сувилагч/эх баригч 37.8, нийт эмнэлгийн дунд мэргэжилтэн 60.0 ногдож байна. 2012 онтой харьцуулахад 10000 хүн амд ногдох эмч 0.4, сувилагч 0.1-ээр нэмэгдсэн байна

Эмч, сувилагчийн (эх баригч) харьцаа улсын түвшинд 1: 1.2, Улаанбаатар хотод 1: 1.0, аймгийн түвшинд 1:1.7 байна.


**Зураг 5.1. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын насны бүтэц, 2013 он**



Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, сувилагч, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн насны бүтцэд 20-29 насны хувь нэмэгдэж байна.

Эмч, сувилагчийг байршлаар авч үзэхэд хөдөө орон нутагт 10 000 хүн амд ногдох их эмч 21.9, сувилагч 32.7 байхад Улаанбаатар хотод эмч 40.8, сувилагч 37.5 байгаа нь хот суурин газар эмчийн нягтрал ихтэй байгаа нь харагдаж байна. Ялангуяа аймагт Улаанбаатар хоттой харьцуулахад нарийн мэргэжлийн эмч болох мэс заслын эмч 1 дахин, гэмтэл, согог заслын эмч 3 дахин, дүрс оношлогоо, лабораторийн эмч 3-3.5 дахин, хүүхдийн эмч 1.1 дахин тус тус бага байна.

**Зураг 5.2. 10 000 хүн амд ногдох их эмч, сувилагч, бүсээр, 2013 он**




10 000 хүн амд ногдох их эмч төвийн бүсэд бусад бүс нутгаас их байхад 10 000 хүн амд ногдох сувилагч зүүн бүсэд бусад бүс нутгаас 0.4-3.0 хувиар их байна.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн 1019 байгууллагад 5835 эмнэлгийн ажиллагсад тусламж үйлчилгээ үзүүлсэн ба нийт ажиллагсдын 33.7 хувь нь их эмч, 22.7 хувь нь сувилагч байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмч нарын дийлэнх буюу 26.0 хувь нь шүдний, 12.6 хувь нь дотрын, 9.5 хувь нь эх барих эмэгтэйчүүдийн, 10.7 хувь нь уламжлалын чиглэлээр ажиллаж байна.

### Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт

2013 онд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтад төрийн сангийн санхүүжилтээр 849 их эмч, 545 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтнүүдийг үндсэн болон төрөлжсөн мэргэшил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан байна. Үүнээс:

**Зураг 5.3.Төрийн зардлаар төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний тоо, 2013 он**



Мөн богино хугацааны сургалтыг 571 сэдвээр зохион байгуулж, давхардсан тоогоор 84878 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.

2013 онд Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий 12 их, дээд сургуулийг (ЭМШУИС, “Ач”, “Монос”, “Этүгэн”, “Энэрэл”, “Оточ манрамба АУДС”, Шинэ анагаах ухааны дээд сургууль, “Улаанбаатар” дээд сургууль, ЭМШУИС-ийн Эрүүл мэндийн технологийн сургууль, Говь-Алтай, Дархан, Дорноговь аймаг дахь салбар сургууль) нийт 2938 мэргэжилтэн төгссөн байна.

## БҮЛЭГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН

### ТОДОРХОЙЛОЛТ

Халдварт өвчинд ӨОУА 10-ын 1 дүгээр бүлэг буюу Халдварт ба шимэгчит зарим өвчин (A00-B99)-ын өвчнүүдийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөл, тархалт өндөр бүс, нутаг, хүн амын бүлгийг тодорхойлох, халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх хөтөлбөр, төслүүдийн ажлын үр дүнг үнэлэх, халдварт өвчний олон жилийн хандлагыг тооцох улмаар халдварт өвчний оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах нөөцийг оновчтой хуваарилах, халдварт өвчний хүн амын эрүүл мэнд, улс орны нийгэм эдийн засагт учруулж буй дарамтыг тооцоход халдварт өвчний тухай статистик мэдээг хэрэглэж байна.

**Халдварт өвчний өвчлөлийн түвшин**-Тайлангийн жилд шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог 10 000 хүн амд харьцуулсан үзүүлэлт

Халдварт өвчнийг хот, хөдөө, хүйс, насны бүлэг, халдварын эх уурхай, халдвар дамжсан зам, халдвар илрүүлэлтээр нь тооцон гаргадаг.

**Вирүст хепатитын өвчлөлийн түвшин**-Тайлангийн жилд шинээр бүртгэгдсэн вирүст хепатитын тохиолдлын тоог 10 000 хүн амд харьцуулсан үзүүлэлт

**Бэлгийн замаар дамжих халдварын өвчлөлийн түвшин** –Тайлангийн жилд амбулаториор шинээр бүртгэгдсэн бэлгийн замын халдварын тохиолдлын тоог 10 000 хүн амд харьцуулсан үзүүлэлт

**Дархлалын олдмол хомсдол /ДОХ/ өвчний тархалтын түвшин** - Тайлангийн жилд дархлалын олдмол хомсдол /ДОХ/-той гэж оношлогдсон хүний тоог 10 000 хүн амд харьцуулсан үзүүлэлт

**Сүрьеэгийн өвчлөлийн түвшин**-Тайлангийн жилд шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын тоог 10 000 (100 000) хүн амд харьцуулсан үзүүлэлт

**Сүрьеэгийн эдгэрэлтийн түвшин**-Уушгиний түрхэц эерэг сүрьеэтэй өвчтөн эмчилгээний хяналтын сүүлийн 2 ба түүнээс дээш удаагийн түрхэцийн шинжилгээнд дараалан сөрөг болсон тохиолдлыг бүх дүгнэгдсэн тохиолдлын тоонд харьцуулна.

**Сүрьеэгийн онош баталгаажилт** - Биологийн сорьцонд хийсэн түрхэцийн, өсгөвөрлөх шинжилгээгээр сүрьеэгийн нян илэрсэн тохиолдол дээр сүрьеэгийн эмчилгээг амжилттай дуусгасан өвчтөн дахин сүрьеэгээр өвчилж түрхэц эерэг болсон тохиолдлыг нэмж /Уушгины эмнэлзүйн шинжүүд илэрч нян судлалын болон гэрлийн шинжилгээгээр батлагдсан тохиолдол дээр Сүрьеэгийн эмчилгээг амжилттай дуусгасан өвчтөн дахин сүрьеэгээр өвчилж түрхэц эерэг болсон тохиолдлыг нэмсэнийг харьцуулна.

## БҮЛЭГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН

### 6.1. Нийт халдварт өвчин


2013 онд улсын хэмжээнд 30 төрлийн халдварт өвчний 37 320 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 5 985 тохиолдлоор буурсан буюу 10 000 хүн амд 132.7 байгаа нь өнгөрсөн оноос 21.3-аар буурсан үзүүлэлт гарлаа. 21 аймаг, Улаанбаатар хотод бүртгэгдсэн халдварт өвчний 10 000 хүн ам тутамд ногдох өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл, Өвөрхангай, Баян-Өлгий, Завхан, Дорноговь, Архангай аймгуудад нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2013 онд халдварт мэнэн, салхинцэцэг, тэмбүү, гар хөл амны өвчин, улаан эсэргэнэ, сүрьеэ, хачигт энцефалит, хүний боом, эритема, хийт үхжил, хумхаа, хачигт рикеттиоз зэрэг өвчнүүд өмнөх онтой харьцуулахад 10 000 хүн амд 0.1-6.6 тохиолдлоор нэмэгдсэн байна.

2013 онд бүртгэгдсэн халдварт өвчин Дорнод (421.7), Сүхбаатар (182.2), Дорноговь (172.5), Говьсүмбэр (137.2), Хөвсгөл (144.9) аймгууд болон Улаанбаатар хот (158.0)-д улсын дунджаас (10 000 хүн амд 132.7) өндөр байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 50.2 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

2013 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт халдварт өвчний 14.3 хувийг гэдэсний халдварт өвчин, 38.9 хувийг амьсгалын замын халдварт өвчин, 1.2 хувийг зоонозын халдварт өвчин, 39.9 хувийг бэлгийн замаар дамжих халдвар тус тус эзэлж байна.

#### Зураг 6.1.1. 2013 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчний бүтэц



### 6.2. Гэдэсний халдварт өвчин

2013 онд улсын хэмжээнд цочмог А хепатит, цусан суулга, хүнсний гаралтай бактерт хордлого, сальмонеллын халдвар, суулгалт халдвар, гар хөл амны өвчин зэрэг 6 төрлийн гэдэсний халдварт өвчний 5 350 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 14.3 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэдэсний халдварт өвчний 3 616 (67.6%) нь Улаанбаатар хотод гарсан байна.

Гэдэсний халдварт өвчний 29.7 хувийг цочмог А хепатит, 37.0 хувийг цусан суулга, 25.7 хувийг гар хөл амны өвчин, 4.4 хувийг хүнсний гаралтай бактерт хордлого, 1.6 хувийг сальмонеллын халдвар, 1.6 хувийг суулгалт халдвар тус тус эзэлж байна.



**Хүснэгт 6.2.1. Гэдэсний халдварт өвчин, бодит тоо, 10 000 хүн амд, 2012-2013 он**

Халдварт өвчин /ӨОУА-10 нэршлээр/	2012		2013		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Балнад	0	0.0	0	0.0	0.0
Сальмонеллэз	112	0.4	83	0.3	-0.1
Цусан суулга	2051	7.3	1982	7.0	-0.3
Хүнсний гаралтай бактерт хордлого	719	2.6	238	0.8	-1.8
Суулгалт халдвар	86	0.3	84	0.3	0.0
Цочмог А хепатит	5892	21.0	1589	5.7	-15.3
Гар-хөл-амны өвчин	405	1.4	1374	4.9	3.5

**6.2.1. Бактерийн гаралтай бусад хоолны хордлого**

2013 онд улсын хэмжээнд бактерийн гаралтай бусад хоолны хордлогот халдварын нийт 238 тохиолдол буюу 10 000 хүн амд 0.8 бүртгэгдсэн нь нийт гэдэсний халдварт өвчний дотор 4.4% эзэлж байна. Үүнээс Улаанбаатар хотод 121 (51%) тохиолдол буюу 10 000 хүн амд 1.0 бүртгэгдсэн байна.

2013 оны Улаанбаатар хотод бүртгэгдсэн бактерийн гаралтай бусад хоолны хордлогот халдварын өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад 512 тохиолдол буюу 4.3-аар буурч, аймгуудад 31 тохиолдол буюу 0.3-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өвчлөгсдийн 35 хувийг ажил эрхэлж буй хүмүүс эзэлжээ.

/Эх сурвалж: ХӨСҮТ-ийн 2013 оны тайлан/

**6.2.2. Вирус хепатит**

Улсын хэмжээнд вирус хепатит өвчний 2 537 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 6.8 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 4 319 тохиолдлоор буурсан байна.

Нийт вирус хепатит өвчний 62.6 хувийг цочмог А хепатит, 24.2 хувийг цочмог В хепатит, 13.2 хувийг бусад вирус хепатит тус тус эзэлж байна.

Нийт вирус хепатит өвчнийг өмнөх онтой харьцуулахад 10 000 хүн амд цочмог А хепатит 15.3-аар, цочмог С хепатит 0.2-оор буурсан үзүүлэлттэй байна. Манай улсын хувьд сүүлийн 10 жилд бүртгэгдсэн цочмог А хепатитын өвчлөлийн байдлыг авч үзэхэд 2011 онд хамгийн их буюу 10 000 хүн амд 49.0 байжээ. Цочмог А хепатит нь 2-9 насныханд хамгийн өндөр бүртгэгдэж, бүх насныхны дунд өвчлөл буурсан ба эрэгтэйчүүд нь илүү өвдсөн байна.


Нийт өвчлөлийн 59.5 хувийг сургууль, цэцэрлэгийн хүүхдийн өвчлөл эзэлж байна. Цочмог В хепатитын өвчлөлийг нас, хүйсний байдлаар авч үзэхэд, 15-34 насанд өвчлөл их бүртгэгдэж, эрэгтэйчүүд зонхилон өвчилсөн байна. Нийгмийн байдлаар нь авч үзэхэд ажилгүй, оюутан, ажилчин, албан хаагчдын дунд өвчлөл өндөр бүртгэгдсэн байна.

/Эх сурвалж: ХӨСҮТ-ийн 2013 оны тайлан/

**Хүснэгт 6.2.2. Вирус хепатит, 10 000 хүн амд /улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудаар, 2012-2013 он**

Аймаг	2012		2013		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Өмнөговь	293	55.8	99	18.9	-36.9
Архангай	281	31	135	14.9	-16.1
Сэлэнгэ	333	31.1	146	13.6	-17.5
Дархан-уул	277	30	124	13.5	-16.5
Өвөрхангай	338	29	122	10.5	-18.5
Улаанбаатар	2 718	22.9	1 207	10.2	-12.7
Увс	232	30	74	9.6	-20.4
<b>Улсын дүн</b>	<b>6 856</b>	<b>24.4</b>	<b>2 537</b>	<b>9.0</b>	<b>-15.4</b>

**Зураг 6.2.1. Вирус хепатит, 10 000 хүн амд, 2003-2013 он**



**6.3. Амьсгалын замын халдварт өвчин**

Амьсгалын замын халдварт өвчний 14 529 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 38.9 хувийг эзэлж байна. Нийт өвчний дотор сүрьеэ (28.3%), салхинцэцэг (32.1%), гахай хавдар (36.3%)-ын халдвар зонхилох хувийг эзэлж байна.

2012 онтой харьцуулахад 10 000 хүн амд гахай хавдар 13.5, улаанууд 0.7, ёлом 0.2-оор буурч, салхинцэцэг 6.6-аар, улаан эсэргэнэ 0.7-оор, сүрьеэ 0.3, халдварт эретима 0.1-ээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 6.3.1. Амьсгалын замын халдварт өвчин, бодит тоо, 10 000 хүн амд, 2012-2013 он**

Халдварт өвчин /ӨОУА-10 нэршлээр/	2012		2013		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Сүрьеэ	3 944	13.9	4 111	14.2	0.3
Улаан эсэргэнэ	89	0.3	271	1.0	0.7
Менингококкт халдвар	28	0.1	40	0.1	0.0
Салхин цэцэг	2 806	10.0	4 669	16.6	6.6
Улаанбурхан	0	0.0	0	0.0	0.0
Улаанууд	215	0.8	15	0.1	-0.7
Гахай хавдар	9 060	32.2	5 268	18.7	-13.5
Ёлом	201	0.7	137	0.5	-0.2
Хийт үхжил	0	0.0	3	0.0	0.0
Халдварт эритема	11	0.0	15	0.1	0.1

**6.3.1. Сүрьеэ**

Сүрьеэ өвчний нийт 4 111 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 11.0 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод өвчлөлийн 2 403 тохиолдол байгаа нь сүрьеэгийн нийт өвчлөлийн 58.5 хувийг эзэлж байна.

Уушгины түрхэц эерэг шинэ сүрьеэ 1 622 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 94 тохиолдлоор буурсан байна.

Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын 57.3 хувийг уушгины сүрьеэ, 42.7 хувийг бусад эрхтний сүрьеэ эзэлж байна.


**Хүснэгт 6.3.2. Сүрьеэ өвчин, 10 000 хүн амд, улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудаар, 2012-2013 он**

Аймаг	2012		2013		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Дархан-Уул	249	27.0	230	25.0	-2.0
Сэлэнгэ	209	19.5	231	21.6	2.1
Дорнод	137	18.6	151	20.5	1.9
Улаанбаатар	2261	19.1	2403	20.3	1.2
Сүхбаатар	78	14.2	87	15.8	1.6
<b>Улсын дүн</b>	<b>3944</b>	<b>13.9</b>	<b>4111</b>	<b>14.2</b>	<b>0.3</b>


**Шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлыг насаар нь авч үзвэл:**

Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлыг насаар нь авч үзвэл 16-44 насныхан 68.7 хувийг эзэлж байгаа бол эрэгтэйчүүд 55.4 хувь, эмэгтэйчүүд 44.6 хувийг тус тус эзэлж байна.

**Зураг 6.3.1. Сүрьеэгийн өвчлөл, нас баралт, 2003-2013 он**



**Зураг 6.3.2. Сүрьеэ өвчний оношийн баталгаажилт хувиар, 2013**



2013 оны байдлаар оношийн баталгаажилт 71.5 хувь, эдгэрэлтийн түвшин 80.1 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад оношийн баталгаажилт 4 хувь, эдгэрэлтийн түвшин 2.6 хувиар тус тус буурсан байна.

**6.3.2. Гахай хавдар өвчин**


Улсын хэмжээнд гахай хавдар өвчний 5 268 тохиолдол буюу 10 000 хүн амд 18.7 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 3 792 тохиолдлоор буюу 10 000 хүн амд 13.5-аар буурсан байна. Нийт халдварт өвчний дотор гахай хавдар өвчний эзлэх хувь 14.1 хувь байна.

10 000 хүн амд ногдох өвчлөл Завхан /53.1/, Хөвсгөл /42.6/, Өвөрхангай /60.4/, Хэнтий /35.4/, Говьсүмбэр /21.8/, Булган /23.8/, Сүхбаатар /42.0/, Архангай /17.3/, Баян-Өлгий /9.2/, Баянхонгор /12.9/, Увс /5.2/, Дорноговь /10.1/, Дархан-уул /4.9/, Дорнод /67.8/, Дундговь /8.4/, Өмнөговь /0.8/ аймгуудад өмнөх онтой харьцуулахад /0.2-43.4/-өөр ихэссэн байна. Нийт өвчлөлийн 28.2 хувийг Улаанбаатар хотод бүртгэгдсэн өвчлөл эзэлж, 10 000 хүн амд өвчлөл өнгөрсөн оны мөн үеэс 46.3-аар буурсан байна.

2013 онд бүртгэгдсэн гахай хавдар өвчин бүх насныхны дунд бүртгэгдсэн ба өвчлөгсдийн 82.5 хувийг сургуулийн насны хүүхдийн өвчлөл эзэлж байна. Насны бүлгээр авч үзвэл 5-19 насны эрэгтэй хүүхдүүдийн дунд өвчлөл өндөр байна.

2013 онд бүртгэгдсэн гахай хавдрын 68.8 хувийг сургуулийн сурагчид, 7.7 хувийг цэцэрлэгт хүмүүждэг хүүхэд эзэлж байна.


**Зураг 6.3.3. Гахай хавдар өвчний хөдлөл зүй, 10 000 хүн амд, 1996-2013 он**



Улсын хэмжээнд 1996-2013 онд бүртгэгдсэн гахай хавдар өвчлөлийн хөдлөл зүйгээс харахад 3-4 жилийн давтамж ажиглагдаж байна.

Гахай хавдрын өвчлөлийн улиралчлалыг авч үзэхэд өмнөх онд өвчлөл 3-6 дугаар сард нэмэгдсэн бол 2013 онд 1, 4, 5 дугаар саруудад өвчлөл нэмэгдсэн байна. /Зураг 6.3.4/

**Зураг 6.3.4. Гахай хавдар өвчин, улирлаар, 2013 он**



### 6.3.3. Салхинцэцэг өвчин

Энэ онд салхинцэцэг өвчний нийт 4 669 тохиолдол буюу 10 000 хүн амд 16.6 тохиолдол бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад 6.6-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2013 онд 10 000 хүн амд Дорнод /61.7/, Дорноговь /44.3/, Өмнөговь /33.7/, Хэнтий /22.9/, Улаанбаатар /21.5/, Сүхбаатар /18.9/, Говьсүмбэр /16.9/ аймаг, хотод салхинцэцэг өвчин улсын дундаж /16.6/-аас дээгүүр байна. Салхинцэцэг өвчнийг өмнөх онтой харьцуулахад Баянхонгор, Ховд, Говь-Алтай, Увс, Булган, Орхон аймгуудад 0.2-4.9 промилль-оор тус тус буурсан, бусад аймаг болон Улаанбаатар хотод 0.1-33.9 промилль-оор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Салхинцэцэг өвчин 75.2% (3 511 тохиолдол) нь 0-15 хүртэлх насны хүүхдүүдийн дунд бүртгэгдсэн байна.

### 6.4 Бэлгийн замаар дамжих халдвар

Бэлгийн замаар дамжих халдварын 14 904 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 39.9 хувийг эзэлж, өнгөрсөн онтой харьцуулахад 414 тохиолдол буюу 10 000 хүн амд 1.5-аар нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн өвчлөлийн 32.5 хувийг заг хүйтэн, 41.9 хувийг тэмбүү, 25.4 хувийг трихомониаз, 0.2 хувийг ХДХВ/ДОХ өвчин тус тус эзэлж байна.


#### Хүснэгт 6.4.1. Бэлгийн замаар дамжих халдвар, бодит тоо, 10 000 хүн амд, 2012-2013 он

Халдварт өвчин /ӨОУА-10 нэршлээр/	2012		2013		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Тэмбүү	4954	17.8	6246	22.2	4.4
Заг хүйтэн	5351	19.2	4842	17.2	-2.0
Трихомониаз	4158	15.0	3793	13.5	-1.5
ХДХВ/ДОХ	27	0.1	23	0.1	0.0

10 000 хүн амд ногдох тэмбүүгийн өвчлөл Дорнод(70.6), Говьсүмбэр(44.3), Сүхбаатар (37.3), Хөвсгөл (28.1), Улаанбаатар (27.4), Баянхонгор (24.8), Дархан-уул (19.7), Дорноговь (19.0), Орхон (18.9) аймгууд болон Улаанбаатар (27.4) хотод, заг хүйтэн Дорнод (118.8), Дорноговь (40.5), Сүхбаатар (35.8), Баянхонгор (30.0), Хөвсгөл (25.7), Сэлэнгэ (19.5) аймгуудад, трихомониазын өвчлөл Дорнод (50.2), Дорноговь (30.3), Баянхонгор (28.1), Дундговь (22.9), Сүхбаатар (20.4), Ховд (17.2), Хэнтий (15.3), Булган (12.5) аймгууд болон Улаанбаатар хот (15.4)-д улс болон аймгийн дунджаас өндөр байна.

2013 онд төрөлхийн тэмбүүгийн 26 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 2 тохиолдлоор буурсан байна. Төрөлхийн тэмбүүгийн өвчлөл Баян-Өлгий аймагт-1, Дорнод аймагт-4, Орхон аймагт-3, Өвөрхангай-3, Хэнтий аймагт-1, Улаанбаатар хотод-14 тохиолдол бүртгэгдсэн байна.

2013 онд жирэмсэн эмэгтэйчүүдэд хийсэн үзлэгээр тэмбүү 1 600 (1.9%), заг хүйтэн 538 (0.7%), трихомониаз 1 425 (1.9%) тохиолдол тус тус илэрсэн байна.

**Зураг 6.4.1. Бэлгийн замаар дамжих халдвар, 10 000 хүн амд, 2011-2013 он**

2013 оны байдлаар зонхилон тохиолдох БЗДХ-аар өвчлөгсдийн 64.8% нь эмэгтэй, 35.2% нь эрэгтэй байна. Насны ангиллаар авч үзэхэд 0.5% нь 0-4 насны, 0.6% нь 5-14 насны, 45.4% нь 15-24 насны, 49.5% нь 25-44 насны, 3.8% нь 45-64 насны, 0.1% нь 65-аас дээш насны хүмүүс байна.

Монгол улсын хэмжээнд ХДХВ/ДОХ-ын нийт 150 тохиолдол албан ёсоор бүртгэгдсэнээс 2013 оны байдлаар 23 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд нийт тохиолдлуудад ХДХВ-ийн халдвар бэлгийн замаар дамжсан байна. 23 тохиолдлын 20 (87.0) нь Улаанбаатар хотоос, 3 (13.0%) нь хөдөө орон нутгаас оношлогдсон бөгөөд 78.2% нь шинж тэмдэггүй ХДХВ-ийн халдварын үедээ, 21.8% нь ДОХ-ын шатандаа оношлогджээ.

ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 19 (82.6%) нь эрэгтэй, 4 нь (17.4%) эмэгтэй байна. ХДХВ-ийн халдварын 15 (65.2%) тохиолдол нь өвчний учир амбулаториор, 1 (4.4%) тохиолдол нь тандалтаар, 1 (4.4%) тохиолдол нь сайн дурын зөвлөгөө шинжилгээний кабинетээр, 6 (26.1%) тохиолдол нь урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн байна.

### 6.5. Халдварт өвчний нас баралт

Халдварт өвчний шалтгаант нас баралтын 145 тохиолдол бүртгэгдсэн байна. Нийт нас баралтын тохиолдлыг шалтгаанаар авч үзвэл сүрьеэ-117, менингококкт халдвар-7, вирүст гепатит-9, хачигт энцефалит-2, төрөлхийн тэмбүү-3, ХДХВ/ДОХ-ын 2, хүнсний гаралтай бактерт халдвар, хийт үхжил, салхинцэцэг, галзуу, улаанууд, шалтгаанаар нас баралтын тус тус 1 хүн нас барсан байна.

## БҮЛЭГ 7. ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

### ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлэгт хүн амын дундах халдварт бус өвчний тэргүүлэх 5 шалтгаан түүний дотор зонхилон тохиолдож байгаа өвчлөлийг нас, хүйс, хот, хөдөөгийн байршлаар нь 10 хүртэлх жилийн байдлаар тооцсон үзүүлэлтүүд багтсан болно.

Өвчлөлийн тухай мэдээг эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт үнэлгээ хийх, тархварзүйн судалгаа хийх, эрсдэлт хүн амыг тогтоох, эмнэлзүйн судалгаа, шинжилгээний ажлын нотолгоо болох зэрэг эрүүл мэндийн мэдээллийн үнэтэй эх сурвалж болгон ашигладаг.

Өвчний олон улсын ангиллыг анх Английн дүн бүртгэлийн ерөнхий газрын статистикч эмч Уильям Фаррын 1855 онд боловсруулсан ангилалд суурилан гаргаснаас хойш ДЭМБ хөгжүүлэн улс орнуудад хэрэглэж иржээ. ӨОУА-10 ангиллыг манай улс 1993 оноос эхлэн нэвтрүүлж, 2013 оноос 4 тэмдэглэгээт ангиллыг хэрэглэж байна.

Халдварт бус өвчнийг үндсэн өвчнөөр бүртгэх бөгөөд энэ нь өвчтөнийг эмчилгээ, оношлогоо хийлгэхэд хүргэсэн төгсгөлийн оношоор нь бүртгэн авч мэдээлж байна.

Хэрэв ийм өвчин эмгэг нэгээс олон илэрсэн тохиолдолд хамгийн их зардал гаргасныг үндсэн өвчнөөр сонгож авдаг. Хэрэв онош тавигдаагүй бол гол шинж тэмдэг, лабораторийн хэвийн бус үзүүлэлтийг үндсэн эмгэгээр сонгоно. Иймд өвчний оношийг ӨОУА-ын дагуу кодлохоор эмч нар маш тодорхой бичих нь зүйтэй.

Мөн гэмтэл, хордлого, гадны шатгааны бусад үр дагаврын үед тухайн өвчин эмгэг болон түүнд хүргэсэн нөхцөл байдлыг дэлгэрэнгүй бичихийг эмч нартаа зөвлөж байна.

Амбулаторит бүртгэгдсэн өвчлөлийн түвшингээр тэргүүлж буй эхний 5 эмгэг (Өвчний олон улсын 10 дугаар ангиллын дагуу) –ээр хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааныг тооцно.

**Зүрх судасны тогтолцооны өвчний тархалтын түвшин** - тайлангийн жилд зүрх судасны тогтолцооны өвчтэй гэж бүртгэгдсэн нийт өвчтөний тоог 10 000 хүн амд харьцуулсан үзүүлэлт

**Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн түвшингээр тэргүүлж буй эхний 10 эмгэг** - Тайлангийн жилд стационарт өвчлөлийн тэргүүлэх шалтгаанаар хэвтэн эмчлүүлэгчдийн тоог 10 000 хүн амд харьцуулсан үзүүлэлт



## БҮЛЭГ 7. ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

### 7.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан

Өнөөдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүмүүсийг өвдсөн хойно эмнэлэгт хандах бус өвдөхөөс урьдчилан сэргийлэхийг зөвлөж байна. Дэлхийн хүн амын нас баралтын шалтгааны 63 хувь нь халдварт бус өвчнөөр буюу 36 сая хүний 14 сая нь 30-70 насны хооронд нас барж байна.

Халдварт бус өвчнийг бууруулах талаар ДЭМБ-аас түүний эрсдэлт хүчин зүйл болсон архи, тамхины хэрэглээг бууруулах, зөв хооллолт, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэхэд анхаарч дэлхийн олон улсын байгууллагуудтай тамхины татвар, хяналтыг сайжруулах, хүнсэнд давс, сахарын хэрэглээг багасгах зэргээр хамтран ажиллахаар ДЭМБ 2013-2020 он хүртэлх Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах төлөвлөгөөндөө тусгасан байна.

Мөн улс орнууд халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах төлөвлөгөөндөө бусад салбар тухайлбал: хөдөө аж ахуй, харилцаа холбоо, боловсрол, эрчим хүч, байгаль орчин, эдийн засаг, худалдаа аж үйлдвэр, хууль, урлаг, спорт, тээвэр зэрэг нийгэм эдийн засгийн салбар хоорондын хамтын ажиллагааг хамруулах тухай зөвлөмж гаргажээ.

Халдварт бус өвчний дээр дурьдсан эрсдэлт хүчин зүйлүүдээс гадна эхийн эрүүл мэнд, хүүхдийн хоол тэжээл, өсөлт хөгжил, өсвөр үеийнхний хоол тэжээл, хорт зуршлаас сэргийлэх зэрэг нь амьдралын хожуу үед халдварт бус өвчнөөр өвчлөхгүй байхад нөлөөлнө гэжээ.


Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах дэлхий нийтээр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 9 зорилт, 25 шалгуур үзүүлэлтийг авч үзжээ. Үүнд:

1. Халдварт бус өвчний нас баралтыг бууруулах
2. Архины хэрэглээг бууруулах
3. Хөдөлгөөний дутагдлыг бууруулах
4. Хүн амын дундах давс, сахарын хэрэглээг бууруулах
5. 15-аас дээш насныхны тамхины хэрэглээг бууруулах
6. Цусны даралтыг хянах, даралт ихсэх өвчний тархалтыг бууруулах
7. Чихрийн шижин өвчний тархалтыг бууруулах
8. Зүрхний хурц, хүнд өвчнийг эмийн эмчилгээний тогтмол хяналт дор бууруулах
9. Халдварт бус өвчний эмчилгээ, технологийг анхан шатны түвшинд сайжруулах тухай

Эх сурвалж: WHO, Global NCD Action plan, 2013-2020

Манай улсын хүн амын дунд халдварт бус өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж байгаа өвчлөл 2003 онтой харьцуулахад 10 000 хүн амд 1-2.5 дахин нэмэгджээ.

**Зураг 7.1.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд, 2003-2013 он**



2013 оны байдлаар 10 000 хүн амд амьсгалын тогтолцооны өвчин 1 339.4, хоол боловсруулах тогтолцооны өвчин 1 056.8, шээс бэлгийн тогтолцооны эмгэг 773.0, зүрх-судасны тогтолцооны өвчин 848.1, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг 578.4 ногдож байгаа бөгөөд 2012 онтой харьцуулахад амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчин, зүрх-судасны тогтолцооны өвчин, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг, шээс бэлгийн тогтолцооны эмгэгийн түвшин нэмэгджээ. (Зураг 7.1.1)

2013 оны байдлаар хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд:

- Амьсгалын тогтолцооны өвчин, 1 339.4
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин, 1 056.8
- Зүрх-судасны тогтолцооны өвчин, 848.1
- Шээс бэлгийн тогтолцооны эмгэг, 773.0
- Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг, 578.4

2013 онд хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг байршлаар авч үзвэл хотод амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчин, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчин, зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлэх 3 шалтгаанд орж байна. Тухайлбал 10 000 хүн амд ногдох амьсгалын тогтолцооны өвчин хотод 1 540.3, хөдөөд 1 165.6, хоол боловсруулах тогтолцооны өвчин хотод 1 027.0, хөдөөд 1 082.6, шээс бэлгийн тогтолцооны эмгэг хотод 654.1, хөдөөд 875.9, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг хотод 929.0, хөдөөд 275.0 ногдож байна.

**Хүснэгт 7.1.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2013 он**


	Нийт өвчлөл	Амьсгалын тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	5567.4	1267.7	851.2	349.7	661.2	751.6
Эмэгтэй	8534.5	1407.3	1251.4	1173.7	1023.8	414.6
<b>Насны бүлэг</b>						
20 хүртэл	5372.1	2483.8	796.7	203.5	40.5	468.4
20-44	6437.5	569.0	923.0	1069.6	437.9	674.2
45-65	10736.4	856.0	1767.7	1204.3	2551.8	619.0
65 ба түүнээс дээш	16575.4	1422.3	2190.6	1226.3	5835.7	535.9
<b>Байршил</b>						
Хот	7949.9	1540.3	1027.0	654.1	768.5	929.0
Хөдөө	6349.0	1165.6	1082.6	875.9	917.0	275.0
<b>Бүсээр</b>						
Баруун	5780.7	1124.2	929.5	925.7	858.2	172.1
Хангайн	6474.5	1033.8	1074.8	935.0	1000.4	248.1
Төв	6591.5	1260.4	1087.0	848.8	964.1	369.5
Зүүн	6481.9	1377.2	1382.6	684.5	681.9	312.8
<b>Улсын дүн</b>	<b>7091.8</b>	<b>1339.4</b>	<b>1056.8</b>	<b>773.0</b>	<b>848.1</b>	<b>578.4</b>

10 000 эмэгтэй хүн амд ногдох өвчлөлийн түвшин эрэгтэй хүн амтай харьцуулахад 1.5 дахин их байна. Өвчлөлийн шалтгаанаар авч үзвэл эрэгтэйчүүдийн гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант тодорхой эмгэгийн улмаас амбулаторит үзүүлж, эмчлүүлсэн өвчлөлийн түвшин эмэгтэйчүүдтэй харьцуулахад 1.8 дахин их, бусад өвчлөлийн хувьд өвчлөлийн түвшин 1.1-3.4 дахин бага байна.

Хүн амын өвчлөлийг бүс нутгаар авч үзвэл баруун бүсэд амьсгалын тогтолцооны өвчин 1 124.2, хоол боловсруулах тогтолцооны өвчин 929.5, шээс бэлгийн тогтолцооны эмгэг 925.7, хангайн бүсэд амьсгалын тогтолцооны өвчин 1 033.8, хоол боловсруулах тогтолцооны өвчин 1 074.8, зүрх судасны тогтолцооны өвчин 1 000.4, төвийн болон зүүн бүсэд амьсгалын тогтолцооны өвчин 1 260.4 ба 1 377.2, хоол боловсруулах тогтолцооны өвчин 1 087.0 ба 1 382.6, шээс бэлгийн тогтолцооны эмгэг 848.8 ба 684.5 байгаа нь тэргүүлэх 3 шалтгаанд орж байна.


Мөн амьсгалын тогтолцооны өвчин зүүн болон төвийн бүсэд, хоол боловсруулах тогтолцооны өвчин зүүн болон төвийн бүсэд, шээс бэлгийн тогтолцооны эмгэг хангайн болон баруун бүсэд, зүрх судасны тогтолцооны өвчин хангайн болон төвийн бүсэд, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг төвийн болон зүүн бүсэд бусад бүсүүдтэй харьцуулахад өндөр байна.

### Зураг 7.1.2. Чихрийн шижин өвчин, хүйсээр, бүсээр, 10 000 хүн амд, 2013 он



Чихрийн шижин өвчин нийт халдварт бус өвчний дотор 0.84 хувийг эзэлж, 10 000 хүн амд 58.3 байгаа нь өмнөх оноос 8.4-оор нэмэгджээ. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд 10 000 хүн амд 56.4, эмэгтэйчүүд 10 000 хүн амд 60.1 байна. Насны бүлгээр нь авч үзэхэд 45-65 насныханд хамгийн өндөр тохиолдож 10 365 буюу 10 000 хүн амд 222.7 тохиолдож өнгөрсөн оноос 30.1-аар нэмэгдсэн байна. Байршлаар нь үзэхэд Төвийн бүсэд 10 000 хүн амд 57.3 буюу хамгийн өндөр тохиолдож байна. Төвийн бүсийн аймгууд дотроос Дархан-уул /88.8/, Дундговь /57.0/, Сэлэнгэ /53.8/ аймгуудад өндөр байна.

### Зураг 7.1.3. Цусны даралт ихсэх өвчин, хүйсээр, бүсээр, 10 000 хүн амд, 2013 он



Цусны даралт ихсэх өвчин нийт өвчлөлийн 5.4 хувийг эзэлж, 10 000 хүн амд 379.9 байна. Хүйсийн хувьд эмэгтэйд илүү тохиолдож харин насны бүлгээр нь авч үзэхэд 45-65 насанд 10 000 хүн амд 1 317.7 болон 65-аас дээш насанд 10 000 хүн амд 2 852.2 тохиолдож, хөдөлмөрийн насны хүмүүст өнгөрсөн оны мөн үеэс 15.6-аар нэмэгдсэн байна. Байршлаар нь үзэхэд Хангайн бүс нутгийн хүн амд илүүтэй энэ өвчлөлөөр өвдөж байгаа бөгөөд Баянхонгор /660.1/, Архангай /603.9/, Өвөрхангай /507.7/ аймгуудад өндөр байна.

## 7.2. Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан

2013 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд:

- Амьсгалын тогтолцооны өвчин, 352.4
- Зүрх-судасны тогтолцооны өвчин, 385.7
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин, 332.0
- Шээс бэлгийн тогтолцооны өвчин, 301.9
- Мэдрэлийн тогтолцооны өвчин 174.3 тус тус орж байна.

### Хүснэгт 7.2.1. Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2013 он

	Нийт өвчлөл	Амьсгалын тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Мэдрэлийн тогтолцооны өвчин
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	1882.9	367.2	312.1	162.8	322.3	151.8
Эмэгтэй	3142.7	338.3	350.9	433.5	445.7	195.6
<b>Насны бүлэг</b>						
20 хүртэл	1546.2	705.4	228.4	88.0	18.8	81.1
20-44	2465.4	99.5	262.8	381.6	166.0	163.6
45-65	3837.4	204.0	620.2	493.3	1121.0	342.2
65 ба түүнээс дээш	7501.8	524.8	913.8	695.1	3177.6	492.7
<b>Байршил</b>						
Хот	2750.2	356.0	383.0	272.2	383.0	183.3
Хөдөө	2339.6	349.2	287.9	327.6	388.0	166.5
<b>Бүсээр</b>						
Баруун	2754.2	380.7	367.7	416.6	441.2	227.8
Хангайн	2272.2	312.1	278.8	331.0	414.2	147.0
Төв	2090.0	355.1	233.3	284.6	342.9	146.3
Зүүн	2353.6	377.6	295.6	255.6	325.0	153.9
<b>Улсын дүн</b>	<b>2530.2</b>	<b>352.4</b>	<b>332.0</b>	<b>301.9</b>	<b>385.7</b>	<b>174.3</b>

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийг хүйсээр авч үзвэл 10 000 эрэгтэй хүн амд 1 882.9, 10 000 эмэгтэй хүн амд 3 142.8 ногдож, ойролцоогоор эмнэлэгт хэвтэж байгаа 2 хүний нэг нь эрэгтэйчүүд байна. 10 000 эрэгтэй хүн амд ногдох хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн түвшин 10 000 эмэгтэй хүн амд ногдох стационарын өвчлөлийн түвшингээс 1.7 дахин бага байна.

2013 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны дотор зонхилж буй өвчнүүдийг авч үзвэл: шээс бэлгийн тогтолцооны эмгэгийн улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 66.1 хувийг бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин, амьсгалын тогтолцооны өвчний дотор уушгины хатгалгааны улмаас хэвтэн эмчлүүлэгчид 46.1 хувийг, хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор элэгний эмгэг 27.0 хувийг, зүрх судасны тогтолцооны өвчний дотор даралт ихсэх өвчин 37.6 хувийг, зүрхний ишеми өвчин 26.7 хувийг тус тус эзэлж эдгээр өвчнүүд хүн амын дунд зонхилон тохиолдож байна.

Бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин нь 2003 онд шээс бэлгийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 63.1 хувийг эзэлж байсан бол 2007 онд 67.8 болж, 2012 онтой харьцуулахад 2013 онд 1.0-оор буурсан байна.

**Хүснэгт 7.2.2. Хэвтэн эмчлүүлэгчдийн зонхилон тохиолдох өвчлөл, хувиар, 2003-2013 он**

Өвчний ангилал (ӨОУА-10)	Зонхилох шалтгаан	Өвчлөлийн тухайн бүлэгт эзлэх хувь										
		2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	Бөөрний сувганцрын үрэвсэл (N10-N16)	63.1	65.4	69.1	69.7	67.8	69.1	66.6	68.3	67.4	67.1	66.1
Амьсгалын тогтолцооны өвчин	Хатгалгаа (J12-J18)	42.7	43.2	39.8	38.6	40.5	41.9	38.8	44.8	46.2	46.9	46.1
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Элэгний эмгэг (K70-K77)	21.8	23.7	25.7	24.9	25.1	25.6	25.7	25.2	26.1	26.6	27.0
	Мухар олгойн өвчин (K35-K38)	22.7	21.4	20.2	19.4	18.6	17	16.9	16.7	15.4	14.6	14.1
	Цэсний хүүдийн өвчнүүд (K80-K81)	16.5	15.8	15.6	15.3	13.97	13.7	14.2	13.8	14.2	14.3	14.6
Зүрх-судасны тогтолцооны өвчин	Даралт ихсэх өвчнүүд (I10-I15)	32.4	32.3	31.3	32.6	32.1	33.2	34.4	36.6	36.8	37.7	37.6
	Зүрхний ишеми өвчнүүд (I20,I23-I25)	23.5	25.7	26.3	26.3	29.3	30.1	29.5	26.6	26	26.1	26.7
Мэдрэлийн тогтолцооны өвчин	Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг (G50-G59)	20.9	20.5	23.4	21.7	22.1	24.3	26.0	26.7	28.8	30.9	33.8
	Эпилепси (G40-G41)	12.6	12.9	12.4	12.5	11.7	11.2	10.9	13.3	12.6	12.1	11.4

Уушгины хатгалгаа өвчин 2003 онд амьсгалын тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 42.7 хувийг эзэлж байсан бол 2007 онд 40.5 хувь болж, 2012 онтой харьцуулахад 2013 онд 0.8-оор буурсан байна.

2003 онд хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор 21.8 хувийг элэгний эмгэг, 16.5 хувийг цэсний хүүдийн өвчнүүд эзэлж байсан бол 2013 онд элэгний эмгэг 27.0 хувь болж нэмэгдэн, цэсний хүүдийн өвчнүүд 14.6 хувийг эзэлж байна.

Зүрхний ишеми өвчин нь 2003 онд зүрх-судасны тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 23.5 хувийг эзэлж байсан бол 2013 онд 26.7 болжээ.

## Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг

2013 оны байдлаар артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 243 163 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 38.5 хувийг эзэлж байна. Хамрагдалтын хувь 2012 оны түвшинд байна. Нийт үзлэгт хамрагдсан хүн амын 41.5 хувь нь эрэгтэй, 58.5 хувь нь эмэгтэй байна. Хамрагдалтын хувийг хүйсээр авч үзэхэд үзлэгт хамрагдвал зохих нийт эрэгтэй хүн амын 34.0 хувь, эмэгтэй хүн амын 42.3 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан байна.

Эрт илрүүлгийн үзлэгийн үр дүнгийн үзүүлэлтээр 70.8 хувь нь хэвийн, 12.9 хувь нь артерийн даралттай байж болох гэж давтан үзлэгт ирүүлэхээр уригдсан байна. Эрт илрүүлгийн давтан үзлэгт нийт 46 836 хүн хамрагдаж 11 158 буюу нийт үзлэгээс 4.6% Артерийн даралт ихсэх өвчний онош батлагдсан байна.

Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 223 039 хүн хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 35.3 хувийг эзэлж байна. Үр дүнгийн үзүүлэлтээр хэвийн 89.3%, өлөн үеийн глюкозын өөрчлөлттэй 4.6% илэрч хоёрдогч шатлалын эмнэлэгт онош батлуулахаар илгээсэн байна.

### 7.2.3. Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүний тоо, аймгаар, 2013 он

Аймаг, хот	Артерийн даралт ихсэх, эрт илрүүлэг үзлэг		Чихрийн шижин хэв шинж 2, эрт илрүүлэг үзлэг	
	Хамрагдсан хувь	Онош батлагдсан хувь	Хамрагдсан хувь	Онош батлагдсан хувь
Архангай	61.1	5.5	54.8	0.3
Баян-Өлгий	28.5	27.6	9.8	8.7
Баянхонгор	58.1	3.9	51.7	0.6
Булган	54.2	8.2	54.2	0.8
Говь-Алтай	31.6	0.5	31.5	0.4
Говьсүмбэр	14.8	0.2	14.8	0.0
Дархан-Уул	100.0	2.7	77.5	0.1
Дорноговь	72.8	5.4	72.6	0.7
Дорнод	20.8	6.5	19.1	0.8
Дундговь	43.5	3.0	42.9	0.9
Завхан	19.9	7.8	16.0	0.4
Орхон	25.9	2.4	20.5	1.2
Өвөрхангай	78.6	7.4	76.1	0.3
Өмнөговь	67.1	3.9	65.5	0.2
Сүхбаатар	71.0	3.5	70.9	0.3
Сэлэнгэ	20.1	9.2	12.5	1.0
Төв	45.2	3.4	39.4	0.7
Увс	51.0	1.7	50.0	0.4
Ховд	38.3	7.1	33.9	0.8
Хөвсгөл	29.7	5.6	26.8	0.1
Хэнтий	24.7	2.6	24.7	0.6
<b>Аймгийн дүн</b>	<b>46.5</b>	<b>5.4</b>	<b>41.2</b>	<b>0.6</b>
Улаанбаатар	28.5	3.0	28.0	0.8
<b>Улсын дүн</b>	<b>38.5</b>	<b>4.6</b>	<b>35.3</b>	<b>0.6</b>

Чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалтын хувийг хүйсээр авч үзэхэд үзлэгт хамрагдвал зохих нийт эрэгтэй хүн амын 31.4 хувь, эмэгтэй хүн амын Эрүүл мэндийн үзүүлэлт, 2013

38.8 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан байна.

Чихрийн шижин эрт илрүүлгийн давтан үзлэгт 37 889 хүн хамрагдаж 1414 хүн буюу нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 0.6 хувь нь чихрийн шижин хэв шинж 2 өвчний тохиолдол батлагдсан байна.

### **Умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэг**

Монгол улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас 2008-2013 оны хооронд хэрэгжүүлж буй “Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр”-ийн зорилтот ажлын хүрээнд “Хавдрын бүртгэл, Эргэн дуудах тогтолцоо” төсөл хэрэгжиж, улсын хэмжээнд анх удаа умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийг эхлүүлж, эргэн дуудах тогтолцоог нэвтрүүлж байна.

Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч нарын тайланд дүн шинжилгээ хийж үзэхэд умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт энэ онд зорилтот болон зорилтот бус насны нийт 78 930 эмэгтэй хамрагдсанаас, хамрагдвал зохих зорилтот /30, 33, 36, 39, 42, 45, 48, 51, 54, 57, 60/ насны 70 639 эмэгтэй (51.6 хувь) хамрагджээ. Харин урилга хүлээн авсан үйлчлүүлэгчдээс хамрагдалтын хувийг тооцож үзэхэд 52.3 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан. Эдгээр хамрагдсан үйлчлүүлэгчдийн 7.6 (6 013) хувь нь Пап эерэг буюу умайн хүзүүний эсийн түвшинд өөрчлөлттэй гэж дүгнэгджээ.

Хөхний өмөнгийн боломжит эрт илрүүлэгт 130 039 эмэгтэй хамрагдсанаас 1.6 хувьд нь хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг буюу хөхөндөө бэрсүү, үүсгэвэртэй гэж бүртгэгджээ. Хөхний өмөнгийн өндөр эрсдэлтэй /урьд нь өөрөө өвдөж, эмчлэгдсэн болон ээж, эгч, охин, дүү нь хөхний өмөнгөөр өвдсөн удмын дурьдатгалтай/ бүлгийн 247 эмэгтэй хамрагдсан. Хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг гарсан 2 031 тохиолдол дундаас хөхний өмөнгийн өвчлөлийн шинэ тохиолдол 26 оношлогдсон байна.



### 7.3. Мэс заслын тусламж


Улсын хэмжээнд 2013 онд нийт 98 526 өвчтөнд мэс заслын эмчилгээ хийгдсэн бөгөөд 68.6 хувь нь Улаанбаатар хотод, 31.4 хувь нь хөдөө орон нутагт хийгджээ. Нийт мэс заслын эмчилгээний 13.0 хувь буюу 12 821 тохиолдолд 15 хүртэлх насны хүүхдэд хийгдсэн байна.

#### 7.3.1. Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хийгдсэн мэс заслын тоо, 2013 он

Мэс заслын нэр	Мэс засал хийлгэсэн хүний тоо		Давтан хагалгаа	Мэс заслын дараах хүндрэл		Нас барсан	
	Бүгд	Эзлэх хувь		Бүгд	Эзлэх хувь	Бүгд	Эзлэх хувь
ЭХЭМҮТ	12266	18.1	28	16	7.2	4	1.8
НЭМГ-ын харьяа улсынэмнэлгүүд	21789	32.2	51	33	14.8	6	2.6
НЭМГ-ын харьяа хувийн эмнэлгүүд	4038	6.0	0	0	0.0	0	0.0
УНТЭ	8673	12.8	20	3	1.3	21	9.2
ГССҮТөв	7058	10.4	0	3	1.3	120	52.6
УГТЭ	4658	6.9	0	25	11.2	29	12.7
ЭМЯ-ны харьяа тусгай зөвшөөрөл бүхий хувийн эмнэлгүүд	5118	7.6	135	120	53.8	2	0.9
УХТЭ	1591	2.4	13	17	7.6	14	6.1
ХСҮТ	1863	2.8	9	6	2.7	32	14.0
ХӨСҮТ	569	0.8	26	0	0.0	0	0.0
<b>Бүгд</b>	<b>67623</b>	<b>100.0</b>	<b>282</b>	<b>223</b>	<b>100.0</b>	<b>228</b>	<b>112.9</b>

Дурангийн мэс засал 3 871 өвчтөнд хийгдсэн бөгөөд 59.5 хувийг хоол боловсруулах тогтолцооны өвчлөлд, 24.7 хувийг шээс бэлгийн тогтолцооны өвчлөлд, 11.2 хувийг эмэгтэйчүүдийн, 4.6 хувь нь бусад эрхтэн тогтолцооны өвчлөлд хийгдсэн байна.


#### Зураг 7.3.1. Мэс заслын тоо, аймгаар, 2013 он



### Хүснэгт 7.3.2. Зонхилон хийгдсэн мэс засал, төрлөөр, 2013 он


№	Мэс заслын нэр	Мэс засал хийлгэсэн хүний тоо	Үүнээс давтан хагалгаа	Мэс заслын дараах хүндрэл		Нас баралт	
				Бодит тоо	Эзлэх хувь	Бодит тоо	Эзлэх хувь
1	Цочмог мухар олгой	12415	26	37	13.0	5	1.9
2	Үе мөчний бусад мэс засал	8751	25	2	0.7	9	3.4
3	Эмэгтэйчүүдийн бусад мэс засал	6067	12	5	1.8	1	0.4
4	Нүдний бусад мэс засал	5822	103	103	36.1	0	0.0
5	Цөсний замын мэс засал	4733	17	17	6.0	14	5.3
6	Хамар хоолойн мэс засал	4647	0	0	0.0	0	0.0
7	Эрүү нүүрний мэс засал	3899	0	1	0.4	1	0.4
8	Нарийн, бүдүүн гэдэсний мэс засал	1983	49	39	13.7	46	17.5
9	Эр бэлэг эрхтний бусад мэс засал	1505	0	0	0.0	0	0.0
10	Тархи, нугасны мэс засал	1976	6	14	4.9	100	38.0

### Зураг 7.3.2. Цочмог мухар олгойн мэс засал, аймгаар, 2013 он



Улсын хэмжээгээр цочмог мухар олгойн үрэвслийн улмаас 12 415 мэс засал хийгдсэн бөгөөд харьяаллаар авч үзвэл 4 198 тохиолдол буюу 33.8 хувь нь Улаанбаатар хотод хийгджээ.

### Зураг 7.3.3. Цэсний замын мэс засал, аймгаар, 2013



Улсын хэмжээгээр цэсний замын 4 733 мэс засал хийгдсэн бөгөөд харьяаллаар авч үзвэл 3 374 тохиолдол буюу 71.3 хувь нь Улаанбаатар хотод хийгджээ.

## БҮЛЭГ 8. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

### ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлэгт Монгол Улсын хүн амын 2013 оны нас баралтын түвшин, нас баралтын тэргүүлэх 5 шалтгааныг хүйсээр, насны ангиллаар, байршлаар гарган харьцуулан тусгалаа.

Нас баралт нь тухайн нутаг дэвсгэрийн хүн амын нас, хүйсийн бүтэц, арьс өнгө, хөдөлмөр эрхлэлтийн байдал болон нийгмийн тодорхой анги бүлэг, байршил, амьжиргааны түвшин, эрүүл ахуйн нөхцөл байдал гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалан харилцан адилгүй түвшинтэй байна.

**Нас баралтын ерөнхий коэффициент (НБЕК)** нь тухайн жилийн 1 000 хүн тутамд ногдох нас баралтын тоог харуулна. Монгол Улсын 2013 оны НБЕК 5.6 гарсан байна.

Нас баралтын түвшинг насны бүлэг, хүйсээр тооцсоноор янз бүрийн насны бүлэгт, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд нас баралт харилцан адилгүй байдгийг судлах боломжтой болно. Монгол улсын хувьд 2013 оны байдлаар эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийн нас баралтаас 1.5 дахин их байна.

Нас баралтын тохиолдлыг шалтгаанаар тооцохдоо ДЭМБ-аас гаргасан нас баралтын шалтгааны ангиллыг ашигладаг. (байршил, хүйсээр, насны бүлгээр, тодорхой шалтгаанаар тооцсон нас баралтын харьцаа, хүн амын нас баралтын тэргүүлэх 10 ба 5 шалтгаан гэх мэт)


Тооцох арга: Тайлангийн жилд (тэргүүлэх эхний 5 шалтгаан тус бүрээр) нас барсан нийт хүний тоог 10 000-аар үржүүлж жилийн дундаж хүн амын тоонд хувааж тооцно.

## БҮЛЭГ 8. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

1995 оноос хойш хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх-судасны тогтолцооны өвчин, хавдар, гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгаан орж жил ирэх тутам эдгээр өвчний улмаас нас барсан хүний тоо нэмэгдсээр байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нас баралтын 16 192 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 731 тохиолдлоор буюу 4.3 хувиар буурсан байна. Нийт нас барсан хүний 60.1 хувь нь эрэгтэй, 39.9 хувь эмэгтэй байна. Нийт нас баралтын 3979 тохиолдол буюу 24.6 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 25.9 хувь нь хоног болоогүй нас баралт байна.

**Зураг 8.1. Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд, 2013 он**



2013 онд хүн амын нас баралтын шалтгааны 35.1 хувийг зүрх-судасны тогтолцооны өвчин, 23.4 хувийг хавдар, 17.2 хувийг гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгаан, 8.4 хувийг хоол боловсруулах тогтолцооны өвчин, 3.4 хувийг амьсгалын тогтолцооны өвчин эзэлж байгаа бөгөөд нийт нас баралтын шалтгааны 87.5 хувийг эзэлж байна. 2013 оны нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанаас авч үзвэл жилд дунджаар 5500-6000 гаруй хүн буюу нас барсан 3 хүний нэг нь зүрх-судасны тогтолцооны өвчин, 3500 гаруй хүн хавдраар, 2700 гаруй хүн буюу нас барсан 6 хүний нэг нь өвчлөл ба нас баралтын гадны шалтгааны улмаас нас барж байна.

2013 оны байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд:

- Зүрх-судасны тогтолцооны өвчин, 19.6
- Хавдар, 13.0
- Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан, 9.6
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин, 4.7
- Амьсгалын тогтолцооны өвчин 1.9 орж байна.

Хүн амын нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 69.1, 10 000 эмэгтэй хүн амд 43.4 ногдож байна. Нийт нас баралтад эрэгтэйчүүдийн нас баралтын эзлэх хувь эмэгтэйчүүдээс 1.6 дахин их байна. Нийт нас баралтын 7.2 хувь нь 1 хүртэлх насандаа, 8.9 хувь нь 5 хүртэлх насандаа, 1.1 хувийг 5-14 насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна.

ДЭМБ-аас нас баралтын хэтийн төлөвийг 2008 онд тооцоолсноор 2030 онд дэлхийн хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан нь зүрхний ишемийн өвчин, тархины судасны өвчин, уушгины архаг бөглөрөлт өвчин, амьсгалын доод замын халдварууд, замын осол гэмтэл байх тооцоо гарсан байна.

### Хүснэгт 8.1. Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 2013 он

	Нийт өвчлөл	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Хавдар	Өвчлөл ба гадны шалтгаант нас баралт	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	69.0	22.7	14.9	15.8	5.3	2.4
Эмэгтэй	43.4	16.7	11.2	3.7	4.1	1.4
<b>Насны бүлэг</b>						
20 хүртэл	16.9	0.2	0.5	3.8	0.5	2.3
20-44	23.8	4.0	2.5	11.8	2.2	0.4
45-65	116.1	41.3	35.9	17.6	11.7	2.0
65 ба түүнээс дээш	527.9	284.3	150.2	9.4	42.7	14.0
<b>Байршил</b>						
Хот	62.2	16.8	13.1	11.5	4.5	1.8
Хөдөө	60.9	22.0	13.0	8.0	4.8	2.0
<b>Бүсээр</b>						
Баруун	59.2	22.5	15.0	5.9	3.5	57.1
Хангайн	63.6	25.1	12.2	9.1	4.5	63.4
Төв	56.5	18.6	11.5	8.6	4.4	57.5
Зүүн	66.4	20.9	15.5	8.7	7.1	61.1
<b>Улсын дүн</b>	<b>55.9</b>	<b>19.6</b>	<b>13.0</b>	<b>9.6</b>	<b>4.7</b>	<b>1.9</b>

### 8.1. Зүрх-судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт

Зүрх-судасны тогтолцооны өвчний улмаас жил бүр 5 500-6 000 хүн буюу 3 хүний нэг нь нас барж байгаа бөгөөд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна.

2013 онд зүрх-судасны тогтолцооны шалтгаант нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 22.7, 10 000 эмэгтэй хүн амд 16.7 ногдож байна.

Зүрх-судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин хангайн болон баруун бүсэд өндөр, зүүн бүсийн аймгуудад бага байна.

Шалтгаанаар тооцсон зүрх-судасны өвчний шалтгаант нас баралтын түвшинг насны бүлэг, хүйсээр харьцуулбал 45-64 насны бүлгийн эрэгтэйчүүдийн дунд 10 000 хүн амд ногдох зүрхний ишемийн өвчин 23.48, тархинд цус харвалт 22.9, цусны даралт ихсэх

өвчин 1.7 ногдож байгаа бөгөөд тухайн насны эмэгтэйчүүдийн нас баралтын түвшинтэй харьцуулбал зүрхний ишемийн өвчний нас баралт 2.9 дахин, тархинд цус харвалт ын өвчний шалтгаант нас баралт 1.6 дахин өндөр, цусны даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт 2.3 дахин бага байна. (Хүснэгт 8.1.2)

Тархинд цус харвалт Монгол эрэгтэйчүүдийн нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа бөгөөд 2013 оны байдлаар 10 000 хүн амд 7.8 ногдож байгаа нь өмнөх оноос 1.2 промиллиор буурсан байна. 2003 оныг хүртэл зүрхний ишеми, тархинд цус харвалтын шалтгаант нас баралтын түвшинд байсан бол 2008 оноос хойш тархинд цус харвалтын шалтгаант нас баралт тэргүүлэх хандлага ажиглагдаж байна.

### Хүснэгт 8.1.1. Шалтгаанаар тооцсон зүрх- судасны тогтолцооны өвчний нас баралтын түвшин, 10 000 хүн амд, насны бүлгээр

	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Тархинд цус харвалт	Даралт ихсэх өвчин	Зүрхний ишеми өвчин
<b>Нийт нас баралт</b>	<b>19.6</b>	<b>6.8</b>	<b>1.1</b>	<b>8.7</b>
20 хүртэл	0.2	0.0	0.0	0.1
20-44	4.0	1.6	0.1	1.4
45-64	41.3	18.4	2.9	15.2
65-аас дээш	283.4	78.7	15.1	143.4
<b>Эрэгтэй</b>	<b>22.9</b>	<b>7.8</b>	<b>0.8</b>	<b>10.4</b>
20 хүртэл	0.2	0.0	0.0	0.1
20-44	5.6	2.2	0.2	2.1
45-64	57.5	22.9	1.7	23.5
65-аас дээш	332.7	96.0	14.4	168.9
<b>Эмэгтэй</b>	<b>16.9</b>	<b>6.0</b>	<b>1.4</b>	<b>7.3</b>
20 хүртэл	0.2	0.0	0.0	0.1
20-44	2.4	1.1	0.1	0.7
45-64	27.1	14.5	4.0	8.0
65-аас дээш	247.9	66.3	15.7	125.0

## 8.2. Хорт хавдрын шалтгаант нас баралт

Хорт хавдар өвчний шалтгаант нас баралт нь 1990 оноос хойш хүн амын нас баралтын 2 дахь тэргүүлэх шалтгаан болсоор байна.


2013 оны байдлаар хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын 23.4 хувийг эзэлж байгаа ба нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 15.0, 10 000 эмэгтэй хүн амд 11.3 ногдож байна.

Эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушиг, улаан хоолой, нойрхойн өмөн, эмэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, умайн хүзүү, улаан хоолой, уушгины хорт хавдрын нас баралт тэргүүлэх 5 шалтгаан болж байна.


2013 оны байдлаар хорт хавдартай хэмээн оношлогдсон хүн амын 75.9 хувь нь өвчнийхөө III, IV үе шатанд орсон үедээ оношлогдож, нас барсан нийт хүн амын 64.3 хувь нь анх оношлогдсоноосоо хойш 1 жил хүртлэх хугацаанд амьдарсан байна.

2010 онтой харьцуулахад хожуу оношлолтын хувь 3.2 хувиар буурч, анх оношлогдсоноосоо хойш 1 жил хүртэлх хугацаанд амьдарсан хувь 2.9 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг 8.2.1. Зонхилон тохиолдох хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойшхи амьдарсан хугацаа хувиар, 2013 он**



**Зураг 8.2.2. Зонхилон тохиолдох хорт хавдрын өвчлөл, анх оношлогдсон I-IV үе шатандаа, 2013 он**




### 8.3 Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан

Өвчлөл ба нас баралтын гадны шалтгааны улмаас нас барах тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, 1990 онд хүн амын нас баралтын 5 дахь, 2000 оноос хойш 3 дахь тэргүүлэх шалтгаан болсоор байна. 10000 хүн амд ногдох гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт нь 1995 онд 6.0, 2000 онд 7.6, 2007 онд 11.7, 2013 онд 9.6 болж 2.1 промилль-оор буурсан байна.

2013 онд Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаанаар 2 788 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 9.6 байна. Хүйсээр авч үзэхэд 79.9 хувь нь эрэгтэйчүүд, 20.1 хувь нь эмэгтэйчүүд байна. 10 000 эрэгтэй хүн амд ногдох нас баралтын түвшин 15.8 байгаа нь эмэгтэйчүүдээс 4.2 дахин их байна

**Зураг 8.3.1. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын хэлбэр, хүйсээр, 10 000 хүн амд, 2013 он**






Өвчлөл ба нас баралтын гадны шалтгааныг хэлбэрээр авч үзвэл 19.7 хувь нь зам тээврийн осол, 15.7 хувь нь амиа хорлох, 8.5 хувь нь бусдад хорлогдсон, 56.1 хувь нь бусад ослын шалтгаанаар нас барсан байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт нэмэгдэж байгаа ч 2013 онд өмнөх оноос 0.2-р болж буурсан байна. Эрэгтэйчүүдийн амиа хорлох, бусдад хорлогдох, зам тээврийн осолд өртөж амь насаа алдах явдал эмэгтэйчүүдээс их байгаа бөгөөд үзүүлэлтийг 10 000 хүн амд харьцуулан авч үзвэл: амиа хорлосон тохиолдлын тоо 6.1 дахин, хүчирхийлэл, бусдад хорлогдсон тохиолдлын тоо 3.9 дахин, зам тээврийн ослын тохиолдлын тоо 3.9 дахин их байна.

Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 10 000 хүн ам тутамд амиа хорлолт 0.5-аар нэмэгдэж, хүчирхийлэл, бусдад хорлогдсон тохиолдол 1.8, зам тээврийн ослын шалтгаант нас баралт 0.5-аар тус тус буурсан байна.

Сүүлийн жилүүдэд өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан нэмэгдэх хандлагатай байна. 2009 онд “Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх” үндэсний хөтөлбөр батлагдсан ба 2013 онд зам тээврийн ослын улмаас нас барсан тохиолдол 100 000 хүн амд 19.9 болж 2012 онтой харьцуулахад 1.0-оор буурсан байна.

**Зураг 8.3.2. Осол гэмтлийн өвчлөл, нас баралт, 10 000 хүн амд, 2003-2013 он**



### Хүснэгт 8.3.1 Дэлхийн хүн амын нас баралтын 2030 оны төлөв байдал, Монгол улсын 2013 оны нас баралтын үзүүлэлтийн харьцуулалт

2030 Өвчлөл ба гэмтэл	Нас баралт хувиар	Байр	Байр	Нас баралт хувиар	2013 Өвчлөл ба гэмтэл
Зүрхний ишеми өвчин	14.2	1	1	15.6	Зүрхний ишеми өвчин
Тархины судасны өвчин	12.1	2	2	13.9	Тархины судасны өвчин
Уушгины архаг бөглөрөлт өвчин	8.6	3	3	5.4	Элэгний хатуурал
Амьсгалын доод замын халдварууд	3.8	4	4	3.7	Ходоодны хорт хавдар
Зам тээврийн осол	3.6	5	5	3.6	Зам тээврийн осол
Гуурсан хоолой, мөгөөрсөн хоолой, уушгины хорт хавдар	3.4	6	6	2.9	Өөрийгөө санаатайгаар гэмтээх
Чихрийн шижин	3.3	7	7	2.3	Гуурсан хоолой, мөгөөрсөн хоолой, уушгины хорт хавдар
Даралт ихсэх өвчин	2.1	8	8	1.8	Даралт ихсэх өвчин
Ходоодны хорт хавдар	1.9	9	9	1.7	Сүрьеэ
ХДХВ/ДОХ	1.8	10	10	1.7	Хүчирхийлэл
Бөөрний өвчлөл	1.6	11	11	1.5	Улаан хоолойн хорт хавдар
Өөрийгөө санаатайгаар гэмтээх	1.5	12	12	1.1	Нярайн амьсгалын дутагдал, төрөлтийн гэмтэл
Элэгний хорт хавдар	1.4	13	13	0.9	Амьсгалын доод замын халдварууд
Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдар	1.4	14	14	0.9	Бөөрний өвчлөл
Улаан хоолойн хорт хавдар	1.3	15	15	0.8	Чихрийн шижин
Хүчирхийлэл	1.2	16	16	0.8	Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдар
	1.2	17	17	0.3	Хөхний хорт хавдар
Элэгний хатуурал	1.2	18	18	0.2	Суулгалт өвчин
Хөхний хорт хавдар	1.1	19	19	0.2	Хугацаанаас өмнө эсвэл бага жинтэй төрөлт
Сүрьеэ	1.0	20	20	0.2	Нярайн халдвар
Нярайн халдвар	0.9	21	21	0.1	Уушгины архаг бөглөрөлт өвчин
Хугацаанаас өмнө эсвэл бага жинтэй төрөлт	0.9	22	22	0.0	ХДХВ/ДОХ
Нярайн амьсгалын дутагдал, төрөлтийн гэмтэл	0.7	23	23	0.0	Малария
Малария	0.4	24	24		

Дэлхийн хүн амын нас баралтын 2030 он дахь нас баралтын төлөв байдлыг харахад зүрхний ишеми, тархины судасны өвчин, уушгины архаг бөглөрөлт өвчин эхний шалтгаан болж байхад 2013 оны байдлаар манай улсын нийт нас баралтад эзлэх хувиар зүрхний ишеми өвчин, тархины судасны өвчин болон элэгний хатуурал өвчний шалтгаант нас баралт тэргүүлж байна. Ялангуяа элэгний хатуурал өвчний шалтгаант нас баралт манай улсад 3 дахь шалтгаан болж байна.

## БҮЛЭГ 9. МОНГОЛ УЛСЫН ЭМИЙН БҮРТГЭЛИЙН ТАЛААР

### ТОДОРХОЙЛОЛТ

Монгол Улсын эмийн бүртгэлд эм, эмийн түүхий эдийг бүртгэснээр аюулгүй, чанарын баталгаатай эм хэрэглэх орчин бүрдэх, дотоодын зах зээлд хуурамч, дуураймал эм нэвтрэх үүд хаалгыг хаах, тэдгээрийг илрүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ач холбогдолтой.

Эмийн бүртгэл нь Монгол Улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2012 оны 41 тоот тушаалаар батлагдсан “Эм, биологийн идэвхит бүтээгдэхүүний бүртгэлийн журам” - аар зохицуулагддаг.

Хүн амын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмийн түүхий эд болон оношлуурын өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай байдлыг хангах, “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-д нийцүүлэн Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах харилцааг энэ журмаар зохицуулна.

Улсын бүртгэлд тухайн жилд эн тэргүүнд бүртгэх эмийн жагсаалтыг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн жил бүрийн нэгдүгээр улиралд ХЭЗ-ийн хурлаас баталж гаргадаг.

Хүний эмийн зөвлөл нь эм, вакцин, түүхий эдийн бүртгэлийн асуудал болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, чанарын баталгаатай, үйлдвэрлэгчээс шууд нийлүүлэгдэж байгаа Монгол улсын эмнэлгийн тусламж үйлчилгээнд чухал шаардлагатай эмийн бүртгэлийг богино хугацаанд /Түргэвчилсэн журмаар/ хэлэлцэж шийдвэрлэнэ.

Эмийг бүртгэх шийдвэрт олон улсын болон худалдааны нэршил, хэлбэр, тун, савлалтын хэмжээ, олгох нөхцөл, бүртгэлийн хүчинтэй хугацаа, үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн улсыг заана. Хуралд хэлэлцүүлсэн эм, оношлуурын тухайн шошго бүхий савлалтын хэлбэрийг улсын бүртгэлтэйд тооцох бөгөөд тус зөвлөлөөс өөрчлөлт оруулахыг зөвшөөрөөгүй өөр савлалттай эм, оношлуурыг бүртгэлд ороогүйд тооцно.

Эм, эмийн түүхий эд, оношлуурыг 5, түргэвчилсэн журмаар бүртгэсэн эмийг 3 жилийн хугацаагаар бүртгэж гэрчилгээ олгоно.


Монгол Улсын эмийн бүртгэлд 1992 оноос хойш нийт 3711 эм, эмийн түүхий эд бүртгэгдээд байна. 2014 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар 2920 эм, 110 эмийн түүхий эдийн бүртгэлийн хугацаа хүчинтэй байна. Тэдгээрийн 6,5%-ийг үндэсний үйлдвэрийн эм эзэлж байна.

2013 онд Хүний эмийн зөвлөлийн хурал 7 удаа хуралдаж 495 эм, эмийн түүхий эдийн бүртгэлийн сунгалт, 525 эмийн бүртгэлийн өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн ба шинэ бүртгэлийн 347 асуудлыг хэлэлцэж нийт 309 эм, вакцин, эмийн түүхий эд бүртгэсэн байна.


## БҮЛЭГ 9. МОНГОЛ УЛСЫН ЭМИЙН БҮРТГЭЛ

Хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэж буй эмийн чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор 1994 оноос эхлэн эмийн бүртгэл хийгдсэн байна. 2013 оны байдлаар Монгол улсын эмийн бүртгэлд 2920 нэрийн эм, 110 эмийн түүхий эд бүртгэлтэй байна. 2013 онд 309 нэрийн эм шинээр бүртгэж, 495 нэрийн эмийн бүртгэлийн хугацааг сунгаж, 525 нэрийн эмийн бүртгэлд өөрчлөлт оруулж, 5 нэрийн эмийг бүртгэлээс хассан байна.

Зураг 9.1. Бүртгэгдсэн эм, бодит тоогоор, 2013 он




Зураг 9.2. Бүртгэгдсэн эм, хувиар, 2013 он




Бүртгэгдсэн нийт эмийг олон улсын АТС /Anatomical Therapeutic classification-Хүний анатомын бүтцэд суурилсан эмийн ангилал/ кодоор ангилвал:

**Зураг 9.3. Бүртгэгдсэн эм, АТС кодоор, 2013 он**



**Зураг 9.4. Улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, Улс орнуудаар, 2013 он**



2013 оны байдлаар улсын бүртгэлд бүртгэлтэй 54 улсын 392 үйлдвэрлэгчийн 2920 нэрийн эмийн 12% нь ОХУ, 11.4% нь Энэтхэг, 8,6% нь Герман улсад үйлдвэрлэгдсэн эм эзлэж байна.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 342 дугаар тушаалаар батлагдсан зайлшгүй шаардлагатай эмийн 6 дахь жагсаалтад 328 нэрийн эм, 419 эмийн хэлбэрийг багтаасан.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” 28 дугаар тогтоолоор ерөнхий нэршлээр 134 нэрийн Зайлшгүй шаардлагатай эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 40-83.3 хувь хүртэл хөнгөлөлттэй үнээр олгож байна.

## БҮЛЭГ 10. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД

### ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлэгт Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдээс 7 хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн 5 жилийн байдлаар орууллаа.

**“Нөхөн үржихүйн эрүүл мэнд”** үндэсний хөтөлбөр нь Засгийн газрын 2012 оны 61 тоот тогтоолоор батлагдсан ба 2012 оноос 2016 онуудад хэрэгжих хөтөлбөр юм. Тус хөтөлбөрийн зорилго нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих замаар монгол хүний хөгжлийг хангах таатай орчинг бүрдүүлж, Мянганы хөгжлийн зорилтыг хангахад оршино. Тус хөтөлбөрт перинаталь эндэгдийн түвшинг /1000 амьд төрөлтөд/ 2014 оны байдлаар 16.9 хүргэнэ гэж заасан байдаг бол 2013 оны байдлаар энэ үзүүлэлт 14.4-д хүрсэн байна.

**“Халдварт өвчинтэй тэмцэх”** үндэсний хөтөлбөр нь Засгийн газрын 2011 оны 108 тоот тогтоолоор батлагдсан ба 2011 оноос 2015 онуудад хэрэгжих хөтөлбөр юм. Тус хөтөлбөрийн зорилго нь “Олон улсын эрүүл мэндийн дүрэм”-ийг хэрэгжүүлэх чадавхийг үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх, Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоход оршино. Халдварт өвчний гаралт 10 000 хүн амд 2013 оны хүрэх түвшингээс цусан суулга 2.0, сальмонеллез 0.3, А вирүст гепатит 10.1, улаанууд 3.9-оор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

**“Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх”** үндэсний хөтөлбөр 2014 оны Засгийн газрын 34 тоот тогтоолоор **“Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр”** болон батлагдан хэрэгжиж байна. Тус хөтөлбөр нь 2014-2021 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжих ба гол зорилго нь хувь хүн, гэр бүл, байгууллага хамт олонд эрүүл аж төрөх дадал, зан үйлийг төлөвшүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зонхилон тохиолддог халдварт бус өвчний хяналт, тандалт, менежментийг сайжруулах замаар урьдчилан сэргийлэх боломжтой халдварт бус өвчний өвчлөл, чадвар алдалт, цаг бусын эндэгдлийг бууруулах орчин бүрдүүлэхэд оршиж байна.

Хөтөлбөрийн хүрээнд хүн амын тамхины хэрэглээний хувийг одоо байгаа түвшингээс 4-5 хувиар бууруулах, 10 000 хүн амд харьцуулсан хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 1.4-2.5-аар, зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралтыг 0.4-2.2-оор бууруулах зорилттой юм.

## “НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Үзүүлэлт	Агуулга
Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	Засгийн газрын 2012оны 61 дүгээр тогтоол
Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа	2012-2016 он
Гол зорилт	Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих замаар монгол хүний хөгжлийг хангах таатай орчинг бүрдүүлж, Мянганы хөгжлийн зорилтыг хангахад оршино.

Шалгуур үзүүлэлт	Эх сурвалж ба шалгуурын мөн чанар	Хүрэх түвшин			2013 оны түвшин	
		Суурь үзүүлэлт	2014	2016		
<b>1. Эхийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд</b>						
1.1	Эхийн эндэгдлийн түвшин /100 000 амьд төрөлтөд /	ЭМСҮ	45.5 (2010)	44.0	40.0	42.6
1.2	Перинаталь эндэгдийн түвшин /1000 амьд төрөлтөд/	ЭМСҮ	16.9 (2010)	16.9	16.9	14.4
1.3	Жирэмсний хяналтад байх хугацаандаа 6 болон түүнээс дээш удаа үзүүлсэн жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь	ЭМСҮ	93.7(2010)	99.0	99.5	91.7
1.4	Эмнэлэгт төрсөн эхчүүдийн эзлэх хувь	ЭМСҮ	99.0 (2010)	99.3	99.5	99.2
1.5	Жирэмсний хяналтад эрт орсон голч хугацаа	судалгаа	2.9 (2008)	2.6	2.1	-
1.6	Эхийн эндэгдэлд халдварт өвчний шалтгаант нас баралтын эзлэх хувь	судалгаа	23.3(2010)	20.0	18.0	-
1.7	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн чухал 10 эмийн нөөцтэй үйлчилгээ үзүүлэх цэг	судалгаа	76.0(2010)	85.0	90.0	-
1.8	Эхчүүдийн амрах байранд амарвал зохих эхчүүдээс амрах байраар үйлчлүүлсэн эхчүүдийн эзлэх хувь	ЭМСҮ	78.0( 2010)	80.0	75.0	74.0
<b>2. Гэр бүл төлөвлөлтийн үзүүлэлт:</b>						
2.1	Гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн аргын хэрэглээний хувь	ЭМСҮ	53.4 (2010)	54.0	55.0	55.0
2.2	Гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээний хувь	судалгаа	13.9(2008)	10.0	7.5	-
2.3	Жирэмслэхээс хамгаалах орчин үеийн гурваас доошгүй эм хэрэгслийг санал болгодог болсон эмнэлгийн эзлэх хувь	судалгаа	93.5(2010)	94.0	95.0	-
<b>3. Аюултай үр хөндөлтөөс сэргийлэх үйл ажиллагааны үзүүлэлт:</b>						
3.1	Үр хөндөлт (1000 амьд төрөлтөд)	ЭМСҮ	18.6(2010)	180	160	195.8
3.2	Нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд ноогдох үр хөндөлт	ЭМСҮ	14.8(2010)	12.0	10.0	18.4
3.3	Үр хөндөлтийн өмнөх болон дараах зөвлөгөөг өгдөг байгууллагын эзлэх хувь	судалгаа	72.2(2010)	90.0	100.0	-
<b>4. Бэлгийн замаар дамжих халдварын хяналт ба урьдчилан сэргийлэлтийн үзүүлэлт:</b>						
4.1	Сүүлийн удаа бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн 15-24 насны залуусын хувь	судалгаа	58.6(2007)	63	65	-
4.2	Халдвар дамжих замыг зөв нэрлэсэн,буруу ойлголтыг үгүйсгэж чадсан 15-24 насны залуусын хувь	судалгаа	24.5(2007)	45.0	48.0	-
4.3	Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэлтэд хамрагдсан эмэгтэйн эзлэх хувь	судалгаа	тогтооно	50.0	70.0	-
<b>5. Бэлгийн боловсролын үзүүлэлт :</b>						
5.1	15-19 насны охидын төрөлтийн түвшин /эзлэх хувь /	ЭМСҮ	6.0(2010)	5.5	5.0	5.5
<b>6. Хүчирхийллээс сэргийлэх ба үйлчилгээний үзүүлэлт:</b>						
6.1	Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь	судалгаа	тогтооно	жил дараалан бууруулна		-
6.2	Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо /Өссөн дүнгээр /	ЭМСҮ	4(2011)	5.0	7.0	-



## “ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Үзүүлэлт	Агуулга
Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	2011 оны 108-р тогтоол
Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа	2011-2015 он
Гол зорилт	"Олон улсын эрүүл мэндийн дүрэм"-ийг хэрэгжүүлэх чадавхийг үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх, Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох

№	Шалгуур үзүүлэлт	2010 оны суурь үзүүлэлт	Хүрэх үр дүнгийн үзүүлэлт (оноор)								
			2011 онд хүрэх түвшин	2011 оны түвшин	2012 оны түвшин	2012 оны хүрсэн түвшин	2013 оны түвшин	2013 оны хүрсэн түвшин	2014 оны түвшин	2015 оны түвшин	
1	Халдварт өвчний дэгдэлтийн үед шуурхай хариу арга хэмжээ авах талаар сургагдсан баг	15	20	34	30	34	40	34	50	60	
2	Халдварт өвчний дэгдэлтийн голомтод 24-48 цагийн дотор хариу арга хэмжээ авсан тохиолдол	40	55	88	70	88	75	85	80	85	
3	Халдварт өвчний хамшинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдлын оношийн лабораторийн баталгаажилт	40	45	68.4	50	68.4	60	70	70	80	
4	Эрсдэлийн үеийн харилцаа холбооны чиглэлээр сургагдсан мэргэжилтэн	50	100	123	150	150	200	150	250	300	
5	Шинэ болон сэргэж байгаа халдварт өвчний дэгдэлт, томуугийн цартахлын үед хариу арга хэмжээ авах талаар хамтран хийсэн үзүүлэх сургууль	3	5	6	5	5	10	8	10	15	
6	Халдварт өвчний дэгдэлтийн үеийн харилцаа холбооны чиглэлээр сургагдсан баг	-	5	34	10	34	15	23	20	20	
7	Халдварт өвчний үед хэрэглэх хувийн хамгаалах хэрэгслээр хангагдсан эрүүл мэндийн байгууллага	10	20	28	30	30	40	35	60	80	
8	Лабораторийн сорьц цуглуулах багцаар хангагдсан эрүүл мэндийн байгууллага	10	20	20	30	30	40	37	60	80	
9	Халдварт өвчний оношилгооны чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн лаборатори	2	4	2	5	5	6	5	7	8	
10	Халдварт өвчний оношлогоонд нэвтэрсэн молекул-биологийн шинжилгээний арга	1	2	4	3	3	4	9	5	6	
11	Олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтын сүлжээнд хамрагдсан лаборатори	2	3	1	4	4	6	6	6	6	
12	В вирус гепатитаас сэргийлэх вакцин хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн	5	20	9	30	30	40	36	50	60	
13	Томуугийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн	10	20	25	30	30	40	55	50	60	
14	Эмнэлгийн ажиллагсдын халдварт өртсөн байдлыг тогтмол мэдээлдэг эрүүл мэндийн байгууллага	6	15	21	25	25	40	35	50	60	
15	Цус, цусан бүтээгдэхүүний эргэх талоньг хэрэглэж хэвшсэн эрүүл мэндийн байгууллага	-	20	21	40	40	60	51	80	100	
16	Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, оношлогоо, эмчилгээний талаар хийсэн судалгаа	9	12	14	15	12	17	16	20	22	
17	Халдварт өвчний тандалт, хариу арга хэмжээний талаар хийсэн дэмжлэгт хяналт	10	20	28	30	30	40	32	50	60	
18	Шинээр нэвтрүүлсэн	Вакцин	-	-	-	-	0	1	-	1	
		Биобэлдмэл	-	1	-	1	1	1	1	1	
		Оношлуур	-	1	-	1	1	1	1	1	
19	Халдварт өвчин 10.000 хүн амд (промилиэр)	Цусан суулга	11.2	11.0	7.6	10.0	7.4	9.0	7.0	9.0	9.0
		Сальмонеллэз	0.8	0.6	0.4	0.6	0.4	0.6	0.3	0.6	0.5
		А вирус гепатит	33.8	21.0	49.0	21.0	21.2	15.8	5.7	13.0	10.0
		Улаанбурхан	0.1	0.0	-	-	0.0	-	0.0	-	-
		Улаанууд	5.9	5.0	0.1	4.5	0.8	4.0	0.1	3.5	3.0
		Гахай хавдар	7.9	7.5	3.7	7.0	32.6	7.0	18.7	6.5	6.0
20	Сүрьеэгийн нас баралт (100.000 хүн амд)	2.5	2.3	2.2	2.1	2.1	1.9	2.0	1.7	1.5	
21	Түрхэц эерэг сүрьеэгийн тохиолдлын илрүүлэлт	83.7	84	74.1	84.3	74.1	84.5	57.0	84.7	85.0	
22	Түрхэц эерэг сүрьеэгийн шинэ тохиолдлын эдгэрэлт	83.4	83.8	83	82.7	82.7	84.4	80.1	84.7	85.0	
23	ХДХВ-ийн халдварыг илрүүлэх шинжилгээ хийлгэсэн сүрьеэтэй өвчтөн	35	43	90.6	51	90.6	59	60.4	67	75	
24	Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд дахь тэмбүүгийн тархалт (судалгаагаар)	1.7	-	-	1.3	-	-	1.1	-	-	

## “ОСОЛ, ГЭМТЭЛ, ХҮЧИРХИЙЛЛЭЭС СЭРГИЙЛЭХ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Үзүүлэлт	Агуулга
Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	2009 оны 279-р тогтоол
Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа	I үе шат 2010-2012 он, II үе шат 2013-2016 он
Гол зорилт	Хүн ам осол, гэмтлийн улмаас тахир дутуу болох, хөдөлмөрийн чадвар алдах, нас барах явдлыг бууруулах

№	Шалгуур үзүүлэлт	2008 оны түвшин	2009 оны түвшин	2010 оны түвшин	2011 оны түвшин	2012 онд түвшин	2013 оны хүрсэн түвшин
1	Зам, тээврийн ослын улмаас нас барсан тохиолдол/100000 хүн амд/	18.7	15.8	17.8	19.7	20.9	19.9
2	Хүүхдийн осол гэмтлийн тохиолдол/10000 хүн ам тутамд/	78.1	84.3	94.3	96.4	99.4	124.4
3	Түлэгдэл/10000 хүн амд/	22.7	23.5	26.9	30.2	29.2	35.1
4	Гэмтэл согог, судлалын кабинеттэй аймгийн тоо	14	11	11	11	12	15
5	Гэмтэл согогын тусламж, үйлчилгээний ор гаргаагүй аймгийн тоо	11	11	11	10	9	6
6	Гэмтэл, согог судлалын эмчгүй аймгийн тоо	5	4	3	3	2	3

## “АМЬДРАЛЫН БУРУУ ХЭВШЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Үзүүлэлт	Агуулга
Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	2014 оны 2 дугаар сарын 7-ны 34 дугаар тогтоол
Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа	2014-2021 он
	Нэгдүгээр үе шат-2014-2017 он
	Хоёрдугаар үе шат-2017-2021 он
Гол зорилт	Хувь хүн, гэр бүл, байгууллага хамт олонд эрүүл аж төрөх дадал, зан үйлийг төлөвшүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зонхилон тохиолддог халдварт бус өвчний хяналт, тандалт, менежментийг сайжруулах замаар урьдчилан сэргийлэх боломжтой халдварт бус өвчний өвчлөл, чадвар алдалт, цаг бусын эндэгдлийг бууруулах орчин бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

№	Шалгуур үзүүлэлт	Эх үүсвэр	2013 оны түвшин	Хүрэх үзүүлэлт	
				2017 он	2021 он
<b>I. Хүний зан үйлтэй холбоотой халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлсийн үзүүлэлт:</b>					
1	Хүн амын тамхины хэрэглээ, хувиар	*	27.1	27	21.7
2	Сүүлийн 30 хоногт тамхийг 1-2 удаа хэрэглэсэн 13-15 насны хүүхэд, хувиар	**	5.9	5.4	4.9
3	Сүүлийн 30 хоногт тамхийг 1-2 удаа хэрэглэсэн 16-17 насны хүүхэд, хувиар	**	17.5	16	14.5
4	Сүүлийн 30 хоногт ажлын байрандаа тамхины утаанд өртөгсөд, хувиар	*	25.5	23.4	21.3
5	15-аас дээш насны нэг хүнд ногдох бүртгэгдсэн согтууруулах ундаа, литр (архинд шилжүүлснээр)	*****	9.8	8.8	7.9
6	Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэгчид, хувиар	*	10.3	10	9.6
7	Согтууруулах ундааг 1-2 удаа хэтрүүлэн хэрэглэж үзсэн сурагчид, 15-17 нас, хувиар	**	23.1	22.3	21.6
8	25-64 насны хүн амын давсны хоногийн дундаж хэрэглээ (гр/хоног)	****	11.1	10	8.9
9	Жимс, ногоог хоногт 5 нэгж (400гр) хэрэглэж чадахгүй байгаа хүн ам, хувиар	*	96.4	88.4	80.3
10	Хөдөлгөөний хомсдолтой хүн ам, хувиар	*	22.3	21.6	20.8
<b>II. Хүний зан үйлтэй холбоотой халдварт бус өвчний хоёрдогч эрсдэлт хүчин зүйлсийн үзүүлэлт:</b>					
1	Илүүдэл жин, таргалалттай хүн амын эзлэх хувь (БЖИ $\geq 25\text{кг/м}^2$ )	*	54.4	49.9	45.3
2	Цусны даралт ихсэлт (артерийн дээд даралт $\geq 140$ , доод даралт $\geq 90$ ба даралт бууруулах эм хэрэглэж байгаа)-ийн тархалт, хувиар	*	27.5	25.2	22.9
3	Цусан дахь нийт холестерин хэмжээ 5 ммол/л ба түүнээс их хүн амын эзлэх хувь	*	61.9	56.7	51.9
4	Захын цусан дахь глюкозын хэмжээ 5.6-6.0 ммол/л байгаа хүн амын эзлэх хувь	*	8.3	7.6	6.9
5	Цусан дахь глюкозын хэмжээ ихэссэн (6.1 ммол/л ба түүнээс их), глюкоз бууруулах эм хэрэглэж байгаа хүн ам, хувиар	*	6.9	6.3	5.8
<b>III. Хүний зан үйлтэй холбоотой халдварт бус өвчний эрт илрүүлэлт, өвчлөлийн үзүүлэлт:</b>					
1	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (30-60 нас)	***	41.6	61	80.4
2	Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (30-60 нас)	***	33.1	55.4	77.8
3	Артерийн гипертензийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (40-64 нас)	***	38.5	59	79.5
4	Чихрийн шижингийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (40-64 нас)	***	32.5	55	77.5
<b>IV. Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл, нас баралтын үзүүлэлт:</b>					
1	Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10 000 хүн амд)	***	13.0	11.6	10.5
2	Зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралт (10000 хүн амд)	***	19.6	19.2	17.4

## “ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД” ХӨТӨЛБӨР

Үзүүлэлт	Агуулга
Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	2005 оны 245 дугаар тогтоол
Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа	2006-2015 он
	Нэгдүгээр үе шат-2006-2010 он
	Хоёрдугаар үе шат-2010-2015 он
Гол зорилт	Хүрээлэн буй орчныг бохирдуулж байгаа хүчин зүйлсийг багасгах, орчны эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг сайжруулах замаар хүн амыг эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

№	Шалгуур үзүүлэлт	2006 оны түвшин	2007 оны түвшин	2009 оны түвшин	2010 оны түвшин	2011 оны түвшин	2012 оны түвшин	2013 оны түвшин
<b>I</b>	<b>Гэдэсний халдварт өвчин /10 000 хүн амд/</b>							
1	Балнад	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	Сальмонеллэз	0.0	0.7	0.5	0.5	0.4	0.4	0.3
3	Цусан суулга	7.3	9.2	11.7	12.5	7.6	7.4	7.0
4	Вирүст хепатит А	21.7	34.2	22.1	29.4	49.0	21.2	5.7
<b>II</b>	<b>Амьсгалын дээд замын үрэвсэлт өвчин /10 000 хүн амд/</b>							
1	Цочмог төвөнхтөс, мөгөөрсөн хоолойтос	33.25	40.57	49.7	56.7	46.9	46.5	53.5
2	Гуурсан хоолойн багтраа	14.46	15.8	20.1	19.8	19.1	20.0	18.9

## “СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХОЁР ДАХЬ ХӨТӨЛБӨР

Үзүүлэлт	Агуулга
Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	2009 оны 303 дугаар тогтоол
Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа	2010-2019 он
	Нэгдүгээр үе шат-2010-2014 он
	Хоёрдугаар үе шат-2015-2019 он
Гол зорилт	Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны болон нийгэм хамт олонд тулгуурласан тусламж, үйлчилгээг өргөжүүлэх замаар сэтгэц, зан үйлийн эмгэгийн тархалтыг бууруулах нөхцөл бүрдүүлэхэд оршино.

№	Шалгуур үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014 онд
		оны түвшин	оны түвшин	оны түвшин	оны түвшин	оны түвшин	хүрэх түвшин
<b>Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож хүртээмж, чанарыг сайжруулах талаар</b>							
1	Сэтгэцийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн орны тоо (10000 хүн амд)	2.2	2.2	2.2	2.2	2.1	10 хувиар буурна
2	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн орны тоо (10000 хүн амд)	0.6	0.6	0.6	0.6	0.6	10 хувиар нэмэгдэнэ
3	Нийгэм хамт олны дунд ажиллаж байгаа гэр төвийн тоо	12	12	14	14	14	14
4	Аймаг, дүүргийн сэтгэцийн эмчийн тоо (10000 хүн амд)	0.1	0.1	0.43	0.4	0.4	0.25
5	Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний талаарх сургалтад хамрагдсан сум, өрхийн эмчийн эзлэх хувь	25.0	32.0	32.0	25.0	25.0	60.0
6	Анагаах ухааны болон сувилахуйн сургалтын хөтөлбөрт сэтгэцийн эрүүл мэндийн хичээлийн цагийн эзлэх хувь	5.0	5.5	5.5	5.5	2.7	10.0
7	Зайлшгүй шаардлагатай эмийн үндэсний жагсаалтад орсон сэтгэц нөлөөт эмээр хангагдсан аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эмнэлгийн эзлэх хувь	86.0	41.0	45.0	41.0	20.0	95.0

## “АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ МЭНД” ХӨТӨЛБӨР

Үзүүлэлт	Агуулга
Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	2006 оны 150 дугаар тогтоол
Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа	2006-2015 он
	Нэгдүгээр үе шат-2006-2010 он
	Хоёрдугаар үе шат-2011-2015 он
Гол зорилт	Шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлийн хяналт, тандалтыг сайжруулах, шүд амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянаж сайжруулах, эрүүл зан үйл төлөвшихөд дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, нийгэм, хамт олонд тулгуурласан амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх замаар хүн амын шүд цоорох өвчний тархалтыг бууруулах

№	Шалгуур үзүүлэлт	2004 оны түвшин	2010 оны түвшин	2011 оны түвшин	2015 оны түвшин	
<b>Шүд цоорлын тархалт, эрчим</b>						
1	Шүд цоорлын тархалт	5-6 настай хүүхдүүдийн дунд	80.1	79.0	89.3	78.0
2		12 настай хүүхдүүдийн дунд	62.0	61.0	65.3	60.0
3		Нийт хүн амын дунд	71.6	71.0	69.9	70.0
4	Шүд цоорлын эрчим	5-6 настай хүүхдүүдийн дунд	4.6	4.5	6.9	4.3
5		12 настай хүүхдүүдийн дунд	1.9	1.9	2.3	1.8
6		Нийт хүн амын дунд	3.1	3.0	69.9	2.8
7	3.18 настай хүүхдийн дунд бүрэн шүдтэй хүүхдийн эзлэх хувь		67.5	70.0	69.9	72.5

**Тайлбар:** Улаанбаатар хоын хүүхэд, залуусын амны хөндийн өвчлөлтийн судалгаа, 2011 он . ШЭНЭСТ, ЭМШУИС-НАСС

# БҮЛЭГ 11. ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн мэдээний санд орох Монгол Улсын үзүүлэлтүүд, 2013

I Хүн ам зүйн үзүүлэлтүүд		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	он	
1	Газар нутгийн хэмжээ (1 000 км <sup>2</sup> )	1 567.00	...	...	2013	
2	Хүн амын тоо ('000)	2 930.3	1 504.5	1 425.8	2013	
3	Хүн амын тоо насны бүлгээр (%)					
	- 0–4 нас	10.9	10.4	11.4	2013	
	- 5–14 нас	16.5	15.9	17.1	2013	
	- 60 ба түүнээс дээш нас	5.8	6.5	5.1	2013	
	- 65 ба түүнээс дээш нас	3.8	4.3	3.3	2013	
	- 80 ба түүнээс дээш нас	1.3	0.9	1.7	2013	
4	Хүн амын цэвэр өсөлт (%)	2.2	...	...	2013	
5	Хотын хүн ам (%)	68.1	67.0	69.2	2013	
6	Төрөлтийн түвшин (1000 хүн амд)	27.5	...	...	2013	
7	Нас баралтын түвшин (1000 хүн амд)	5.6	6.9	4.3	2013	
8	Төрөлтийн нийлбэр коэффициент (15–49 насны эмэгтэйчүүд)	3.0	...	...	2013	
9	Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын хувь	97.8	98.0	97.5	2000	
10	Одоогийн зах зээлийн ханшаар нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт (US\$)	3335	...	...	2012	
11	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний үнийн өсөлт (%)	30.2	...	...	2012	
12	Бүртгэгдсэн нас баралт (%)					
II Эрүүл мэндийн байгууллагын тоо /эмнэлэг/		Бүгд	Улсын	Хувийн	он	
1	Эрүүл мэндийн байгууллагын тоо	1665	646	1019	2013	
2	Эрүүл мэндийн төвүүд	511	511		2013	
3	Дүүргийн эмнэлгүүд	12	12		2013	
4	Аймгийн нэгдсэн эмнэлэг	16	16		2013	
5	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Төв эмнэлэг тусгай мэргэжлийн төвүүд	5	5		2013	
6	Эмнэлгийн орны тоо	19860	16031	3829	2013	
III Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар		Бүгд	Улсын	Хувийн	он	
3	Нэг иргэний жилд үзүүлсэн дундаж тоо	5.7	5.1	0.6	2013	
